



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-60

1.Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан 2025.05.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	5-28
2.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүн 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	29-60

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
06 дугаар сарын 13-ны өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 73 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 11 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баттулга, Ш.Бямбасүрэн, Ж.Ганбаатар;
Чөлөөтэй: Ж.Баярмаа, Х.Булгантуяа, Л.Мөнхбаатар, Л.Оюун-Эрдэнэ, М.Энхцэцэг;

Эмнэлгийн чөлөөтэй: М.Мандхай, Б.Тулга, Л.Энхнасан, Д.Энхтүвшин;
Тасалсан: Н.Алтанхуяг, А.Ганбаатар, Л.Гантөмөр, С.Лүндэг, С.Одонтуяа, Ж.Энхбаяр;

Хоцорсон: Н.Алтаншагай-42 минут, С.Амарсайхан-1 цаг 31 минут, О.Амгаланбаатар-17 минут, Т.Аубакир-23 минут, Ц.Баатархүү-38 минут, М.Бадамсүрэн-2 цаг 01 минут, Б.Батбаатар-03 минут, Р.Батболд-03 минут, О.Батнайрамдал-1 цаг 58 минут, П.Батчимэг-51 минут, Ж.Бат-Эрдэнэ-02 минут, Ж.Баясгалан-22 минут, С.Бямбацогт-24 минут, С.Ганбаатар-1 цаг 07 минут, Д.Ганбат-50 минут, Т.Доржханд-1 цаг 06 минут, Б.Жавхлан-2 цаг 58 минут, Х.Жангабыл-03 минут, Б.Жаргалан-20 минут, Д.Жаргалсайхан-1 цаг 01 минут, Ж.Золжаргал-01 минут, Г.Лувсанжамц-1 цаг 35 минут, Б.Мөнхсоёл-01 минут, Ц.Мөнхтуяа-1 цаг 24 минут, Б.Найдалаа-10 минут, П.Наранбаяр-1 цаг 28 минут, Н.Номтойбаяр-25 минут, Э.Одбаяр-1 цаг 03 минут, Б.Пунсалмаа-15 минут, О.Саранчулуун-24 минут, Г.Тэмүүлэн-09 минут, А.Ундраа-1 цаг 07 минут, Н.Учрал-39 минут, Г.Уянгахишиг-2 цаг 15 минут, Д.Цогтбаатар-1 цаг 37 минут, Ж.Чинбүрэн-14 минут, Б.Чойжилсүрэн-14 минут, Л.Энх-Амгалан-1 цаг 45 минут, Б.Энхбаяр-39 минут, Р.Эрдэнэбүрэн-2 цаг 59 минут.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д “Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол Зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ.” гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 11 гишүүн 2025.06.10-ны өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 40 гишүүн 2025.06.12-ны өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд хуваарилсныг мэдээлэв./10:02/

Нэг.Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан 2025.05.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийслэлийн хот байгуулалт, хотын стандартын газрын Ерөнхий архитекторын ажлын албаны дарга А.Баттөмөр, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх С.Сайнбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 10 цаг 15 минутаас хуралдааныг даргалав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Б.Уянга, Д.Рэгдэл, С.Эрдэнэбат, Д.Пүрэвдаваа, Г.Хосбаяр, М.Ганхүлэг, Д.Ганмаа, О.Номинчимэг, Ж.Золжаргал, Ж.Галбадрах, О.Саранчулуун, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Нийслэлийн хот байгуулалт, хотын стандартын газрын Ерөнхий архитекторын ажлын албаны дарга А.Баттөмөр, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх С.Сайнбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./11:33/

Уг асуудлыг 11 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүн 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын даргын зөвлөх Н.Отгончимэг, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, мөн яамны Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн дарга Ш.Цолмон нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, мөн албаны референт Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Х.Баасанжаргал, С.Эрдэнэбат, А.Ариунзаяа, Н.Наранбаатар, Ж.Золжаргал, Б.Жаргалан, Ц.Баатархүү, П.Батчимэг, Ж.Батжаргал, П.Сайнзориг, Л.Соронзонболд нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын даргын зөвлөх Н.Отгончимэг, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, мөн яамны Захиргааны хэм хэмжээний актын хяналт бүртгэлийн хэлтсийн дарга Ш.Цолмон нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./13:20/

Уг асуудлыг 13 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 10 минут үргэлжилж, 126 гишүүнээс 108 гишүүн хүрэлцэн ирж, 85.7 хувийн ирцтэйгээр 13 цаг 21 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр,
Баасан гараг Төрийн ордон “Их хуралдай” танхим 10 цаг 11 минут.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтгая. 65 гишүүн бүртгэгдэж, ирц 51.6 хувьтай болсон байна. 2025 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сарын 13-ны өдрийн нэгдсэн хуралдаан эхэлснийг мэдэгдье. Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хоёрдугаарт, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороонд хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад байнгын хороог тогтоож нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

Нэгдүгээрт, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин нарын 11 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн Төрийн байгуулалтын байнгын хороонд хуваарилсан,

2.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин нарын 40 гишүүн 2025 оны 6 сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн Төрийн байгуулалтын байнгын хороонд хуваарилсан.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё. Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Алдаржавхлан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсад хот байгуулалтын тухай хууль 1998 онд анх батлагдаж улмаар 2008 онд шинэчлэн батлагдсан байдаг юм аа. Энэхүү хууль нь тухайн үеийн нөхцөл байдал, төвлөрөл багатай, хүн амын байршлыг харгалзан үзэж хот байгуулалтын үйл ажиллагааг ерөнхий төлөвлөлт зураг төслийн түвшинд ерөнхий архитектурт төвлөрүүлэн шийдвэрлэдэг зохицуулалттай хэрэгжиж эхэлсэн байдаг аа. Сүүлийн 20 гаруй жил Улаанбаатар хотын хүн ам 2 дахин нэмэгдсэн. Хот төлөвлөлтийн хариуцлага бүхий эрх зүйн зохицуулалт нь цаг үеийн шаардлагаа хангахаа больсон гэж үзэж байгаа юм аа. Үүний улмаас сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ муудаж, нийгмийн үйлчилгээ, ногоон байгууламж зэрэг суурь дэд бүтцийн хангамж алдагдаж иргэдийн амьдрах орчинд сөргөөр нөлөөлж байна аа.

Хот байгуулалтын тухай болон тухайн цаг үеийн нөхцөлд нийцүүлэн хот төлөвлөлтийн эрх зүйн үндсийг тодорхойлсон боловч хүн амын төвлөрөл хотжилтын эрчимтэй өөрчлөлтөд дасан зохицож шинэчлэгдээгүй нь өнөөгийн хүртээмжгүй, зохион байгуулалтгүй төлөвлөлтийн суурь шалтгаан болсон гэж үзсэн. Энэ бүхний үр дагаварт хүүхдийн сурч боловсрох эрх хамгийн ихээр зөрчигдөж байна аа.

Бидний хувьд хүртээмжтэй, чанартай боловсролын талаар олон асуудлыг хөндөж ярьдаг ч түүнийг бүрдүүлэх шаардлага эрх зүйн орчныг орхигдуулсан байгаа юм аа. Үүний улмаас сургууль, цэцэрлэггүй, сургууль, цэцэрлэгийг төлөвлөсөн ч түүнийг хэрэгжүүлдэггүй төлөвлөлтүүд нийслэл хотод маш их байна аа. Жишээлбэл БГД-т байрладаг Алтай хотхон 2008 онд ашиглалтад орсон боловч 5200 өрхтэй, 16 мянга орчим хүнтэй боловч нэг ширхэг ч сургууль цэцэрлэгийг барьж байгуулаагүй байгаа юм аа. Энэ хотхон сургууль цэцэрлэгийн асуудлыг бүрэн орхигдуулсан жишээ байна аа.

Мөн Эрин, Хархорин зэрэг хотхонд сургуулийн насны 3500 хүүхэд байгаа ч улсын сургууль цэцэрлэг огт байхгүйгээр ашиглалтад оржээ. Хамгийн сүүлийн жишээ Хан-Уул дүүрэг Кинг Товер хотхон 2 мянган өрхтэй, 5794 хүн амтай, сургуулийн насны 2 мянга орчим хүүхэдтэй, цэцэрлэгийн насны мянга орчим хүүхэд байгаа ч нэг ширхэг сургууль, цэцэрлэг төлөвлөгөөг орхигдуулсан байгаа юм аа. Ийм жишээ дурдвал маш олноор хэлж болно оо.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан Улаанбаатар хотын нийт өрх түүнд ноогдож байгаа хүүхдийн дундаж үзүүлэлтийн талаарх статистик тоон мэдээллийг харахад мянган өрх тутамд 18 хүртэлх насны 2600 хүүхэд байгаа юм аа. Мөн 250 өрх тутам зургаа хүртэлх насны цэцэрлэг насны 400 орчим хүүхэд ноогдож байна аа.

Иймд миний хувьд дээрх асуудлыг шийдвэрлэх суурь эрх зүйн орчныг бүрдүүлэх буюу хэсэгчилсэн төлөвлөлтийг боловсруулах, батлуулахдаа сургууль, цэцэрлэгийн хүртээмжийн асуудлыг өрхийн тооттой шууд уялдаатай зайлшгүй тооцож эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор дараах хуулийн төслүүдийг санаачлан боловсрууллаа.

Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт

оруулах тухай мөн Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай 5 хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Уг хуулийг төслийг хэлэлцэн шийдвэрлэж хүсье ээ.

Б.Пүрэвдорж: Жуковын Алдаржавхлан гишүүнд баярлалаа. Гишүүддээ энэ өдрийн мэндийг өргөн дэвшүүлье.

Төслүүдийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүн танилцуулна аа. Индэрт урья

С.Цэнгүүн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангаас 2025 оны 5 дугаар сарын 02-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хот байгуулалтын тухай шинэчилсэн найруулгад нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Хууль санаачлагчийн зүгээс хот байгуулалт, барилгажилт, газар олголтын талаар авч байгаа зөрчлийг арилгах, иргэдийн эрүүл, аюулгүй таатай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хот суурин газарт орон сууцын төлөвлөлтийг хийхдээ эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг оновчтой тооцож төлөвлөх эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор Хот байгуулалтын тухай шинэчилсэн найруулга нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төслийг D parliament.mn цахим сайтад байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байна аа. Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуугаагүй бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн орон сууцын хотхон хорооллыг сургууль цэцэрлэгтэй байхаар төлөвлөх болон орон сууцын гадна авто зогсоол явган хүний зам ногоон байгууламжийн төлөвлөлтийн стандартын талаарх хуулийн зохицуулалтыг заавал биелүүлэх шинж чанартайгаар боловсруулсныг дэмжиж байгаа талаар Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг сүүлийн жилүүдэд хот төлөвлөлт алдагдсанаар энэ хуулийн хүрээнд хүний эрхийн талаас нь засаж залруулах боломжтой, Газрын тухай хууль, хот байгуулалтын тухай хуулийг иж бүрнээр нь боловсронгуй болгож цаашид газрын эдийн засгийн эргэлтэд оруулах баримтлах эрэмбэ дэс дараалал, суурь зарчмыг тогтоох эхний алхмуудыг зохицуулах энэхүү хуулийн төслийг дэмжиж байгаа талаар саналаа илэрхийлсэн болно оо.

Байнгын хорооны хуралдааны хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хот байгуулалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Б.Пүрэвдорж: Саруулсайханы Цэнгүүн гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Нэг хүн байгаа юм байна. Сүрэнхүүгийн Сайнбаяр Улсын Их Хурлын гишүүний зөвлөх.

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчдын илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж хариулт авна аа.

Би хуралдаан даргалж байгаа учраас асуултаа хойшлууллаа. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууя. Микрофоныг нь шинээр өгье.

С.Эрдэнэболд: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе ээ. Ер нь энэ бол энэ Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамцын яг хэлж байгаа хот байгуулалттай холбоотой бас яг энэ суурь асуудлууд, нөгөө талаасаа энэ шинэ үеийн хот, шинэ үеийн энэ метрополитон соёлын талаар энэ Хархорины ажлын хэсэг эд нар дээр хэлж байгаа мөн Анар гишүүний хэлж байгаа. Энэ Улсын Их Хурлын энэ шинэ гишүүдийн яг энэ асуултад мэргэжлийн хандаж байгаа зүйлүүд дээр би талархалтай байгаа. Тэгээд яах вэ нэг ийм 2-оос 3 ийм тусгал байгаад байгаа юм. Яг одоо манай улсын хүн амын талаас илүү хувь нь Улаанбаатар хотод оршин сууж байгаа. Мэдээж хотын асуудал гэдэг бол зөвхөн барилга байгууламж гэхээсээ илүүтэйгээр энэ бол хүний амьдралын таатай орчны дэд бүтэц талаас нь хармаар байгаа юм аа.

Сая тэр Байнгын хорооны хурал дээр Дамдинням гишүүн бас яг хэлж байна лээ. Хуучин зүгээр явдаг байсан скүтерийн, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тусгай хэрэгцээт зам нь одоо маш хэцүү болчихсон. Стандарт дордоод байгаа ийм нөхцөлүүд байгаа. Тэгэхээр ер нь бол яг энэ хуулийн агуулга дээр хүний эрхийн бид нар бол эдийн засаг талаасаа бол 20 минутын хот ч гэдэг юм уу одоо бол 2 цагийн хотыг яаж 20 минут руу оруулах вэ гэдэг агуулга яриад байгаа бол энэ бүх стандартдаа энэ бүх хэмжүүрдээ хүний эрх гэдэг энэ зүйлийг тавимаар байгаа юм аа. Парламент өнгөрсөн 11 сарын хорьдоор хүн төвт 5 тулгуурт бодлогыг хэрэгжүүлнэ гээд ингээд заагаад өгчихсөн. Тэрнээс хойших олон шийдвэрүүд дээр харлаа бид нар энийгээ тэр болгон сайн баримталж чадахгүй байна.

Одоо ингээд дахиад төсвийн тодотгол олон сэдвүүд гарч ирнэ. Тэгэхээр юу гэж хэлэх гэж байна гэхээрээ тэр хүн төвт байх шийдвэр гаргах парламентын тэр 5 шалгуурт энэ орж ирж байгаа төсөл маань хэр зэрэг хангагдсан бэ? Өөрөөр хэлбэл хүний эрх, дээрээс нь хүний тэр эрүүл аюулгүй орчинд амьдрах энэ эрхийн асуудал дээр энэ төсөл хэр уягдсан бэ гэдэг асуултыг асуух гэж байгаа юм. Энийг яг тодорхой тоо хэмжүүртэй хариулбал сайн байна аа. Жирийн иргэдийн хүсэж байгаа зүйл бол асуудал маш ойлгомжтой баймаар байгаа юм. Жишээлбэл автомашиныг

хориглох юм уу, хориглохгүй юм уу, эс үгүй бол татвар яах юм бэ гэдэг ч юм уу нэг шийдвэр гаргаад л ард нь бөөн асуудал хэл ам. Шинэ машины улсын дугаар дамлагддаг. Энэ чинь өөрөө тэгээд дахиад дамын наймаа болчихлоо л доо. Тэгэхээр 1 зөв юм хийх гээд дахиад олон буруу уршиг үр дагаврыг гаргаад байгаа. Тэр утгаараа энэ хуулийн яг зөвхөн үзэл баримтлалын түвшинд гэхээсээ га гаднаас зохицуулалтын хувьд нөгөө хүний заяамал эрх, хүний эрхийн тэр стандартуудыг хэр хангасан бэ?

Тэгэхээр 2 тодорхой асуулт.

Нэгдүгээрт тэр парламентын хүн төвтэй байх 5 шалгуурыг энэ яаж хангаж байгаа юм бэ гэдэг асуулт байгаа.

Хоёрдугаарт нь гэх юм бол эргээд нөгөө эрүүл аюулгүй орчинд амьдрах яг энэ эрхийн асуудал. Аюулгүй орчин гэсэн стандарт дээр яаж нөлөөлж байгаа юм бэ гэсэн энэ 2 асуултыг асууя.

Б.Пүрэвдорж: Асуултад Дэгийн тухай хуулийн дагуу Эдийн засгийн байнгын хорооны дарга Ренчинбямбын Сэддорж, хууль санаачлагч Жуковын Алдаржавхлан нар хариулах ёстой хэн хариулах вэ? Хууль санаачлагч хариулъя.

Ж.Алдаржавхлан: Ерөөсөө энэ хуулийн гол зорилго нь л хүний эрхийг л хангах зорилготой хууль шүү дээ. Ер нь манай Улаанбаатар хотод бол сургууль, цэцэрлэггүй ийм төлөвлөлтүүд маш их болчихоод байгаа юм. Тэгээд яагаад энэ үүсчхэв гэхлээр Улаанбаатар хотыг ерөнхий архитектур гэдэг хүний зөвшөөрлөөр төлөвлөж байгаа юм. Тэд нар төлөвлөхдөө ганцхан зүйлийг барьдаг. Барилгын норм дүрэм гэж Барилгын сайдын баталсан нэг норм дүрийг баримталдаг. Тэрэн дээр нь сургууль цэцэрлэгийн асуудал байдаг. Гэхдээ зарим тохиолдолд сургууль цэцэрлэгтээ зөвшөөрлийг өгдөг, заримд нь огт өгдөггүй. Тийм дабль стандарт мөрдөгдөөд байгаа байхгүй юу. Яг гарын үсэг зурж байгаа ажил хариуцаж байгаа улсууд дабль стандарт мөрдөгдөж байгаа учраас миний хувьд энэ сургууль, цэцэрлэгийг заавал хуульд оруулж байж хотхон хороололд төлөх нь зүйтэй юм байна гэж үзэж байгаа юм.

Дээр нь энэ мянга хүртэл хүн амтай өрхтэй хотхон хороололд нэг улсын сургууль байна гэж төлөвлөж байгаа юм. Яагаад ингэж хүмүүс яагаад улсын сургууль гэж асууж байна лээ. Мянгын өрх дандаа баян хүмүүс байх бололцоогүй л юм байна лээ. Дийлэнх нь улсын сургуульд хүүхдээ өгөх юм сан гэсэн хүмүүс л байгаа.

Тийм учраас миний хувьд энэ хууль дээр хүүхдийн эрхийг хангахын төлөө, хүний эрхийг хангахын төлөө ерөөсөө хамгийн сайн сургууль гэрийн ойролцоо сургууль. Аюулгүй байдлыг хангаж байгаа. Хол явна гэдэг чинь аюултай байдал үүсгэнэ. Машинаар зөөнө, машинаар авна. Тийм учраас хүний эрх хүүхдийн эрхийн төлөө энэ хуулийг санаачилсан гэж үзэж байгаа. Энэ хууль хэрвээ батлагдах юм бол дахиж Улаанбаатар хотод сургууль цэцэрлэггүй хотхон хороо төлөвлөлт шууд хориглогдоно. Ийм давуу талтай хууль гэж үзэж байгаа.

Б.Пүрэвдорж: Болдын Уянга гишүүн асуулт асууна.

Б.Уянга: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Хот байгуулалтын тухай хуулийн үзэл баримтлалтай танилцсан. Тэгээд Монгол Улсын Үндсэн хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй 7 дахь заалт буюу сурч боловсрох эрхтэй гэсэн энэ заалт, энэ өгүүлбэр бол хэд хэдэн удаа давтагдаж байна лээ. Ингээд хуулийн төсөлтэй танилцангуут бол сурч боловсрох эрхийг хангах хүрээнд Хот байгуулалтын тухай хуулийн төслийн 12.6.4-д нэмэх байдлаар 250 хүртэлх хүртэл хүртэл 1-ээс доошгүй цэцэрлэг 1000 хүртэл 1-ээс доошгүй төрийн өмчит сургууль төлөвлөж тооцно гэсэн энэ заалтыг нэмж байна аа.

Эмнэлгээ яах билээ. Тэгээд энэ хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 12.4.1 дэх заалт болоод 10.2.5 дахь хэсэгт ингээд сургууль, цэцэрлэг, эмнэлэг гээд гурвууланг нь аваад нэмээд байгаа байхгүй юу. Эмнэлэг, сургууль, цэцэрлэг гээд. Тэгсэн мөртөө 12.6.4-д та бүгдийн нэмж оруулж ирж байгаа заалтад эмнэлгийг орхигдуулсан байгаа юм шиг уншигдаад байна аа. Тэгэхээр энэн дээр эхлээд ажлын хэсгээс тодруулгыг аваад тэгээд дараагийн асуултыг асууя.

Б.Пүрэвдорж: Жуковын Алдаржавхлан гишүүн хариулъя.

Ж.Алдаржавхлан: Уянга гишүүний асуултад хариулъя. Ер нь бол миний хувьд энэ хуулийг санаачлахдаа зөвхөн сургууль, цэцэрлэгийн чиглэлээр гол анхаарлаа хандуулж боловсруулсан. Хэрвээ Улсын Их Хурал дээр ажлын хэсэг гараад эмнэлгийн асуудлыг нэмж оруулах нь зүйтэй гэж үзэх юм бол хууль санаачлагч дэмжиж ажиллахад бэлэн. Тэгэхдээ эрүүл мэндийн байгууллагын энэ асуудлууд өөрөө бас тогтолцооны хувьд манай эрүүл мэндийн сайд хариулах ёстой гэж бодож байна. Яагаад гэхлээр ӨЭМТ-ийн тогтолцоо чинь одоо бас их тийм сонин тогтолцоо болчихоод байгаа юм. Хувийнх ч юм шиг, улсынх ч юм шиг. Улсаас бүх хэм тусламж дэмжлэгээ авдаг. Тэгээд өөрсдөө орлогоо авдаг. Тэгээд ийм сонин тогтолцоо байгаа юм аа. Тэгэхээр энэ эрүүл мэндийн асуудлыг цогцоор нь авч үзэхгүй бол яг энэ хуульд яваад хэцүү байсан юм аа.

Тийм учраас бид нар хамгийн түрүүнд хамгийн тулгамдсан хамгийн тулгамдсан асуудал гэж үзээд үзээд сургууль, цэцэрлэгийн хүртээмжийн асуудлыг дүрэмд оруулсан юм аа.

Б.Пүрэвдорж: Уянга гишүүн нэмж тодруулъя.

Б.Уянга: Ойлголоо. Гэхдээ эмнэлэг гэдэг үгийг сургууль цэцэрлэгтэйгээ та хэдийн хөндөж орж ирж байгаа заалт болгон оруулж ирсэн байгаа учраас уул нь тодорхой нэг тийм судалгаан дээр эмнэлгийн асуудлыг давхар оруулж ирсэн бол гэж бодогдож байлаа. Тэгээд гишүүд маань нэлээн судалж, ярилцаж, шийдсэн байх гэж найдаж байна аа. Гэхдээ яг нэг тоон дээр яагаад 250 хүртэлх өрх юм? Яагаад? Мянга хүртэлх өрх тутамд нэг сургуулийн, 250 хүртэлх өрх тутамд нэг цэцэрлэгийн гээд энэ ди парламент дээр тавигдсан материалууд дээр олигтой хариултыг олоогүй учраас та яг энэ од чуулганы индэр дээрээс энэ яг тооцооллын ерөнхий агуулгыг нь тодорхой хэлж өгвөл их зүгээр байна.

Ер нь хүүхдийн анги дүүргэлтийг, орон тоог нь яг тооцож үзсэн эсэх тэр бүх судалгаануудыг дурдаж өгвөл бүгдэд хэрэгтэй мэдээлэл байх байх аа.

Б.Пүрэвдорж: Академич Дүгэрийн Рэгдэл гишүүн асуулт асууна аа.

Д.Рэгдэл: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе ээ. Хууль санаачлагчийн танилцуулга, хуулийн төслийн танилцуулгыг аваад үзэх дээр зэрэг энэ нэмэлт өөрчлөлтийн гол зорилго нь 1 дүгээрт угаасаа манайд энэ ужигрчихсан сургууль цэцэрлэгийн хүртээмжийг сайжруулах.

Хоёрдугаарт, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль нь энэ хот тосгоны газар олголтыг цэгцтэй, ойлгомжтой, хариуцлагатай болгох, хяналтыг нь чангатгах.

Гуравдугаарт ер нь хот тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулахдаа тавигдах шаардлагуудыг тодорхой болгох ийм үндсэн 3 зорилгын үүднээс энэ нэмэлт, өөрчлөлтийг оруулж байгаа юм байна гэж ингэж ойлголоо.

Тэгээд би энэ хүүхдийн цэцэрлэгийн тоо сургуулийн тоо зэргийг авч үзээд тодорхой мэдээллийн эх сурвалжуудаар хайсан боловчиг манай энэ томоохон хотууд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг хотуудад одоо 6 хүртэл настай өрх хэчнээн байдаг юм. 18 хүртэл настай өрх хэчнээн байдаг юм гэдгийг үнэндээ олж харж чадсангүй.

Бид нарт бол тийм мэдээлэл алга юм байна. Гэхдээ яах вэ ерөнхийдөө бол жишээлбэл Улаанбаатар хотыг аваад үзэхээр 475100 өрх байгаа гэсэн ийм статистик байна. Энэ 475100 өрхөд бид 250 өрх тутамд нэг цэцэрлэг барина гэвэл 1900 орчим цэцэрлэг хэрэгтэй болох юм аа. Энэ 1900 цэцэрлэг одоо байж байгаа 645 цэцэрлэгийг хасаад үзэхтэй зэрэг жишээ нь явсаар байгаад 1255 цэцэрлэг шинээр шаардагдана.

Сургуулийн хувьд бол 475100 өрхөд 475 сургууль шаардагдах юм байгаа юм. Тэгэхээр одоо байгаа сургуулиудаа нэмж 161 сургууль барина гэсэн ийм тооцоо харагдаад байгаа юм. Саяхан манай Их Хурлын гишүүн Галбадрахын хийсэн энэ боловсролын тогтолцооны судалгаан дээр гарсан байгаа. Одоо манай Монгол Улсад эхний ээлжид 200 сургууль барьчих юм бол энэ сургуулиудын 3 дугаар ээлжийн асуудал анги дүүргэлтийн асуудлыг нэг тодорхой түвшинд шийдэж болох юм байна гэсэн их нарийн судалгаа гарсан.

Тэгэхээр энэ хуулийн заалтаар явна гэхээр зэрэг энэ 200-аас бүүр хамаагүй цаашаа гараад явчих шинжтэй юм харагдаад байна аа. Тэгэхээр эндээс би юу гэж асуух гэж байна вэ гэхээр зэрэг энэ олон сургууль, цэцэрлэгийн барих зардал чирэгдлийн тооцоо ер нь гаргаж үзсэн үү? Энэ хэмжээний зардлыг ер нь манай улс төсвөөсөө хэдэн жилд багтааж гаргаж чадах юм бэ? Энэ асуудлыг нэг та бүхэн маань нэг тодорхой хариулаад өгнө үү гэсэн хүсэлт байна аа.

Б.Пүрэвдорж: Рэгдэл гишүүний асуултад Жуковын Алдаржавхлан гишүүн хариулна.

Ж.Алдаржавхлан: Рэгдэл гишүүний асуултад хариулъя.

Ер нь зүгээр ийм л юм байгаа юм. Бид нарт Статистикийн үндэсний хорооноос гаргаж өгсөн судалгаагаар орон нутаг болоод Улаанбаатар хотыг бүүр ингээд дүүрэг дүүргээр нь гаргаж өгсөн. Жишээ нь БГД-т мянган өрх тутамд 2637 18 нас насны сургуулийн насны хүүхдүүд, 1481 цэцэрлэгийн насны хүүхдүүд гарч ирж байгаа юм. Тэгээд ерөөсөө дунджаар жишээ нь СХД-т мянган өрхөд 2620 гэх мэтээр. Ер нь

тэгээд л мянган өрх тутамд л 2600 гэдэг чинь нэг 960 хүүхдийн сургууль зайлшгүй хэрэгтэй болчихоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр ерөөсөө мянга хүртэлх хотхон, хороолол, хүн амьтан, хотхон, хороолол өргөтгөх хотхон хороолол төлөвлөх юм бол зайлшгүй нэг 960 хүүхдийн сургууль баригдах ёстой юм байна гэж үзэж байгаа. Хүртэлх гэдэг үг нь юу гэсэн үг вэ гэхээр 500 өрхтэй бол тэр сургуулийн хүчин чадал буурч болно. Тэрийг багасгах ёстой. Энэ зардал мөнгө нь хаана вэ гэвэл угаасаа хотхон хорооллыг төлөвлөж байгаа хүмүүс энэ сургууль, цэцэрлэгийг заавал барих ёстой гэж үзэж байгаа юм. Хөрөнгө оруулалт хийж байгаа хүмүүс ашиг олж байгаа бол хүүхдийн сургууль цэцэрлэгийг заавал төлөвлөх ёстой. Одоо тэр Алтай хотхон бол 15 мянган хүнтэй мөртөө нэг ч сургууль, цэцэрлэггүй хаячихсан байгаа байхгүй юу. Тэр хүүхдүүдийг хаана яв гэж бодож байгаа юм. Хаашаа хүргэж өгөх гэж бодсон юм.

Тийм учраас хуульчилж өгөхгүй бол ерөөсөө болохгүй байгаа юмаа Рэгдэл гуай. Тэр санхүүжилтийнх нь асуудлыг тэр хөрөнгө оруулагч нар өөрсдөө шийдэх ёстой гэж үзэж байна.

Б.Пүрэвдорж: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууна.

Уучлаарай Дүгэрийн Рэгдэл гишүүн тодруулж асууна.

Д.Рэгдэл: Тэгэхээр би сая буруу ойлгоогүй бол энэ орон сууц бариад байгаа хувийн хэвшил байна. Сургууль, цэцэрлэгийг нь өөрөө хөрөнгөө гаргаад барих ёстой гэсэн ойлголтыг л хэлчих шиг болох юм. Тэгэхдээ зэрэг нийтийн сургууль цэцэрлэгийг барихад угаасаа тэр хөрөнгө оруулах хэлбэр ямар ч байж болно. Гагцхүү тэр хөрөнгө бол төсвөөс гарна гэдэг ойлголт бид нарт байх ёстой. Тэр компани хувийн компани орон сууцынхаа хажууд сургууль, цэцэрлэг барихдаа өөрийнхөө мөнгөөр барьж болно. Гагцхүү тэр мөнгийг нь бол улсаас компенсаци хийж байх л ёстой юм л даа. Тэгэхээр энэ бол алсын ер нь ерөнхий утгаараа бол төсвийн мөнгөөр л барих юм шүү дээ. Тэгэхдээ зэрэг энэнийхээ тооцоог энэ хуулийн хэлэлцүүлгийн явцад нэг нэлээн нарийвчлал хийгээд оруулаад ирээрэй гэж захъя даа.

Б.Пүрэвдорж: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууна.

С.Эрдэнэбат: Энэ хуулийг дэмжиж байгаа тэгэхдээ их л оройтсон бороо гэдэг шиг Улаанбаатар хотод маань дахиад хот төлөвлөлт сургууль барих зай талбай үнэндээ байхгүй дээ. Уг нь 15 жилийн өмнө нэг энийг санаачлаад хийчихсэн байсан уг нь их зөв байсан юм 2 дугаарт шинэ төлөвлөлт, энэ Сэлбэ дэд төв, Баянхошуу энэ тэр гээд шинээр төлөвлөж байгаа гэр хорооллын төлөвлөлтүүдээр яг энэ стандарт дүрэм журмыг бариад явах ёстой. Томоохон үнэтэй хотхонууд байна. 10 сая, 7, 8 сая гээд нөхдүүд байшин бариад ашгийг нь олдог. Тэгэнгүүт нь тэнд нь улсын сургууль төлөвлөнө гэхээр тэр тухайн компаниуд гаргана гэж энэ сургуулийг өөрийнхөө хөрөнгөөр тэгэхгүй бол ашгийг нь тэр хүмүүсийнхээ хүртдэг татвар төлөгчдийн мөнгөөр сургуулийг нь бид нар очиж барьж өгдөг гэдэг ийм концепцоор явчих юм биш байгаа?

Тийм учраас яах вэ ер нь ямар ч байсан төлөвлөнө. Мөн түүнээс дээш цэцэрлэг дагаад тэр эмнэлэг, өрхийн эмнэлэг, бүр нөгөө 20 минутын хотын үзэл баримтлалын хүрээнд замын түгжрэлтэй шууд холбогдож байгаа. Хүүхдийн хичээл

амралт эхлэхээр замын түгжрэл эрс буурчигдаг. Тийм учраас хүмүүсийн хамгийн нэгэнт энэ хуулийг байж байгаа учраас би Алдаржавхлан гишүүнийг хэлэхэд тэр эмнэлэг, сургууль, цэцэрлэг, өдөр өнжүүлэх гээд нэг зүйл байдаг. Түрүүн 15 мянган хүнтэй тэр хотхон дотор бол хүүхдийн сургууль байтугай нэг сагсны шийд хүртэл байхгүй хотхонууд хүртэл байна л даа. Тэгээд энэ мэнийг нь бүгдийг нь ингээд нэг цогц байдлаар нь нэмэлт оруулаад ингээд шийдчих боломж бололцоо байна уу?

Олон дахин бид нар хийхэд бол энэ хот байгуулалтын хуульд оруулах юм байна. Дээрээс нь хэрвээ энэ стандартыг мөрдөхгүй бол яах юм? Өөр зөрчилдөх хуулиудыг нь харж үзсэн үү? Мөрдөхгүйгээр барьчихвал яадаг юм гэдэг байдлаар. Тэгэхээр тэр ерөнхий архитектур байна уу, хот төлөвлөлтийн зөвшөөрөл олгож байгаа хүмүүс байна уу? Энэ дээр ямар хариуцлагын механизмыг дагалдах хууль тогтоомжуудаар оруулж өгсөн бэ гэдэг зүйлийг тодруулж асуумаар байна. Эхлээд энийг тодруулаад асуучихъя.

Б.Пүрэвдорж: Гишүүний асуултад Жуковын Алдаржавхлан гишүүн хариулна.

Ж.Алдаржавхлан: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Эрдэнэбат гишүүн маш чухал асуудлуудыг хөндөж байна.

Нэгдүгээрт бид нар хүний хүчин зүйлээс гаргах гэж энэ хуулийг санаачилж байгаа. Нэг албан тушаалтны хүчин зүйлээс. Тэр хүнд субъектив байдлаар объектив байдлаар хандахаас гаргахын тулд энэ хуулийг санаачилсан. Та хэд маань сая ярьж байгаа саналуудаа нэгтгээд ажлын хэсэг байгуулагдаад ажиллана гэж төлөвлөж байгаа. Энэ хууль дээр зарим нэг заалт нэмье гэвэл бид нар дэмжиж ажиллахад бэлэн байгаа. Зөрчлийн хуулиар хариуцлагын асуудал нь орж ирж байгаа. Хэрвээ энэ хуулийг биелүүлээгүй бол Зөрчлийн хууль дээр заагдсан арга хэмжээнүүд авагдана гэж байгаа. Тэгээд энэ хуулийн дагаж мөрдөх журмын хууль дээр ч байж байгаа. Ер нь энэ хуульд нийцүүлэх шаардлагыг тавигдаж байгаа.

Эрдэнэбат гишүүн өмнө төлөвлөлтөө авчихсан нөгөө А даалгавар гэж юм байдаг шүү дээ. Тэрний гарын үсгээ зуруулаад авчихсан нөхдүүд ч гэсэн энэ шаардлагыг нийцүүлэх тийм асуудлыг тавьж байгаа юм. Энэ дагаж мөрдөх журмын тухай хууль дээр нь байж байгаа. Одоо барилга нь эхлээгүй байгаа барилга нь явж байгаа хотхон хорооллууд бүгдэд нь энэ хуульд нийцүүлэх шаардлагыг тавих тийм зохицуулалтыг оруулсан байгаа. Тэгэхээр ажил хариуцаж байгаа улсууд энийг заавал хийх ёстой гэж би хууль санаачлагчийн хувьд үзэж байгаа юм аа.

Б.Пүрэвдорж: Сүхбаатар Эрдэнэбат гишүүн тодруулъя.

С.Эрдэнэбат: Шинэ хотхон, хорооллыг барихад нэг зүйлийг бид нар орхиод байдаг нь яах вэ төр өөрөө бодлогоороо орон сууцжуулах бодлого хийж байвал тэр сургууль, эмнэлэг, цэцэрлэгт ажиллаж байгаа хүмүүсийн орон сууцыг худалдаж авах энэ боломж бололцоог нь давхар төлөвлөөд өгвөл уг нь энэ хотын түгжрэл нэг сумаар олон туулай буудчих ийм боломж бололцоо байгаа.

Дээрээс нь энэ газар хөдлөх гэдэг юм уу ийм хүнд эрсдэл тохиолдсон тохиолдолд манай хотыг ингээд харж байхад заавал нэг айлын цонхыг хааж барьдаг нар салхи үзэх энэ юуг нь хааж барьдаг.

Дээрээс нь газар хөдөлбөл ёотон шиг нурчих магадлалтай ийм хотхонууд байгаа. Тийм учраас энд энэ тал дээр бол хэрвээ хотын стандарт дүрэм журам зөрчиж гамшиг ослын үед ийм олон хүний амь нас эрүүл мэндтэй холбоотой хохирол гарсан тохиолдолд хариуцлага хүлээдэг байхаар энэ хуулиуд дээр тодорхой тусгаж өгөх ийм шаардлагатай байна гэж үзэж байна аа.

Б.Пүрэвдорж: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууна.

Д.Пүрэвдаваа: Өглөөний мэнд. Хууль санаачлагч Алдаржавхлангийн санаачилсан энэ хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлье ээ. Тэгээд цөөн хэдэн асуулт байна аа.

Нэгдүгээрт, энэ Хот байгуулалтын тухай хууль нь бол олон зүйл заалтаараа бусад хуулиудтайгаа нийцэж байгаа эсэхийг ер нь судалсан уу? Энгийнээр хэлэх юм бол миний харж байгаагаар Үндсэн хууль зөрчсөн нэлээн хэд хэдэн заалт байгаа.

Дээрээс нь Нэгжийн тухай хууль, дээрээс нь Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, дээрээс нь түгжрэлийг нөгөө бууруулах гээд яаралтай горимоор нэг шийдэгдсэн хууль байгаа шүү дээ. Эдгээрийн уялдаа бол огт байхгүй байна гэж харж байгаа. Энгийн жишээ дурдахад Үндсэн хуулийн 25.1.2-т төсвийн болон улсын хөгжлийн бодлого Улсын Их Хурлаар батлагдана гээд. Тэгэнгүүт энэ хот төлөвлөлтийн тухай хуулиуд дээр болохоор хөгжлийн ерөнхий төлөвлөгөө Улсын Их Хурлаар батлагддаггүй, зөвхөн НЗДТГ-аар ороод батлагдаад явчихдаг. Тухайн хурлаараа ороод.

Жишээгээр төвлөрсөн ба төвлөрсөн бүс удирдлагын зохистой хослол. Ер нь ингээд нөгөө хотын бүсчлэлийг тогтоохдоо уул нь бол ил тод байдлыг хангаад тэгээд иргэдээсээ саналыг нь авах байтал төрийн байгууллага тогтоохоор хуульчилчихсан ямар ч ил тод байдал байхгүй.

Эдгээрийн чинь сүүдэр нь өнөөдрийн үр дүн байна уу даа гэж ойлгож байгаа. 2 дахь нь стандартын асуудал. Жишээгээр өнөөдөр хариуцлагын систем байдаггүй. Нэг куб агаарт 50 микрограмм тоосонцор байхад хотын дарга ямар хариуцлага үүрдэг вэ. Дүүргийн Засаг дарга ямар хариуцлага үүрдэг вэ гэхээр ямар ч хариуцлага үүрдэггүй. Стандарт зөрчсөн тохиолдолд.

Тэгэхээр энэ хариуцлагын асуудлуудыг хэчнээн хэмжээний децибелийн дуу чимээ гаргавал өнөөдөр хүний эрх зөрчигдөөд байгаа юм бэ? Энэ хотод байна гэдэг чинь нийт дэлхийн хүн амын 70 орчим хувь нь суурин газар амьдарч байна. Монгол Улсын мөн адил нэг 67 орчим хувь нь суурин газар амьдарч байна. Тэгэхээр энэ суурин газрын иргэдийн төлөөлж байгаа тухайн ИТХ, Засаг даргаа томилж байгаа.

Тэгэхээр тэр хэм хэмжээг мөрдөх стандартын асуудал тодорхойгүй байна гэж харж байгаа юм. Хариуцлагын хувьд.

Дээрээс нь жишээгээр цэцэрлэг өнөөдөр 3 настай, 4 настай 5 настай хүүхдүүдийг авдаг. Гэхдээ барилгыг нь бол 2 давхраар стандартчилсан байдаг. Герман ингээд бүр энэ ялангуяа газар нутаг багатай Азийн орнуудад бол цэцэрлэг олон давхар ч байх тохиолдол бий. Тэгэхээр 2 давхар байгаа төвийн байршилтай иргэд ингээд дайраад хүүхдээ өгөх тэр бололцоотой цэцэрлэгүүдийг 3 давхар

болгоод багтаамжаа нэмж болдоггүй юм уу? Энэ тал дээр та бодож үзсэн үү? Одоо бид нар ингээд улсын мөнгөөр цэцэрлэг барилаа гээд бодоход алслагдмал уулын орой дээр эцсийн буудлаасаа хол тийм газар цэцэрлэг сургууль барих тохиолдол гараад байгаа юм.

Тэгэхээр энийгээ нэг эргэж харах.

Б.Пүрэвдорж: Алдаржавхлан гишүүн хариулъя.

Ж.Алдаржавхлан: Пүрэвдаваа гишүүн чухал асуудал хөндөж байна. Тэр норм дүрэм стандарт гэж байдаг. Тэр нь өөрөө Барилгын сайдын баталсан тийм байгаа юм. Барилгын норм дүрэм, стандарт, цэцэрлэг, цэцэрлэгийн барилга ийм байна. Сургуулийн барилга ийм тэдэн давхар байна. Тэдэн метр квадрат нэгийн анги байна гэсэн тийм норм дүрэм байж байгаа юм. Гэхдээ харамсалтай нь 2 янзын норм дүрэм байгаад байгаа юм. Улсын сургууль 3 давхраас дээш байж болохгүй, хувийн сургуульд тийм стандарт байхгүй хэдэн давхар ч байсан. Ийм стандарт манай барилгын сайдын өнөөдрийн баталчихсан норм дүрэм дээр явж байгаа юм. Энийг одоо энэ шинэ Засгийн газар гардаг юм уу, яадаг юм тэгээд би өөрчлөх байх гэж найдаж байгаа. Би албан тоот энэ тэр явуулсан энэ хуулийг санаачилж байхдаа энэ стандартаа нэг стандарттай байвал яасан юм бэ гэж.

Тэгээд үнэхээр хүрэлцэхгүй бол цэцэрлэг 3 давхар болох тухай асуудлыг ярьж хөндөж болох ёстой гэж үзэж байгаа юм.

Тийм учраас манай салбар хариуцсан сайд нар маань энэдээ хариуцлагатай хандаад нэг стандартыг Монгол Улсад бүрдүүлэх ёстой гэж үзэж байгаа юм аа.

Тэгээд ямар ч байсан энэ хуулиа эхлээд батлуулж аваад тэгээд саяын ярьсан Стандартаас орох ёстой юм байна гэж би харсан. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Пүрэвдаваа гишүүн нэмж тодруулъя.

Д.Пүрэвдаваа: Ер нь бол хуулийн төслийг түрүүний хэлсэн дэмжиж байгаагаа илэрхийлж байгаа. Тэгээд өнгөрсөн хугацаанд дахиад л нөгөө Үндсэн хууль дээр мэдээлэл авах төрийн үйл хэрэгт иргэн бүр оролцох эрхтэй гэсэн тэр нэг зүйл заалт нь хаагдмал байгаа учраас Хот байгуулалтын тухай хууль дээр бол иргэдээс санал авна, иргэдэд ил тод байна гэсэн юм нь ердөөсөө байхгүй.

Нэгэнтээ хуульдаа хүрч байгаа юм чинь үндсэн том том цогц зүйлүүдээ давхар янзлаад цэгцлээд явчихвал оновчтой байх юм болов уу гэдэг ийм саналыг хэлэх гэсэн юм аа. Баярлалаа. Амжилт хүсье.

Б.Пүрэвдорж: Ганбаярын Хосбаяр гишүүн асуулт асууна.

Г.Хосбаяр: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Ер нь ерөнхий төлөвлөгөө хэсэгчилсэн төлөвлөгөө гээд маш чухал юм байдаг л даа. Тэгээд хэсэгчилсэн төлөвлөгөө ерөнхий төлөвлөгөөг мэргэжлийн архитектурууд, хот байгуулалтын инженерүүд, мэргэжлийн эрдэмтэн судлаачид хийдэг. Түүнээс биш өнөөдөр хотын ерөнхий төлөвлөгөөг ганцхан архитектур батлаад тэр хүн янз бүрийн асуудал үүсгээд ингээд өөрийнхөө дураар шийдээд байдаг ч юм уу гэж ойлгохгүй л байна л даа.

Тэгэхээр бид нар ер нь өмнө нь явж ирсэн зам бол энэ архитектур ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөгөө муу байсан учраас үүнийг сайн хийж чадаагүй байсан учраас ганцхан Улаанбаатар хот гэлтгүй аймгийн төвүүд хөдөө сумдууд хүртэл энэ газар олголт энэ асуудал хурцаар хөндөгддөг болсон.

Тийм учраас сая оны эхэнд Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөө орж ирж байсан. Бид нарт бүгдээрэнд нь том өнгөтөөр хэвлээд тараасан. Ирээдүйд Улаанбаатар хот энэ хэсэгтээ хүнсний агуулах аэросити байна, энэ хэсэгтээ ингээд Хүннү хот нь байна, энэ хэсэгтээ тээвэр ложистикийн төв нь байна гээд ингээд төлөвлөсөн.

Тийм учраас бид нар энэ улс бол энэ ерөнхий төлөвлөгөө хэсэгчилсэн төлөвлөгөөгөө дахин боловсруулаад үүн дээрээ онцгой анхаараад үүнийг аймаг сум, дунд шатад иргэдийн хурал нь баталж байгаа. Түүнээс биш ганцхан архитектор дураараа шийдээд байдаг юм байхгүй гэж ойлгож байгаа. Тийм учраас ард иргэдийн саналыг аваад энэ ерөнхий төлөвлөгөө хэсэгчилсэн төлөвлөгөөгөө сайн боловсруулаад үүнийгээ бариад ажиллахад бас нэг их замбараагаа алдчихсан юм байхгүй. Зохицуулагдаж болно гэж ингэж ойлгож байгаа. Тэгээд яах вэ сая энэ сургууль, цэцэрлэг, эмнэлгийн асуудлыг л түлхүү яриад байна. Мэдээж одоо олон хүнтэй хотхон хороололд ийм шаардлага тавьж болно. Гэхдээ нөгөө талд нь энийг мэдээж хувийн хэвшилд л хөрөнгө оруулалт гаргаж хийвэл тэр орон сууц хотхон хорооллын үнэ л нэмэгдэх ийм асуудал үүснэ ээ.

Тийм учраас үүн дээр одоо ер нь эдийн засгийн тооцоолол хийсэн үү? Судалгааны байгууллагуудаас бас санал авсан уу? Хувийн хэвшлээс санал авсан уу гэдгийг бас асуумаар байна.

Тэгээд ер нь бол энэ хот байгуулалт дээр газрын асуудал л хамгийн чухал асуудал байгаа шүү дээ. Өнөөдөр Улаанбаатар хотод өмнө нь явагдаж ирсэн замбараагүй газар олголтоос болоод л газрын үнэ өсчихсөн. Өнөөдөр Яармагт газрын үнэ нэг га нь жилд 500-аас тэрбум төгрөгөөр нэмэгдээд л ингээд явж байна. Үүнээс чинь болоод л орон сууцын үнэ өсөж байна. Сургууль цэцэрлэг барих боломжгүй болж байна.

Одоо нэгэнт тийм үнэ цэнтэй, үнэтэй газар авчихсан хүмүүс чинь улсад буцаагаад газраа өгөх гэхээр л бөөн нөхөн төлбөр авдаг, эсвэл янз бүрийн арга саам хийдэг шүүхэд өгдөг гээд ийм олон асуудлууд үүсдэг ээ.

Тийм учраас энэ Газрын тухай хуулийг шинэчлэн найруулж ер нь бас зориулалтын дагуу ашиглахгүй байгаа маш их газрууд байгаа. Үүнийг төр тэр зориулалтын дагуу ашиглаагүй урт удаан хугацаанд ингээд зүгээр ашиг олох зорилгоор хадгалаад байгаад байдаг жил болгон үнийг нь өсгөөд байдаг энэ асуудлыг одоо тэр яг хуулийнхаа дагуу хурааж аваад, зориулалтын дагуу ашиглах бусдад хөрөнгө оруулаад ажил хийх боломжтой газар нь өгөх зэрэг ийм асуудалд анхаармаар байгаа юм.

Мэдээж Барилгын тухай хууль, барилгын стандарт, норм дүрэм гээд олон асуудлууд байгаа. Үүнийг бол шинэчлэх шаардлагатай байгаа.

Өнөөдрийн чуулганаар байна уу энэ стандартын техникийн зохицуулалтын хууль орж ирнэ. Би бас ажлын хэсэгт орж ажиллаж байгаа. Тийм учраас энэ барилгын стандарт маш их шинэчлэх шаардлагатай өөрчлөх шаардлагатай юмнууд байгаа. Тэгээд ер нь бол энэ эдийн засгийн тооцооллыг сайн хийх хэрэгтэй. Хэсэгчилсэн болон ерөнхий төлөвлөгөөнүүдээ иргэд нийтээрээ хэлэлцүүлээд мэргэжлийн хүмүүсийг оролцуулж сайн хийх шаардлагатай гэж ингэж харж байгаа.

Тэгээд энэ хэсэгчилсэн төлөвлөгөөн дээр бас ажлын хэсгийн хүмүүс.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ.

Алдаржавхлан гишүүн хариулъя.

Ж.Алдаржавхлан: Би Хосбаяр гишүүнийхийг ер нь санал байна гэж ойлгож авч байна. Таны саналуудыг бид нар тусгаад хэдүүлээ энэ хуулийг хэлэлцүүлгийн шатад саналыг тусгаж авч болно манай нийслэл Улаанбаатар хотын Ерөнхий архитекторын ажлын албаны дарга Баттөмөр гэж хүн ирсэн байгаа. Тэрнээс нэмэлт тодруулж болно. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуулт асууна.

М.Ганхүлэг: Өглөөний мэндийг хүргэе. Хуулийн төслийн хэлэлцэх асуудлыг дэмжиж байгаа. Чухал асуудал оруулж ирсэн. Алдаржавхлан гишүүнд талархал илэрхийлье. Хуулийн энэ агуулга бас оройтсон гэдэгтэй санал нэг байна. Тийм тэгээд энэ агуулгаараа яах вэ шинээр явж байгаа зураг төсөв нь хийгдсэн баригдаж эхлэх гэж байгаа болон цаашид баригдах энэ барилгуудтай хамааралтай асуудал ингээд энэ хуулиар зохицуулагдах юм байна аа.

Тэгэхээр таны илтгэлд дурдагдсан одоогийн байгаа энэ асуудлуудтай холбогдолтой асуудлыг та бүхэн ажлын хэсэг дээр төсөл дээр яригдсан уу? Энэ асуудлуудыг ямар байдлаар шийдэх ийм юу тооцооллууд байж болох вэ гэдэг асуултыг тодруулъя. Бүс орон нутгууд бас жоохон ялгаатай онцлогтой байна уу? Сумдууд, аймгууд, хөдөө орон нутгийн түвшинд хэлэлцүүлгийн шатад санал авсан уулзсан тэдний саналуудыг тусгасан тэр нөхцөл байдалд нь тулгуурлаж тооцоолсон зүйлүүд байгаа юу гээд бусад асуудлууд ерөнхийдөө давхардлаа.

Б.Пүрэвдорж: Үг хэлчихлээ.

Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууна.

Уучлаарай түр зуур хүлээж байгаарай. Сая асуулт нэг байсан байна. Алдаржавхлан гишүүн хариу хариулъя.

Ганхүлэг гишүүнд баярлалаа энэ ингэж байгаа юм. Ганхүлэг гишүүн ээ одоо төлөвлөж байгаа нөхдүүд энэ стандартыг барья гэж байгаа юм тиймээ.

Дээр нь энэ Дагаж мөрдөх журмынх нь тухай хууль дээр уг шаардлагад нийцүүлээгүй явж байгаа хотхон хорооллуудын төлөвлөлтийг энд нийцүүлэх шаардлагыг тавина гэж байгаа юм. Ер нь одоо эхэлсэн байгаа болон одоо төлөвлөлтөд явж байгаа бүх хотхон хорооллууд энэ асуудлыг тавина. Одоо баригдаад дууссан асуудлууд дээр хүндрэлтэй л дээ. Ашиглалтад ороод

дуусчихсан. Анхнаасаа сургууль, цэцэрлэггүй төлөвлөчихсөн нөхдүүд зөндөө байгаа. Тэгээд бид нар олон газартай уулзалт хийгээд саналуудыг авсан. Ди парламент дээр ч тавьж саналууд авсан. Барилгын салбарын хүмүүстэй ч уулзаж асуултад саналуудыг авсан. Иргэдээс маш их хүсэлтүүд ирсэн. Энэ хуулийг санаачилж байхад. Энэ улсын сургуультай болгож өгөөч л гэдэг юм байна лээ. Иргэд маань ерөөсөө. Одоо би 0-18 насны 4 хүүхэдтэй. 4 хүүхдийн сургалтын төлбөрийг би 80 сая төгрөг жилд өгч чадахгүй байна энэ энэ хотхонд амьдарсныхаа төлөө гэж байгаа юм. Тэгээд улсын сургуультай болгож өгөөч гэдэг хүсэлт маш их ирдэг учраас миний хувьд энэ хууль дээр улс төрийн өмчит сургуулийг бол оруулсан юмаа. Бусад асуудал дээр бол санал байна гэж ойлголоо.

Б.Пүрэвдорж: Ганхүлэг гишүүн нэмж тодруулъя.

М.Ганхүлэг: Хувийн хэвшлийнхэн төсөв санхүү ямар төсвөөр барихтай холбогдолтой асуудал манай гишүүд ярьж байх шиг байна. Бид тодорхой шийдлийг гаргаж өгсөн ийм хувилбарууд байгаа гэж харж байна аа.

Тодорхой ААН-ийн орлогын нэг хувийг сургууль, цэцэрлэг, боловсролын салбарт зарцуулах энэ боломжийг бид бүхэн хуулиараа нээж өгсөн. Тэгэхээр энэ тодорхой бас энэ шийдлүүдээр асуудлуудыг ч тэгээд авч боломжтой болов уу гэж ингэж харж байна гэдгээ хэлж байна.

Б.Пүрэвдорж: Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууна.

Д.Ганмаа: Энэ Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль шинэчилсэн найруулга өөрчлөлт оруулах тухай энэ хуулийн төслийг дэмжиж байна. Энэ асуудлыг жишээлбэл Өмнөговь дээр нэг ийм Цагаан хад гэж газар байгаа. Энэ өмнө гишүүд ярьж байсан. 10 мянга гаруй суурьшилтай. Тэрүүгээр говийн бүсүүдээр явах уулзалтын үеэр харж байхад нөгөө хөл хөдөлгөөн ихтэй тэгээд халдварт буюу халдварт бус өвчний эрсдэл маш өндөртэй, хэт төвлөрсөн түр суурьшил гээд нэрлэчихсэн учраас зүгээр Ханбогд суманд байршилтай боловч засаг захиргааны нэгж байхгүй энэтэй холбогдоод эмнэлэг байхгүй эмч гэж багийн ганц эмч байдаг. Эрүүл мэнд тусламж үйлчилгээний хүртээмж огт байхгүй. Чанар эмийн талаар яриа ээд ч хэрэггүй. Энэ том асуудал байгаа юм. Энэ асуудлыг ингэж цаашаагаа ахиад л хойшлогдоод л дор хаяж жилээр хойшлогдож энэ асуудал орж ирэх гээд байгаад сэтгэл зовниж байна. Энэ дээр журмаар ч юм уу судалгааны нөхцөл тоо датагаа ашиглаж байгаад энэ дээр ямар нэгэн шийдэл гаргах боломж бололцоо энэ ажлын хэсгийнхэнд байсан уу, харсан уу, судалсан уу гэдгийг асууя.

Хоёрдугаарт яах вэ өрхийн эмнэлгийн талаар санал нэг байгаа. Одоо нэг хувийн ч юм шиг төрийн ч юм шиг нийлбэр ч юм шиг. Тэгээд яг моделийг нь тодорхой болгоод болоогүй учраас ингээд хаягдаад байгаа. Тэгэхдээ энэ таны саяын нэрлэсэн тэр том том суурьшлын олон хүмүүстэй энэ хотхонуудад яах аргагүй өрхийн эмнэлэг ч юм уу эмнэлгийн тусламж ялангуяа нөгөө жирэмсэн эхчүүд байдаг архаг өвчлөлтэй хүмүүс их байдаг. Группийн хүмүүс байдаг. Нялх нярай хүүхэдтэй вакцины асуудал энэ бүгд хаягдаж хол явах шаардлага гаргадаг учраас энийг юу энэ журамдаа ч юм уу ямар нэгэн байдлаар тусгах зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна. Энийг саналдаа тусгаж өгөөрэй гэж хүсэж байна.

Гурав дахь нь Хот тосгоны энэ эрх зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулга нь 2024 оны 6 сарын 5-ны өдөр анх баталсан юм байна. Гэтэл жилийн ч хугацаа

өнгөрөөгүй байхад ингээд өөр өөрчлөлт оруулаад ирэхээр ер нь энэ Хууль тогтоомжийнхоо хуультайгаа нийцэж байгаа юу гэдэг дээр нэг асуулт байна.

Б.Пүрэвдорж: Хууль санаачлагч Жуковын Алдаржавхлан гишүүн хариулна аа.

Ж.Алдаржавхлан: Цагаан хадны тухайд надад үнэхээрийн мэдээлэл алга. Нөгөө та тойргоор тойрч явахдаа олж харсан юм байна. Тэгээд та санаачилга гаргах юм бол яг түүнтэй холбоотой асуудлууд хэдүүлээ энэ хуулийн ажлын хэсэг дээрээ санаачлаад явж болно гэж бодож байна. Өрхийн эмнэлгийн асуудлуудыг бол үнэхээрийн яг олж харсан байна. Модель загварын хувьд бүр ойлгомжгүй загвартай. Тэгээд энэ асуудлыг нэг тийш нь болгохгүй бол маш хүндрэлтэй байгаа. Тэгээд маш олон гишүүд эмнэлгийн асуудлыг хөндөж байгаа учраас бид нар ажлын хэсэг дээр эмнэлгийн асуудлуудыг оруулаад явъя.

Гэхдээ хоёулаа бас ярьж байгаад саяын тэр өрхийн эмнэлэг дээр нэг ЭМЯ-тай ярьсан загварын асуудал нэг тийш нь болгохгүй бол маш их хэмжээний орлого олоод авах юмаа бүгдийг нь улсаас аваад байгаа юм. Тэгээд цалин гайгүй өндөр цалинтай болчихсон юм байна лээ шүү дээ. Тэгсэн хэрнээ манай тогны мөнгийг төлж өг, байрны мөнгийг төлж өг гээд байдаг. Тэгсэн хэрнээ нөхөрлөл гэж яваад байдаг энэ сонин зүйл байгаа юм. Энэ дээр хэдүүлээ хамтарч ажиллаад шинэ загвар дээр ажиллах саналыг би танд тавьж байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууна аа.

О.Номинчимэг: Бүгдээрэнд нь өглөөний мэнд хүргэе. Энэ хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуультай холбогдуулан 3 асуулт байна. Хуулийн төслийн танилцуулгыг харахаар аймаг нийслэлийн хот суурин газрын төвлөрсөн суурьшлын бүсийг төлөвлөхдөө нэн тэргүүний ээлжид хүүхдийн суралцах цэцэрлэг сургуулийн хүртээмжийг яг таны хуульд оруулсан энэ хэмжээгээр төлөвлөдөг тооцдог болно гээд тэгж байна.

Тэгэхээр энэ ер нь агуулгаараа бид нар тооцдог энэ стандарт байдаг юм уу, норм байдаг юм уу төлөвлөлтийн энэ нормоор хуульд оруулж хуулийн хэм хэмжээ болгож байгаа гэж ойлгож болох уу? Ялангуяа энэ нөгөө 250 өрх бүрд нэг цэцэрлэг, мянган өрх бүрд нэг төрийн өмчит сургууль гэж байгаа шүү дээ тиймээ. Энэ тоо бол яг хуучин байсан стандартын тоо юу гэдэг 1 дүгээр асуулт байна.

Хоёрдугаар асуулт энэ хуулийг харахаар ингээд төлөвлөлтөд орох юм бол энэ хууль батлагдах юм бол энэ төрийн өмчит сургууль баригдана гээд тэгж байна. Тэгээд энэ хот төлөвлөлтийн асуудал, хот байгуулалтын асуудал өөрөө газартайгаа маш холбоотой байдаг. Та бол яах вэ сая хэлж байна л даа одоо ингээд төлөвлөгдөж байгаа болон цаашаа төлөвлөгдөх хот суурин газар энэ хотхон хороололд л үйлчилнэ гээд. Тэгэхээр энэ дээр газрын асуудлыг нь төлөвлөлтөд яаж тусгах юм бэ? Энэ барилгын компаниуд газар авчихсан байдаг. Тэрэн дээрээ уг нь бол ингээд тоглоомын талбай, гарааш юу байдаг юм тэр чинь нэг нормтой орц гарц гээд бүх юмыг нормоороо төлөвлөх ёстой байдаг. Тэгээд тэр газар дээр нь бид нар энийг нөгөө сургууль байх ёстой гэж харах юм уу? Эсвэл тэрнийх нь ойролцоо байдлаар бид нар төлөвлөж одоо энэ барилгын компани энд мянган өрхтэй байшин барих гэж байна. Тэгвэл төлөвлөлтөө энэ хажууд нь ингээд юу гэдэг юм 1 мянган хүний, мянган хүүхдийн сургууль байна гэж газраа төлөвлөх гэж байгаа юм уу? Энэ

газрын төлөвлөгөө хот суурин газрын төлөвлөлттэй одоо энэ Дагаж мөрдөх журмын тухай хууль дээр орж ирж байгаа төлөвлөлттэй яаж уялдах юм, энэний уялдаа холбоог та яаж харж байна гэдэг 2 дугаар асуулт байна.

Гуравдугаарт энэ зардлын тооцоололтой холбоотой асуудал байна. Би энэ нөгөө энэ хууль гарснаар ер нь төрд ямар зардал гарах гээд байгаа юм, ААН-үүдэд тэгвэл энэтэй холбоотой газар дээрээ газраа хэсэгчилж сургууль төлөвлөхөөр байшингаа төлөвлөхгүй ийм юман дээр зардал гарах гэж байна уу гээд харахаар надад Тамгын газраас өгсөн зардлын тооцоолол Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн зардлын тооцооллын судалгаа гэсэн чинь буруу бичиг баримт л юм шиг байна. Дотор нь ерөөсөө түгээмэл малтмалын юу муу гээд тэгээд энэ л байгаа юм уу гээд тэгэхээр хуультай дагалдаж энэ орж ирсэн гэхэд тэгэхээр та яг энэнтэй холбоотой энэ хууль батлагдсанаар ААН-үүдэд болон төрд гарах зардлын тооцооллыг юу гэж тооцоолсон юм бол? Тэгээд тэрнээс дагаад тодруулъя. Ийм 3 асуулт байна.

Б.Пүрэвдорж: Хууль санаачлагч Жуковын Алдаржавхлан гишүүн хариулна.

Ж.Алдаржавхлан: Эхлээд манай НХТ-ийн газрынхан яг яаж төлөвлөдөг юм? Одоо тэр Номинчимэг гишүүний асууж байгаа газрын асуудлыг энэ хот төлөвлөлтдөө багтаахдаг сургуулийг багтааж төлөвлөдөг юм уу гэдгийг хариулаад өгчих. Дараа нь би асуултад нэмж хариу хэлье ээ.

А.Баттөмөр: Сайн байна уу? Эрхэм Улсын Их Хурлын гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Одсүрэнгийн Номинчимэг гишүүний асуултад товч бөгөөд тодорхой хариулъя.

Өнөөдөр Улаанбаатар хотын болон Монгол Улсын суурин газруудын хот төлөвлөлтийн баримт бичгийг бол Хот тосгоны барилгажилтын норм ба дүрэм 30.01.04 гэсэн энэ нормыг үндэслэж боловсруулж байгаа. Энэ дээр бол ерөнхийдөө 1 дүгээрт бид нар сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг төлөвлөхдөө 1 дүгээрт зайгаар нь төлөвлөж байгаа. 500 метр тутамд нэг сургууль байна. 250 метр тутамд нэг цэцэрлэг байна гэсэн энэ нормыг барьж төлөвлөж байгаа. Үүнээс гадна тухайн 500 метрийн радиус болон 250 метрийн радиуст байгаа хүн амыг мянган хүн ам тутамд тооцоолж тухайн сургуулийн хүчин чадлыг тодорхойлдог байгаа. Төсөл өргөн барьснаар ерөнхийдөө цэцэрлэгийн нормын дагуу төвлөрсөн сургуулийн нормоор мянган хүн тутамд заахдаа тухайн нягтралаар нь төлөвлөнө өө гэж агуулгаар яг тодорхой тоо оруулаагүй. Яг тухайн хороолол хотхоны хүн амын нягтралыг нь тооцож гарч байж сургууль цэцэрлэгийг төлөвлөө гэдэг агуулгаар хуульд оруулж өгсөн байгаа юм аа.

Хоёр дахь асуудлын хувьд бол ерөнхийдөө төрийн өмчийн сургууль байна гэж байгаа. Сургууль, цэцэрлэгийн газрын хувьд бол ерөнхийдөө бид нар томоохон хэмжээтэй 5-аас дээш га газартай, орон сууцын хороолол хотхонд бид бол сургууль, цэцэрлэгийн нормын дагуу төлөвлөлтийг тухайн ААН-ийн бол эдэлбэр газар дээр төлөвлөөд явж байгаа.

Хоёр дахь асуудал нь бол бид нар жижиг нэгж талбартай энэ газрууд байгаа. Энэ дээр бол яалт ч үгүй бид нар хот суурин газрыг дахин төлөвлөх тухай хуулийн дагуу бол тухайн нутаг дэвсгэрийн нягтралыг зайлшгүй тооцож төлөвлөх шаардлага үүсэж байгаа. Тухайн хууль батлагдсанаар бид тухайн орчны хүн амын нягтралыг

тооцож тэрэн дээр бол нэгдсэн 1 төлөвлөлт хийх замаар сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг сайжруулна гэж байгаа гэж төлөвлөсөн байгаа.

Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг бол Монгол Улсын Их Хуралд өргөн барьж хэлэлцүүлсэн байгаа. Энэ дээр ерөнхийдөө бол хэрэгцээтэй сургууль, цэцэрлэгийн нормын дагуу тухайн нормын дагуу боловсруулж гаргасан байгаа. Нийт зардлын тооцоо бол нийгмийн дэд бүтэц, эмнэлэг сургуулийн хувьд 3.9 их наяд төгрөгийн тооцоо гарсан байгаа. Тэгээд 2040 оны ерөнхий төлөвлөгөө батлагдсанаар тухайн нутаг дэвсгэр дээр хаана ямар сургууль, хэдэн цэцэрлэг, хэдэн хүн амтай гэсэн энэ нарийн.

Б.Пүрэвдорж: Үлдсэн асуултад Жуковын Алдаржавхлан.

Ж.Алдаржавхлан: Зардлын асуудал дээр Номинчимэг гишүүн. Би дараа энэ хурлын дараа мэдээллүүдийг өгье өө манай ажлын хэсэг дээр боловсруулсан улсуудаас би аваад өгье өө гэж бодож байна аа.

Б.Пүрэвдорж: Номинчимэг гишүүн нэмж тодруулъя.

О.Номинчимэг: Ер нь нөгөө иргэдээс 20 минутын хот гэдэг концепцын хүрээнд юу хүсэж байна гэхээр ерөөсөө 20 минутын дотор өөрсдийнх нь хүүхдүүдэд чанартай сайн сургууль байгаасай. Сайн үйлчилгээтэй эмнэлгийн байгууламж, эрүүл мэндийн үйлчилгээ байгаасай, ногоон байгууламж хүүхдийн тоглоомын талбай байгаасай л гэдэг юм маш чухал байгаа. Тэгээд яах вэ энэ хуулиар бол ингээд сургууль, цэцэрлэгийнх нь асуудлыг илүү шийдэж орж ирж байгаа юм байна. Ажлын хэсэг дээр эмнэлгийн асуудлаа ярих юм байна. Тэгээд төлөвлөлтийн хүрээнд ер нь энэ ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай гэдэг юм ч гэсэн стандарт нь байдаг боловч ерөөсөө хэрэгждэггүй. Одоо яг ашиглалтад орох болоход тэр тоглоомын талбай нь гарааш болчихдог. Эсвэл байгууламж болчихдог, стандартаа зөрчдөг юмнууд байгаад байгаа юм. Тэгээд энийг нэг давхар хараасай гэж бодож байна.

Хоёрдугаарт тэр газрын төлөвлөгөөтэй энийгээ маш сайн уяхгүй бол олигтой хэрэгжихгүй ээ. Бид нар төлөвлөгөөгөө гаргаад гаргаад газар олголт нь үүнийгээ дагахгүй байх юм бол ерөөсөө болохгүй. Сая ажлын хэсгээс хариулж байгаа байдлыг үзэхээр томоохон ААН-үүд өөрийнхөө газар дээрээ үүнийгээ төлөвлөөд яв.

Б.Пүрэвдорж: Нэмж нэг минут тодруулъя.

О.Номинчимэг: Хэрвээ тэгж төлөвлөж байгаа бол хэрвээ төрийн өмчит сургууль энэ ААН-ээ авсан газар дээр нь бид нар барина гэх юм бол дахиад л газраа төр буцаагаад нөхөн төлбөр өгч авах юм уу, үгүй юм уу гэдэг маш том асуудал болно оо.

Энийгээ нэг нарийвчилж тооцож яг аймаг нийслэлийн энэ ИТХ-аар энэ журам эд нараа батлахтай нэг уялдуулахгүй бол хэрэгжилт дээрээ очоод янз бүрийн асуудал гарах вий дээ гэсэн болгоомжлол байна. Тэгэхээр энэ дээр ч гэсэн хэрвээ ийм тохиолдолд төрд гарах зардлын тооцоолол нь юу байх вэ гэдгийг маш сайн харах ёстой. Тэгэхээр Алдаржавхлан дарга дараа нь гишүүн энэ юуны дараа зардлын тооцооллоо нарийн харъя. Энэ өргөн барьсан төсөл дээр бол буруу зардлын тооцоолол юу яагаад ороод ирчихсэн байх шиг байна гэж харж байна.

Б.Пүрэвдорж: Жаргалсайханы Золжаргал гишүүн асуулт асууна.

Ж.Золжаргал: Алдаржавхлан гишүүн түрүүн жишээ болгохдоо тэр Алтай хотхон, Эрин хороолол энэ тэр гээд Баянголын том хорооллуудыг эш татна лээ. Яг түгжрэл үүсгэдэг, дотроо сургууль байдаггүй, бүгдээрээ ингээд нүүдэллэж явдаг сургуультай газар руугаа маш хүнд.

Дээрээс нь энэ хойд талын гэр хорооллууд тэр хорооллын хойд талын гэр хорооллууд чинь ингээд уул руу гардаг байхгүй юу. Хүүхдүүд нь өвөл нөгөө аймаар халтиргаатай, утаатай тэгээд юу байдаг вэ? Чиглэлийн автобус байдаггүй. Мянган төгрөгийн таксинд суудаг. Мөнгө байхгүй алхдаг, жоохон хүүхдүүд. Тэгэхээр ер нь агуулгаараа энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт бол маш зөв зүйтэй юм байна гэж үзэж байгаа. Монгол Улсын хувьд орон нутгийн онцлогт нийцсэн гэр бүлдээ ойр ийм сургуулийн олон төрлийг нэвтрүүлнэ гэсэн агуулга Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт орсон байгаа.

2026 оныг боловсролын жил болгож зарласны хүрээнд энэ Наранбаяр сайд яриад яваад байгаа шүү дээ. Хорооны бага сургууль гээд. Хорооны бага сургууль гэдэг концепцтой энэ маань яаж уялдах болоо энэ талаар уялдуулах талаар бодсон болов уу? Нэг ийм асуулт байна. Тэгээд энэ хот төлөвлөлтийн талаар ярьж байгаа ташрамд хэлэхэд энэ гэр хорооллыг барилгажуулах Сэлбэ төв гээд их том төсөл байгаад байдаг. Тендер нь 400, 500 тэрбум төгрөгийн багцаар зарлачихаар зэрэг тэрний 30 хувийг ингээд бэлэн байлгаж байдаг ийм чадвартай компани, барилгын компани Монголчуудын дунд байхгүй байна гээд том хэмжээний бонд гаргаж ирсэн мөнгөө ингээд гаднын компаниуд өгч явуулахаар асуудал тулгараад баахан жагсаал цуглаан болсон. Тэгээд энд нийслэлээс хүмүүс байгаа болов уу? Энэ дээр ямар арга хэмжээ авч байгаа юм болоо? Ийм асуулт байна.

Баярлалаа.

Б.Пүрэвдорж: 4 номерын индрээс ажлын хэсгийн гишүүн Нийслэлийн хот байгуулалт хотын стандартын газрын Ерөнхий архитектурын газрын ажлын албаны дарга Амгаагийн Баттөмөр хариулна.

А.Баттөмөр: Жаргалсайханы Золжаргал гишүүний асуултад хариулъя.

Өмнө нь бол Алтай хотхон тухайн хот тосгоны барилгажилтын норм ба дүрэм одоо мөрдөгдөхгүй байгаа шалтгаан нь Алтай хотхон маршал хотхон гэх мэт сургууль цэцэрлэггүй хороолол баригдсан нь үнэн. Энийг засаж залруулахад тухайн хуулийн заалтаар хүн амын нягтрал тухайн байршлаар нь сургууль, цэцэрлэгийг нэмэлтээр төлөвлөх шаардлагатай байгаа. Энэ дээр газар чөлөөлөлтүүд хийгдэнэ. Тэрнээс гадна тухайн сургууль, цэцэрлэгийн хүртээмжийн асуудал яригдана. Тэгээд түрүүн ч гэсэн гишүүдийн дунд хэлэлцүүлэг өрнөөд ер нь бол нөгөө барилгын давхрыг нэмэгдүүлэх шаардлагатай гэдэг дээр санал нэг байгаа. Тэгээд ер нь бол тухайн нягтрал ихтэй бүсэд ер нь 960 хүүхдийн сургууль байлаа гэхэд бол нэмэгдүүлэх, 1200 болгох, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх шаардлага байдаг.

Энэнээс гадна тухайн байршил нь зай талбайгүй болчихсон байдаг.

Хоёр дахь асуудлын хувьд гэр хорооллын хойд талын уул руу гардаг хэсэг байгаа. Энэ бол маш их хүндрэлтэй бид нарын шийдэх ёстой асуудал байгаа. Бид бол Улаанбаатар хотын хөгжлийг 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө дээр тухайн одоо уул руу гарч байгаа хэсгийн хүн амын нягтралыг нь тооцоод энэ дээр нөгөө инженерийн шугам сүлжээ болон зам тавих хөрөнгийн эх үүсвэрийг нь тооцож үзсэн. Тухайн уул руу гарч байгаа хэсэг ер нь гадаад 20-оос 30 хүн амын нягтралтай. Тэгээд томоохон хэмжээний эх үүсвэр зам, тээвэр шийдвэрлэхэд эдийн засгийн хувьд үр ашиггүй байдаг аа. Энийг бол ерөнхийдөө бид хот гэр хорооллыг дахин төлөвлөж сайжруулах замаар тухайн одоо уулан дээр нэгэнт авираад гарчихсан сурвалжлалыг дахин төлөвлөнө гэсэн ийм төлөвлөлттэй байгаа 2040 оны ерөнхий төлөвлөгөөн дээр.

Монгол Улсын Засгийн газрыг 2026 онд боловсролын жил болгон зарлахтай холбоотойгоор манай байгууллага болон нийслэлийн зүгээс хамтарч ажиллаж байгаа тухай бүрд нь саналаа өгөөд яваад байршлыг нь тодорхойлох, хүчин чадлыг нь тодорхойлох нэмэлт мэдээллийг өгөх ажил дээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа. Тэгээд гэр хорооллын барилгажуулалтын Сэлбэ дэд төвтэй холбоотой асуудал дээр яг тодорхой нөгөө худалдан авалтын үйл ажиллагаан дээр тодорхой мэдээлэл алга байна.

Жаргалсайханы Золжаргал гишүүнд би ажил дээрээ очоод тан руу тодорхой мэдээллийг явуулъя гэсэн ийм байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Түр зуур зогсож байгаарай. Танай газар чинь дотроо хэдэн хэлтэстэй юм ямар ямар хэлтэстэй юм хэлээд өг дөө? Микрофон 4 номерын микрофон.

А.Баттөмөр: Манай газар бол ерөнхийдөө бүтэц орон тоогоор 99 хүний бүтэц орон тоотой байгаа. Одоогоор 50 хувь ажиллаж байна. Манай дээр Захиргаа санхүү, ерөнхий архитекторын ажлын алба, Хот байгуулалтын хэлтэс, Хот төлөвлөлтийн хэлтэс, Инженерийн бэлтгэл арга хэмжээний хэлтэс, Хотын стандартын хэлтэс, Хууль, эрх зүйн хэлтэс тэгээд Барилгын чанарын хэлтэс гэсэн ийм хэлтсүүдтэй байгаа.

Б.Пүрэвдорж: Жадамбаагийн Бат-Эрдэнэ гишүүн байхгүй байна. Батын Батбаатар гишүүн алга байна. Жанчивын Галбадрах гишүүн асуулт асууна.

Ж.Галбадрах: Өглөөний мэнд. Энэ хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах маш чухал хууль бид энийг яаралтай батлах хэрэгтэй гэж бодож байгаа энэ утгаараа дэмжиж байгаа. Тэгээд би өөрөө ч гэсэн энэ хуулийн ажлын хэсэгт бас орж ажиллах хүсэлтэй байна. Энийгээ уламжилъя. Өнөөдрийн энэ хуульд нийслэлийн ямар хүмүүс оролцож байна. Нийслэл ажлын хэсэг хуулийн энэ боловсруулах энд ямар судалгаа хийгдсэн бэ? Нийслэл дээр нэг том судалгааны төв байдаг юм байна лээ. Тэр төвийнхөн энэ тэр оролцож байгаа юу гэдгийг асууя. Ер нь хуулийн маань гол үзэл санаа бол энэ хотхонд шинээр хороолол хотхон барих үед тэнд заавал сургууль, цэцэрлэг төлөвлөө өө, өрхийн эмнэлэг төлөвлөө өө л гэсэн ийм гол зүйл байгаа юм байна.

Тэгэхээр энэ стандарт норм, журам, дүрмүүд ингээд байгаа мөртөө ерөөсөө хэрэгжихгүй яваад ирсэнд л хамаг гол асуудал маань байгаад байна. Тэгээд сая ажлын хэсгийн хүн хэлж байна. Энэ Алтай хотхон ч гэдэг юм уу энэ ингээд бид нар

энэ дээр ингээд алдсан гэж байна. Тэгвэл одоо энийг ингээд нөхөж бариулах талаар нийслэл нэлээн санаачилгатай ажиллах ийм шаардлагатай юм байна лээ.

Энэтэй холбоотой би зүгээр хамгийн эхлээд 1 дүгээрт энэ хуулийн заалт дээр энд бичсэн байна. Хот байгуулалтын тухай хуульд шинэчилсэн найруулгад нэмэлт оруулах тухай гээд 12.6.4 гээд мянга хүртэлх хүн ам эс үгүй бол 250 хүртэлх өрх тутамд 100 хүүхдийн багтаамжтай гэж ярихаасаа илүү ортой гэж яривал зүгээр. 100 хүүхдийн ортой цэцэрлэг гэж яриад байгаа. Мөн 200 хүүхдийн багтаамжтай сургууль гэж яриад байна. Энийг бол бид нар сургуулийн зураг бол 1 зургаар хийгддэг болсон байгаа. Боловсролын яам, төр өөрөө хийгээд ялангуяа төрийн сургуулийг 320, 640, 960 хүүхдийн ийм сургууль. Тэгээд бүүр том сургууль нь 1200 гэдэг ийм зураг төсөл яаман дээр Боловсролын яам өөрөө захиалаад өөрийн өмч болгоод юу гэдэг юм патент болгоод ингээд гаргаад ирсэн байна лээ. Тийм учраас хамгийн доор хаяж хамгийн бага стандарт нь 320 хүүхдийн суудалтай гэж ингэж оруулах ч юм уу ийм найруулгын зүйлийг 1 дүгээрт хэлчихье.

Тэгээд гол санаа маань Боловсролыг 2026 оныг Боловсролыг дэмжих жил болгон зарласантай холбоотой Сангийн яам, Боловсролын яам, Нийслэл ингээд хамтраад бүгдээрээ нэг тоон дээр тохирсон байгаа. Энэ ирэх 3 жилд 108 сургууль, 95 цэцэрлэг шинээр барья гэдэг энэ барих шаардлагатай. Энэ нь сургалтын чанарыг дээшлүүлэхийн төлөө, нөгөө талаас Улаанбаатар хотод байгаа тэр түгжрэл энэ асуудлуудыг хамтад нь шийдэхийн тулд энийг цогцоороо аль аль талдаа ингээд хүлээн зөвшөөрөөд гаргаж ирсэн байгаа. Тэгээд ирэх 2026 оны төсөвт бид нар сая хөгжлийн төлөвлөгөөгөө бид нар өөрсдөө танилцаж хэлэлцсэн. Энд 45 цэцэрлэг, 45 сургууль барина гээд орчихсон байгаа. Одоо газар төлөвлөлт нь хаана байршил нь явагдах вэ гэдэг асуудал яригдаж байгаа юм.

Тэгэхээр энэтэй холбогдуулаад энэ хууль бол зайлшгүй л яаралтай л гарч ирж байж л энэ асуудлуудыг шийдэхэд зөндөө асуудал хуульгүйгээс болоод зөндөө асуудал байгаа. Хуульд яг ийм тодорхой заалт нь байхгүйгээс болоод бэрхшээл тулгараад байгаа. Би энэ дээр гол миний хэлэх гол мессеж энэ талыг юу гэж бодож байна вэ гэдгийг асуумаар байгаа юм. Хууль санаачлагчаас нэг зүйл байна. Хотхон нэг шинээр барих үед сургууль цэцэрлэгийг барих зардлыг тэр компани өөрөө даана гэж ойлгож яриад байх шиг байна тиймээ Алдаржавхлан гишүүн. Компани өөрөө сургууль, цэцэрлэгээрээ өөрийнхөө хөрөнгөөр барина гээд. Энэ ерөөсөө боломжгүй хэрэгжихгүй зүйл л дээ. Би сая Казахстанд очоод судлаад ирэхэд энийг бол хотхон, тэр сургууль, цэцэрлэгийг компани нь барьдаг юм байна. Харин дараа нь 5 жилийн дараа төр нь буцааж худалдаж авч төлбөрийг нь хийдэг юм байна лээ. Энэ зарчим ямар вэ?

Б.Пүрэвдорж: Хууль санаачлагч Жуковын Алдаржавхлан гишүүн асуултад хариулна.

Ж.Алдаржавхлан: Галбадрах гишүүнтэй яг санал нэг байна. Та боловсролын салбарт олон жил ажиллаж байгаа. Бидний жаргал зовлонг маш сайн мэдэж байгаа хүн. Хуульд ямар нэгэн хэмжээгээр ч өөрөө хөрөнгийг нь гарга гэж зааж болохгүй. Тэгэхээр яг таны хэлдгээр жишээ нь Яармагт бид нар чинь нэг том хотхон хороололд улс компани нь газар гаргаад, улс хөрөнгийг нь гаргаад сургууль барьж байгаа шүү дээ. Хан-Уул дүүргийн 23 дугаар хороонд. Энүүгээр ч явсан болно. Өөр үнэхээр хүчин чадалтай нийгмийн хариуцлагаа хүлээгээд сургууль барих бололцоотой компани байвал барьж өгч болно. Тэрийг хааж болохгүй.

Галбадрах гишүүнээ тийм компани байвал тэрийг хаах хэрэггүй. Яг таны хэлснээр улс дараа нь худалдаж авах тэр эрх чөлөөг нь нээж өгч байгаа байх? Тэрийг нь дараа нь зохицуулж болно л гэж үзэж байгаа юм. Хууль дээр зөвхөн тоо, ор, тоо хэмжээг оруулж байгаа юм байна. Таны тэр редакцын саналуудыг хүлээж авч болно.

Б.Пүрэвдорж: Галбадрах гишүүн нэмж тодруулья.

Ж.Галбадрах: Баярлалаа. Тэгээд ер нь яг хотхон дотор нь л Ерөнхий архитектур гэж хүн батлахдаа сургуулийг заавал ингэж шаардаж байгаа. Тэгээд яг батлах үедээ заачхаад тэр сургуулийг ямар хөрөнгөөр яаж барих вэ гэдэг асуудал нь л гарч ирээд байгаа юм. Тэгэхээр энэ дээр л угаасаа Улаанбаатар хот дүүрэг маань өөрсдөө ингээд сургууль, цэцэрлэг маш их хэрэгцээ шаардлагатай байдаг. Газраа олж чадахгүй байгаа. Тэгвэл одоо өнөөдөр тэрэн дотор нь газрыг нь гаргаад тэр компаниар нь өөрсдийг нь бариулах хэрэгтэй.

Тэгэхдээ төсөв мөнгөнд нь хязгаарлалт, өнөөдөр төсөвт бид нар 320 хүүхдийн сургуулийг хэдээр барих вэ, 960-ыг хэдээр барих вэ гэдэг нэг улсын төсөвт тусгасан тэр үнэ дээр шаардлагаа өндөр шаардлагуудаа тавиад ингээд хийх тал дээр бас энийгээ хууль дээрээ бүүр ийм тусгаж өгөх л ийм л шаардлагууд байна л гэж бодож байна.

Тийм учраас энэ саналаа тодорхой хэмжээнд бичгээр болон ажлын хэсэгт орж ажиллаж өгье өө гэж ингэж бодож байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Отгоны Саранчулуун гишүүн асуулт асууна.

О.Саранчулуун: Өглөөний мэнд. Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга дотор хүртээмж саадгүй байдлын талаар яг ямар ямар зохицуулалтыг оруулсан бэ гэдэг асуултыг асууя. Яагаад гэхлээр тэр саадгүй байдал, хүртээмж гэдгээ яг энэ хуулийн хүртээмж гэдгээ юу гэж ойлгосон юм. Томьёолол байна уу гэдэг дээр хариулаад өгөөч.

Б.Пүрэвдорж: Хэн хариулах вэ? Жуковын Алдаржавхлан гишүүн асуултад хариулья.

Ж.Алдаржавхлан: Би хариулья даа. Яг тийм саадгүй байдал энэ тэр гэсэн тийм юу байхгүй дээ. Саранчулуун гишүүн. Би зүгээр энэ хуулийг зөвхөн сургууль цэцэрлэгийн хүртээмжийг сайжруулах чиглэлээр л боловсруулсан. Сургууль цэцэрлэгийн хамгийн хүнд нөхцөл байдалд байгаа хуучин би орон нутагт ажиллаж байсан хүний хувьд бидэнд хамгийн их тохиолддог бэрхшээл юу вэ гэхлээр сургууль, цэцэрлэггүй хотхон хороололд баригдчихдаг. Очихлоор нөгөө 1 ерөнхий академик гэдэг хүний зөвшөөрөлтэй байдаг байхгүй юу. Одоо энэ хууль батлагдчих юм бол бид нар хуулиа барьж очиж шаардаж болох юм. Үгүй энэ хууль дээр чинь чи сургуультай байна гэсэн шүү дээ. Чиний сургууль чинь хаана байна гэж бид нар шаардаж болох байхгүй юу. Цэцэрлэгтэй байна гэсэн тэр нь хаана байна гэж бид нар шаардаж болох эрх бид нарт үүсэх юм.

Тийм учраас одоо тэр энэ хууль батлагдсан нөхцөлд үүнээс хойш дахиж сургууль цэцэрлэггүй, 10 мянган хүнтэй, 5 мянган хүнтэй хотхон хорооллыг хэзээ ч барьж болохгүй л гэж үзэж байгаа юм. Тэгээд энэ хариуцлагын асуудалд орж

байгаа. Бүр энэ дагаж мөрдөх журмын тухай хууль дээр байгаа шүү дээ. Хэрвээ одоо баригдаж байгаа нөхдүүд шаардлагад нийцүүлэхгүй бол тусгай зөвшөөрлийг нь барилгын ажлын зөвшөөрөл хүчингүй болгоно л гэж байгаа юм. Энэ мэтчилэн хатуу арга хэмжээнүүдийг нэлээн авахаар энэ хуулийн төсөлд оруулсан.

Б.Пүрэвдорж: Отгоны Саранчулуун гишүүн нэмж тодруулъя.

О.Саранчулуун: Би санал тэгвэл зүгээр санал өгчихье гэж бодоод байна. Санал дээр яг 12.6.4 дээр жишээлбэл 250 хүртэлх өрх тутамд нэгээс доошгүй цэцэрлэг, мянга хүртэлх өрх тутамд нэгээс доошгүй төрийн өмчит сургуулийг төлөвлөж, төлөвлөж тооцох, саадгүй байдал, хүртээмжийг тооцох гээд оруулчихвал илүү бодитой гэж болох гээд байна, нэгдүгээрх санал нь.

Хоёр дахь санал ер нь бол 1 дүгээрт сургууль, цэцэрлэг дотроо гэхээсээ илүү сургууль, цэцэрлэг рүүгээ явж байгаад хүүхдүүд их гэмтдэг. Явган хүний тэр сургууль цэцэрлэгт явах замыг тэр эргэн тойрны радиусыг аюулгүй байдлыг нь тооцсон ийм тооцооллыг оруулах хэрэгтэй. Тэрийг нь харин яг аль хэсэгт нь оруулахыг би мэдэхгүй байна. Ямар ч байсан миний зүгээс эхний ээлжид бодитойгоор хэдүүлээ саадгүй байдал хүртээмжээ тооцчих хэрэгтэй. Угаасаа энэ хууль удахгүй ярихаас хойш тиймээ. Ийм саналтай байна.

Б.Пүрэвдорж: Би Амгаагийн Баттөмөр гишүүнээс нэг асуулт асуугаадахъя. Яг энд ирсэн дээр нь таны ажил үүрэгтэй холбоотойгоор. Танай байгууллагад Хот байгуулалтын хяналтын хэлтэс гэж байдаг юм байна. Тэгээд газрын зөвшөөрөл, барилгын газрын зөвшөөрөл ус, цахилгаан, дулаан, онцгой эрүүл ахуй гээд баахан зөвшөөрлүүдийг бүгдийг нь авчихсан. Тэгээд зургаа батлуулчихсан. Тэгээд энэ хүмүүсийн зөвшөөрөл гарчихсан. Байгууллагуудын зөвшөөрөл гарчихсан байж байхад дахиад танай хэлтэс чинь ажил эхлүүлэх зөвшөөрөл гэж өөрсдөө өрөөнөөс гарахгүй, зөвшөөрөл өгдөг. Ийм бүтэц дотроо бий болгочихсон байна. Зөвшөөрөл дээр зөвшөөрөл олгодог. Тэгээд лам юм уу? Үгүй ядаж өдөр судрыг нь үзүүлээд л энэ чинь газар лус савдаг хөндөнө гээд нэг өдөр хардаг байж болно. Ламд ханддаг байж болно. Тэгэхдээ танайх тэдний өдөр эхэл гэдэг ийм зөвшөөрөл тэртээ тэргүй гарчихсан бүх зөвшөөрөл дээр дахиж зөвшөөрөл өгдөг энэ чинь ямар учиртай юм бэ?

Дахиад нэг авлигалын хүмүүсийг гацаасан нэг тийм нэмэлт бүтэц юм биш үү? Энэ дээрээ нэг тайлбар өгөөдхөөч.

А.Баттөмөр: Хурал даргалагч Пүрэвдорж гишүүнд нөгөө түрүүн асуултад хариулахдаа дутуу хариулсан байна. Гүйцээгээд хариулчихъя. Энэ дээр бол манай байгууллага ерөнхийдөө 11 хэлтэстэй байгаа. Дутуу нэрлэгдсэн хэлтсийн хувьд хотын орон зайн мэдээлэл, технологийн хэлтэс, хот байгуулалтын инженерийн дэд бүтцийн хэлтэс, дэд төв, дагуул хотын хэлтэс гэдэг энэ хэлтсүүд байгаа. Бид нар бол ерөнхийдөө бол газрын үйл ажиллагааны хувьд бол барилгын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл олгож байгаа. Энэ маань Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 213 дугаар тогтоолоор барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм гэдэг энэ эрх зүйн баримт бичгийг мөрдлөг болгон ажиллаж байгаа. Тухайн дүрэмд бол ерөнхийдөө таны дээр дурдсан бүх бүрдэл хангагдсан тохиолдолд ямар нэгэн нэмэлт бичиг баримт шаардахгүйгээр барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг бол олгох үүрэгтэй байгууллага. Тэгээд энэ дээр бол ерөнхийдөө бол нөгөө ажлын ачааллын асуудал ярина. Тухайн хэлтэс

маань 10 хүний хүчин чадалтай байлаа гэхэд тухайн яг барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл дээр одоогоор 3 хүн зөвшөөрөл өгөөд сууж байгаа.

Энэ нь ерөнхийдөө нөгөө ажлын ачаалалтай холбоотойгоор тухайн иргэн ААН-үүдийг хүндрүүлэх зүйл байж магадгүй ээ. Танд тэгээд тодорхой яая.

Б.Пүрэвдорж: Эргээд үгүй наадхаа тэртээ тэргүй бүх зөвшөөрлүүд нь гарчихсан тэгээд угаасаа наадах байгууллага чинь тэр дүрмээрээ өөрөө үүрэгтэй юм байна. Танай байгууллага чинь өөрөө үүрэгтэй. Тэгэхээр наадхаа шууд цахимжуул л даа. Өөрөөр хэлбэл нөгөө зөвшөөрлүүдээ шивсэн тохиолдолд шууд ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх тэр зөвшөөрөл нь шууд гардаг тийм цахим программ бичээд л болох юм байна шүү дээ.

Тэгээд тэр ажлын ачаалал гэж юу яриад байгаа юм бэ? Наадах чинь одоо энэ Зөвшөөрлийн тухай бол Хассуурийн Ганхуяг гишүүний санаачилж батлуулсан Зөвшөөрлийн хуулийн дагуу маш хурдан шийдвэрлэх ийм л асуудал байгаа юм байна. Тэгээд ер нь хэргээр гацааж байгаа л даа. Ажил их байна гээд л гацаагаад л. Тэгж байгаад л нэг хэдэн төгрөг цохиж аваад л тэгээд л нэг зөвшөөрөл өгсөн болдог л ийм л нөхдүүд байна л даа. Наадхыг чинь жоохон шалгана шүү. Наадхаа цахимжуулаарай. Өөрсдийнхөө бичиг баримтыг шивсэн тохиолдолд шууд барилга эхлүүлэх үргэлжлүүлэх тэр зөвшөөрөл нь гардаг. Тэгээд тэрнийхээ дагуу тэр хэн нэгэн дарга дээр очихгүйгээр, танай хот руу очихгүйгээр, байгууллага руу чинь очихгүйгээр шууд ажлаа эхлүүлдэг болгох хэрэгтэй.

Үг хэлэх гишүүд. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн үг хэлнэ. Индрийн 2 дугаар номерын микрофоноос.

Уучлаарай би одоохон нэг юм хэлье. Үүний дараагаар 30 зарчмын зөрүүтэй саналтай санал хураалт явагдана. Тийм учраас гишүүдийг танхимдаа цуглахыг хүсэж байна аа.

Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн индрийн 2 номер.

С.Эрдэнэболд: Ажлын хэсгийн гишүүдэд хандаж 2 агуулга хэлэх гэсэн юм Алдаржавхлан гишүүн ээ.

Нэгдүгээрт энэ хот байгуулалтын асуудал гэдэг бол өөрөө асар том цар хүрээтэй ажил. Тэгэхээр аливаа шийдвэр гаргахдаа, аливаа шийдвэр гаргахдаа ямар ямар суурь судалгаанууд дээр, мөн төсөөтэй аргын загварчлал буюу ямар симуляцыг хийх вэ гэдэг маш чухал байна аа. Ер нь бол манай улсын үе үеийн Засгийн газрууд болон хотуудын гаргаж байгаа шийдвэрүүд нь сүүлийн жилүүдэд асар огцом болсон. Нэг өглөө босоход л бордюр хуулчихдаг, нэг өглөө босоход л нэг шинэ дүрэм гарчихдаг. Нэг өглөө босоход л татвар нэмчихдэг ийм асуудал гарсан.

Тэгэхээр ажлын хэсэгтээ хандаж хэлэхэд бол 2 зүйлийг цаашдаа анзаарч авч үзээч гэж хүсэх гэж байгаа юм.

Нэгдүгээрт энэ симуляцыг маш сайн хийх ёстой байгаад байна. Их Хурлын чуулган дээр хэлэлцэх гэж байгаа энэ тайлбарлагдаж байгаа зүйл бол яг тухайн үедээ ингээд яваад өнгөрчихдөг. Мэдээлэлтэй ойлгож байгаа хүмүүс нь ойлгоод

өнгөрчихдөг. Гэтэл жирийн иргэдэд нөгөө ойлгомжтой байх одоо энэ шинэ Ерөнхий сайд чинь болохоор зөвлөлдөх ардчилал гэж санаачилж хийж байсан шүү дээ. 2015 оны 5 сарын 3-нд тэр зөвлөлдөх ардчиллын механизм чинь бол яаж байна гэхлээрээ тодорхой томоохон шийдэл гаргах асуудал дээр иргэд олон нийт нэг өөр байр суурьтай мэргэжлийн хүмүүс, хууль санаачлагчид нэг өөр байр суурьтай байгаа бол тодорхой төлөөллүүдийг өргөн хүрээтэй аваад тухайн асуудал дээр танин мэдэхүйгээс нь өгсүүлээд мэргэжлийн асар нарийн мэдээллүүдийг хоорондоо хуваалцаж дундын зөвшилцлийн шийдвэр гаргах тэр механизм байдаг.

Тэгээд энэ хотын асуудал дээр бол яг ийм зөвлөлдөх ардчиллын зарчим гэдэг шиг иргэддээ мэдээлэлжүүлсэн иргэдийн оролцоог хангах ёстой. Өмнө нь бид нар чинь одоо иргэний танхимууд гэж арваад жилийн өмнө байгуулаад тодорхой асуудлууд дээр бодлогын хийгээд үнэт зүйлсийн асуудлууд дээр Иргэний танхимын хэлэлцүүлгүүд хийдэг байсан. Тэгэхээр энэ байхаа больчихсон.

Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүд бол мэдээж бид нар хууль тогтоох тодорхой шийдвэр гаргах эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа ч гэсэн бүгдийг мэдэх боломж байхгүй учраас аль болохоор гаргаж байгаа шийдвэрүүдээ иргэдийн дэмжлэгтэй байх үүднээс иргэдэд илүү мэдээж, тэд нарын оролцоог хангах тал дээр нь анхаараач гэдэг хүсэлт байгаа.

Хоёрдугаарт энэ симуляц гэдэг асуудал байгаа юм аа. Юу гэхлээр энийг энэ төслийг явуулснаар, энэ хуулийн үйлчлэлийг бий болгосноор жишээлбэл 10 жилийн дараа гэхэд нийгэм, эдийн засгийн ямар үр дүн өгөөж бий болох юм бэ? Түрүүн Алдаржавхлан гишүүн хэлсэн шүү дээ. Хүний эрхийг, хүүхдийн эрхийг хангахын тулд энийг хийх гэж байгаа гэсэн. Энэ төслийг одоо энэ концепцыг хэрэгжүүлснээр яг хэмжигдэхүйц нөгөө Лувсанжамц гишүүний байнга хэлээд байгаа, хэмжигдэхүйц ямар үр дүнгүүд гарах юм? Энэ нь 10 жилийн дараа, 20 жилийн дараа, 30 жилийн дараа гэдэг энэ симуляц модуль буюу энэ төсөөтэй аргачлалын загварчлалаар энэ асуудлаа гаргаж ирэх юм бол маш их хэрэгтэй байгаа юм.

Жирийн иргэд ч гэсэн ойлгомжтой, хялбар байдлаар яаж ойлгомжтойгоор хүргэх юм бэ гэж. Тэгэхээр Монголчууд хэлдэг шүү дээ. 7 хэмжиж нэг огтол гэж. Тэгэхээр 7 хэмжих процессыг нь энэ үйл явцдаа иргэдийн оролцоог маш олон байдлаар хангаач гэж. Тэгэхээр мэдээж мэргэжлийн хүмүүс бол яг энэ нарийвчилсан яг төсөл хөтөлбөртэй холбоотой эдийн засгийн үр дүн төсөөллүүдийг гаргах байх. Гэхдээ төрийн бодлого иргэдэд итгэл үнэмшил төрүүлж байж дэмжлэг авдаг тэгж байж урт хугацаанд үйлчилдэг гэсэн. Тэгээд энэ 2 агуулгыг ажлын хэсгийнхэнд зориулж хэлье ээ. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10.12-т хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно гэдэг энэ заалтын дагуу санал хураалтыг түр хойшлуулъя.

11.34 цаг

Дараагийн асуудалдаа орж байя. Хэлэлцэх асуудалдаа орьё.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна аа.

Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэг танилцуулъя. Индэрт урья.

О.Номинчимэг: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар нарын 9 гишүүнээс 2025 оны 1 дүгээр сарын 23-ны Өд өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг 2025 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр Улсын Их Хурал чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн билээ.

ХЗБХ-ны 2025 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 03 дугаар тогтоолоор Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэг ахалж, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Ухнаагийн Отгонбаяр, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Сүхбаатарын Эрдэнэболд нар болон холбогдох бусад албан тушаалтнууд ажиллалаа.

Хууль зүйн байнгын хороо 2025 оны 6 дугаар сарын 4 болон 10-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцсэн болно оо.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг хуулийн төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томьёололтой холбогдуулан асуулт асууж хариулт авсан болно.

ХЗБХ-ны хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалан, Пүрэвжавын Сайнзориг, Д.Энхтүвшин нараас гаргасан саналуудыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.20 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэж дараах санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна аа.

Үүнд:

1.Хуулийн төслөөр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд хязгаарлалт нь зорилгодоо нийцсэн бодит нөхцөлд тохирсон боломжит хамгийн бага түвшинд байх шаардлага хангасан эсэхийг хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ нэмж тусгахаар,

2.Тухайн жилийн улсын төсөв төсвийн тодотголын хуулийн төслийг дагалдуулан зөвхөн тухайн жилийн төсөвт нөлөөлөл үзүүлэх хууль тогтоомжийг төслийг өргөн мэдүүлэх бөгөөд энэ тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслийн төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэлд үзүүлэх нөлөөлөл, холбогдох тооцоо, цолыг хуулийн төслийн танилцуулгад тодорхой тусгахаар.

3.Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээг хөндлөнгийн судлаач хуулийн этгээдээр гүйцэтгүүлэхээр.

4.Төсөлд тусгагдсан Хууль тогтоомжийн төслийг баталснаар үүсэх зардлын тооцоог үнэлж тодорхойлох шаардлагаас эдийн засагт үзүүлэх нөлөөллийг үнэлэх асуудлыг хасахаар.

5.Хуулийн төслийн захиргааны хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалтад тусгахыг хориглосон зохицуулалтаас 27¹.2.3 буюу албан татвар төлбөр хураамж тогтоосон харилцааг хасахаар.

6.Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолоор хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хууль санаачлагчид мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий төрийн холбогдох байгууллагын албан хаагчдыг холбогдох аргачлал, арга зүйгээр хангах, чадавхжуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж хэрэгжүүлэх.

Хуулиар тусгайлан эрх олгогдоогүй бөгөөд нийтээр заавал дагаж мөрдөгдөхөөр баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг хүчингүй болгох.

Хуульд заасны дагуу баталсан боловч бүртгүүлээгүй захиргааны хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудын удирдлагад даалгахаар.

7.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр, томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх зэрэг болно.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Пүрэвдорж: Отгончимэг гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя. Наранчулууны Отгончимэг-Улсын Их Хурлын даргын зөвлөх, Чулуунбаатарын Дондогмаа-Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга, Нармандахын Жамъянхүү-ХЗДХЯ-ны Хууль зүй бодлогын газрын дарга, Шагдарсүрэнгийн Цолмон-ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын хяналт бүртгэлийн хэлтсийн дарга.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харгиа харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна аа.

Энэ хуулийг дэмжиж байгаа. Манай Дамдины Цогтбаатар гишүүн ер нь их либерал хүн юм байгаа юм. Тийм учраас энэ дүрэм журмыг цэгцлэх эмхэтгэх багасгах энэ ажил дээр энэ сайн хуулийг оруулж ирж байгаа. Тэгэхээр би дүрэм журам яаж төрийн байгууллагад нөлөөлдөг талаар би нэг ганцхан жишээ хэлж өгье. Та Мөнхтуяа гишүүн жоохон чимээгүй байж байгаач.

Тэгэхээр 2012 онд би ГИХГ-ын даргаар томилогдсон. Тэгээд очингуут миний ширээн дээр асар их бичиг баримт ороод ирсэн. Юун энэ нь юун бичиг баримт юм бэ гэсэн чинь Баян-Өлгий аймгийн Цагааннуурын боомтоор шатахуун зөөвөрлөж байгаа Оросын жолоочид хүртэл олон удаагийн визийг өгөхөд Улаанбаатар хотод газрын дарга нь зөвшөөрөл олгож өгдөг ийм тогтолцоотой байсан. Энэ тэгэнгүүт хуулийг нь ингээд манайх хоёрхон хуультай. Тэр хуулийг нь аваад үзэх дээр Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулиар зөвхөн тэр хил дээрх визийг тухайн байцаагч мэргэжилтэн олгох хуулийн зохицуулалттай. Гэтэл газрын дарга нь журам гаргаад тэр бүх эрх мэдлийг бүгдийг нь Улаанбаатар хот руу аваад ирчихсэн байсан. Тэгээд энэ дүрэм журамд нь нийтдээ 2 хуультай.

Тэгсэн мөртөө 86 журамтай. Тэр 86 журмаар бүх эрх мэдлийг бүгдийг нь Улаанбаатар хотод бүх дарга нар шийддэг. Ийм эрх мэдэлтэй болгочихсон байсан. Тийм учраас энэ дүрэм журамд нь өөрчлөлт оруулаад хуулийн дагуу хуульд нийцүүлээд 86 журмаас 44-ийг нь хүчингүй болгоод, 51 хувийг нь хүчингүй болгож ингэж хүчингүй болгосны үр дүнд жишээ нь Ховд аймагт Гадаадын харьяатын газрын 7 хүнтэй ажилтантай тэр 7 хүн бүтэн жилийн хугацаанд хорин гуравхан виз олгодог байсан. Бүтэн жилийн хугацаанд хорин гуравхан. 1 хүн гуравхан виз олгодог. Тэгээд энэ дүрэм журамд өөрчлөлт ороосны үр дүнд 2013 он гэхэд нийтдээ 6 мянган визийг хил дээр олгодог болсон. Тухайн байгууллага 7 хүнтэй өдөртөө жилдээ нэг 20-оод сая төгрөг аймгийн төсөвт хураамжаар оруулдаг байсан бол 2013 онд 600 сая төгрөг болсон. Тэр хилийн цаад талд байж байгаа манай Монгол үндэстэн наад талд байгаа нэг цаад талдаа 100 км-т байгаа хүмүүс. Наад талдаа нэг 50 км-т Булган сум орж ирэхийн тулд Хөх хот Бээжин явдаг. Тэндээсээ Замын-Үүдийн хилээр орж ирээд Улаанбаатарт очоод Улаанбаатараасаа Ховд нисээд, Ховдоосоо 400км явж Булганд очдог. 150 км яваад ирэх газар ингэж 7, 8 км явдаг ийм л тогтолцоотой байсныг өөрчилсөн. Үүний үр дүнд маш их тийм өөрчлөлтүүд ирсэн байгаа.

Тэгэхээр ер нь энэ дүрэм Хууль тогтоомжийн тухай хуульд өөрчлөлт оруулснаар иргэдэд илүү аятайхан зөөлөн ямарваа нэгэн төрийн дарамтгүй ийм хуулийн өөрчлөлт хийх ийм боломжийг бий болгож байгаа юм аа. Тийм учраас гишүүд энэ хуулийг дэмжиж манай либерал маш хуулийн өөрчлөлтийг маш сайн хийхийн төлөө зүтгэж байгаа манай ХЗБХ-ны хамгийн сайн Байнгын хорооны дарга

Дамдины Цогтбаатар гишүүний санаачилсан энэ хуулийг дэмжиж өгөөрэй гэж хүсье ээ. Би үг хэллээ.

Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна.

Б.Бат-Эрдэнэ: Хамгийн сайн Байнгын хорооны даргаа дэмжиж байна яах вэ. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай бид нар нэг зүйлийг маш сайн бодмоор байна аа. Энэ хариуцлагагүйн зудтай холбоотой асуудал яалт ч байхгүй байна. Энэ төрийн албан хаагчдыг яаж хууль уншиж сургадаг юм. Яаж хуулийн хэрэгжилтийг хангахгүй бол хариуцлагын тогтолцоо очдог гэдгийг ойлгуулдаг юм. Хэцүү зүйлсүүд нэлээн байна. Хуульд тусгайлан заагдаагүй, тусгайлан эрх олгогдоогүй, тэгсэн мөртөө энэ нийтээр дагаж мөрдүүлэхээр баталсан дүрэм журмуудтай холбоотой асуудлууд байна, нэг.

Нөгөөдөх нь хуулиар тусгайлан эрх олгогдсон мөртөө нийтээр дагаж мөрдөхөөр батлуулаагүй дүрэм журамтай холбоотой асуудлууд байгаа. Хэн нэгэн албан тушаалтан дураараа нэг юм гаргачихдаг. Одоо саяын Пүрэвдорж даргын хэлж байгаа шиг юм гаргачхаж байгаа юм. Тэгээд эцсийн хариуцлага нь бизнес эрхлэгчид хохироод дуусдаг. Тэр их хариуцлага хүлээдэг субъект байхгүй болчихсон. Тэр дураараа дүрэм журам өөрчилсөн даргыг хэзээ ч хариуцлага татдаггүй. Энэ хэлбэрийг бид нар 1 дүгээрт энэ Хууль тогтоомжийн тухай хуультай холбоотой асуудал дээр нэгэнт нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа учраас энийгээ бид нар олж хармаар байна гэдгээ хэлмээр байгаа юм.

Хохирлын асуудал энд яригдаж байгаа. Бизнес эрхлэгчдийн маш том хохиролтой холбоотой асуудлууд энд хөндөгдөж байгаа гэдгийг нэгдүгээрт анхаараасай гэж хүсэж байгаа юм.

Хоёрдугаарт энэ чиг үүргийн давхардалтай холбоотой асуудлууд байна. Хууль тогтоомжийн тухай хууль уул нь хэрэгжих ёстой. Гэтэл одоо бид нар харж байна шүү дээ. Үндэсний хороо, Үндэсний зөвлөл, үндэсний комисс 50 гаруй байгууллага бий болчихсон. Эрчим хүч гэхэд саяын ДЦС 3-тай холбоотой асуудал ЭХЯ, Эрчим хүчний зохицуулах хороо, Эрчим хүчний үндэсний хороо Эрчис Монгол. Одоо ингээд чиг үүргийн хувьд энэ чинь бүр давхардал нь бүр ёстой замаа алдчихсан. Тэгээд ингээд харахаар энэ чиг үүргийн давхардалтай холбоотой асуудлуудаа бид нар энэ Хууль тогтоомжийн тухай хуулиараа шийдвэрлэх шаардлагатай юм шиг харагдаж байгаа юм.

Бид нар дагах хуулиудтай холбоотой асуудал гэдгээ их сайн бодож хөндөхгүй бол яг ний нуугүй хэлэхэд энэ хуулийн хэрэгжилт явахгүй байгаа учраас зарим Улсын Их Хурлын гишүүд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах агентлаг байгуулах асуудал хүртэл дахиад яриад явж байна шүү дээ. Энэ чинь тухайн холбогдох байгууллагууд нь ажлаа хийхгүй байна л гэсэн үг. Тэгэхээр бид нар хууль уншдаг дарга нартай болмоор байна. Хуулиа мэддэг дарга нартай болмоор байна. Хуулийг хэрэгжүүлэхгүй бол өөрөө дураараа өөрчлөх юм бол хариуцлага хүлээдэг тогтолцоотой болно.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя.

Х.Баасанжаргал: Надад энэ Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбоотой 1 асуулт, нэг санал байна. Тэгэхдээ миний хэлэх гэж байгаа санал бас асуулттай холбоотой учраас та бүхэн бас хариулаарай. Ажлын хэсгийн зүгээс гэсэн үг. Ер нь бол яах вэ одоо бол энэ удаагийн парламент хэлэлцэх хууль цөөхөн байна. Өмнөх парламент нэг удаагийн чуулганаараа тэдэн хууль хэлэлцдэг байсан байна гээд ингээд нэг ийм тооны хойноос нэг ийм яарах маягтай л байгаад байна.

Тэгэхээр энэ дээр би бол харин эсрэгээрээ одоо бол бид нар аягүй чанартай хууль батлах ёстой. Хүний эрхийн зөрчилгүй хууль батлах ёстой, хүний эрхийн хязгаарлалт хамгийн бага түвшинд маш сайн судлагдсан хуулийг бид нар батлах ёстой гэдэг ийм байр суурьтай байгаа. Тэгээд одоо манай хуульч гишүүд бүгдээрээ мэдэж байгаа байх. Бид нар Үндсэн хуулийн цэц дээр очоод л өмнөх парламентын баталсан хуулийн очоод л тэгээд л нөгөө судалгаа янз бүрийн юмнуудыг нь хайхаар юм нь байхгүй. Асар их дутуу, дулимаг судалгаатай ингээд л хуулиуд баталчихсан. Тэгээд л Цэцийн өмнө очоод л уулзаад л байдаг. Бид нарын улалзах ч бол яах вэ гэхдээ тэр хууль чинь өөрөө өнөөдөр хүний амьдралд хэрэгжээд хүний эрхийг хязгаарлаад явж байна гэдэг чинь өөрөө асар их хортой үр дагавартай байхгүй юу. Тэгэхээр хууль батлагдах энэ процесс өөрөө маш сайн чанартай байх ёстой гэдэг хувь хуульчийн хувьд бол би тийм байр суурьтай байгаа.

Тийм учраас одоогийн энэ Хууль тогтоомжийн тухай хуульд орж байгаа өөрчлөлт манай зарим гишүүд энд бас аягүй эмзэглээд байгаа юм. Одоо хууль батлагдахад хэцүү болох гээд байна. Энэ хуулийг батлах юм бол аягүй олон шаардлага хангасан байх гээд байна. Олон судалгаа шаарддаг болох гээд байна гээд ингээд манай гишүүд жаахан тэн дээр нэг ийм байр суурь илэрхийлээд байх шиг байгаа юм.

Тэгэхээр энэ дээр ер нь энэ хууль батлагдах, хууль боловсруулах үйл явц өөрөө концепцын үед ямар байх ёстой юм бэ гэдэг дээр энэ судалгаа хийдэг хүмүүс энэ ажлын хэсэгт орсон байгаа учраас энэ дээр хариулаасай гэж бодож байна.

Асуулт нь энэ гэсэн үг тиймээ.

Тэгээд 2 дугаарт гэвэл бид нар энэ хүний эрхийг хамгийн бага түвшинд хязгаарласан байх ёстой бөгөөд тэр олон хувилбаруудаас түүнийгээ судлаад оруулж ирээд миний энэ боловсруулсан хууль тогтоомж ийм хэмжээнд хүний эрхийг хязгаарлана. Энэ олон хувилбаруудаас сонгоод энэ энэ хувилбаруудыг үзэхэд ийм юм байна гэдэг ийм л судалгаатай хууль маань дагалдаж орж ирдэг баймаар байгаад байгаа юм. Тэгэхээр яг үүнтэй холбоотой тавигдаж байгаа шаардлага босго хэрхэн өндөр болж байгаа вэ гэдэг ийм асуулт. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: 1995 онд БНД-ийн ерөнхий боловсрол боловсролын сургуулийг төгссөн төгсөгчид чуулганы танхимд орж ирсэн байна. 30 жилийн ойгоо тэмдэглэж байгаа багш сурагчид та бүхэнд мөн түүнчлэн яг энэ анги ангидаа хамт төгссөн Цэндийн Сандаг-Очир гишүүн та бүхэндээ нийт Их Хурлын гишүүдийнхээ өмнөөс гүн талархал илэрхийлье ээ. Эрүүл энх сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Отгоны Номинчимэг гишүүн хариулна.

О.Номинчимэг: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя.

Яалт ч үгүй бид нар хуульч гишүүний хувьд ч гэсэн Улсын Их Хурал чанартай хууль хэрэгждэг хууль гаргахын тулд сая хэлсэн саналуудыг маш сайн тусгаж харах ёстой. Тэгээд амьдрал дээрээ тэр маань хэрэгждэг байх ёстой. Тэгээд ер нь Улсын Их Хуралд орж ирж байгаа хуулиудыг харахаар зардлын тооцоолол нь дутуу байдаг ч юм уу үр нөлөө нь муу байдаг ч юм уу тиймээ. Уялдаа холбоог нь сайн хараагүй ч байж байдаг юм уу. Энэнээсээ болоод бид ер нь тийм нэг нөгөө хууль тогтоомжийн бараг түгжрэл рүү орчхоод байгаа. Тэрнээсээ үүдээд ямар ч хэрэгждэггүй эсвэл хэрэгжихээрээ буруу хэрэгжчихдэг ийм юм руу л орчхоод байгаа.

Тэгэхээр энэ хуулийн хууль тогтоомжийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаагийн нэг уг нь энэ үзэл баримтлал нь энэ байгаа. Таны асуусан яг энэ хүний эрхтэй холбоотой асуудлаар Хууль тогтоомжийн хуульд нэг шинэ уг нь үнэлгээний аргачлалыг нэвтрүүлж байгаа юм тэгээд тэр нь хэрвээ хууль тогтоомжийн санаачилж байгаа хүн маань хуулиараа тэр маань ихэвчлэн Засгийн газар байх юм уу. Хуулиар хүний эрх эрх чөлөөг хязгаарлах ийм зохицуулалт орж ирэх гэж байгаа бол яг одоо олон улсын жишигт байдаг зорилгодоо нийцсэн байгаа юм уу, зорилго нь юу юм хууль ёсны байгаа юм уу, арга хэмжээ нь тохирсон байгаа юм уу, авч болох хамгийн бага арга хэмжээгээр байгаа юм уу гэдэг энэ шалгуур үзүүлэлтээр аргачлалаар өөрөө энийгээ тооцоолж үнэлээд оруулж ирнэ гэдэг ийм нэмэлт шаардлагыг тус тусгасан. Мөн хэрвээ хүний эрх чөлөөтэй холбоотой ийм хууль оруулж ирэх гэж байгаа бол Засгийн газар ч бай өөр бусад хууль санаачлагч ч бай заавал Хүний эрхийн комиссоос саналыг нь авахаар явуулдаг байна гэдэг ийм шаардлагыг оруулж өгч байгаа.

Харамсалтай нь яах вэ Байнгын хороон дээр бид нар ирцийн асуудлаас болоод яг энэ нөгөө үнэлгээний асуудал дээр нэг бас бага зэрэг өөрчлөлт хийж нэг сайжруулсан хувилбар маань уначихсан байгаа. Тэгэхээр одоо зарчмын зөрүүтэй санал хураах үеэр энэ дээр бол хурал даргалагчаас чиглэл авах хэрэгтэй байгаа. Ер нь ингэж бас хууль боловсруулагч нь өөрөө үнэлгээ хийхээс гадна энэ аргачлалын дагуу хязгаарлалт хийх гэж байгаа үнэхээр боломжит хэмжээнд байна уу, хуулийн дагуу байна уу үндэслэл нь тохирсон байна уу гээд энэ аргачлалын дагуу хийдэг болох юм бол аяндаа бид нар энэ чинь бид нарын гаргаж байгаа хууль тогтоомж маань хүний эрхэд яаж нөлөөлөх гээд байна гэдгээ илүү хаа хаанаа боловсруулж байгаа түвшинд ч бид нарын хэлэлцэж байгаа түвшинд ч илүү сайн хардаг болох уу? Болдог болох байх гэсэн ийм хүлээлттэй байгаа.

Б.Пүрэвдорж: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууна.

С.Эрдэнэбат: Хуулийг зөвхөн хуульч нар бичээд байхаар хууль зарим талаараа бол амьдралгүй болоод байдаг юм. Бодит амьдралыг хууль эрх зүйн хувьд журамлаж тогтооход хуульчийн нүднээс харах нэг өөр. Яг тэр хуулийг хэрэглэх зохицуулалт хэрэгтэй гээд байгаа тэр өөрөө субъектүүдийнх нь санаа бодлоос хоцорчих гээд байдаг. Хуулийн төсөл боловсруулаад Хууль зүйн яам болон бусад газруудаас санал авахаар маш олон хувь хүний үзэмж хүртэл ордог байхгүй юу. Магадгүй тэр Хууль зүйн сайд хэн байхаас хамаараад.

Тийм учраас ийм л юмыг бид нар хийхгүй байх ёстой. Тийм учраас энэ хуулийн төсөлд хувь хүний тэр үзэл баримтлал тэр хувь улс төрчийн гэдэг юм уу үзэл баримтлалыг нь батлахад Хууль зүйн сайд болон холбогдох сайд нар баталж байгаа. Тэрийг хувь хүний үзэмжээс үл хамаарсан байдлаар зохицуулах тал дээр

яаж оруулж өгсөн бэ гэдэг дээр асуумаар байна. Нөгөө талаараа бол одоо хэрэгждэггүй, сэтгэл хөөрлөөр, эс үгүй бол нийгмийн сошиал ч гэдэг юм уу ийм зүйлийг харж байгаад бас янз янзын чанаргүй богино настай хэт нэг талаас харсан хуулиуд бол шүүлтүүргүйгээр орж ирэх гээд байдаг. Энийг хязгаарлаж байгаа энэ асуудлууд нь бол яг хэрхэн яаж тусгаж байгаа вэ? Үндсэн хуульд зааснаас бусад чиглэлээр хүний эрх эрх чөлөөг хязгаарлах гээд тавьж байгаа. Тэгэхээр зарим талаар харахаар бол нэг хүний эрх, нөгөө хүний эрхээр хязгаарлагддаг. Тухайлбал манай Улаанбаатар хотод саяхан нэг иргэдээс санал гомдол ирж байхад энэ дуу чимээний асуудал нэлээн яригдлаа. Маш бүдүүн яндантай мотоцикл үнэтэй машинуудаар давхилддаг. Энийг нь хязгаарлана гээд Ингээд хууль ингээд оруулаад ирэхээр миний ямар машин унах, яаж явах нь одоо Үндсэн хуульд хязгаарлагдаагүй учраас ийм хотын дүрэм журам ч гэдэг юм уу ийм зүйлээр хязгаарлах нь хууль бус гээд ингээд ороод ирэх вий. Ийм хуулийн бас нөгөө талаасаа өнцгөөс нь яаж харагдаж байгаа вэ гэдгийг би тодруулж асуумаар байна.

Дээрээс нь хүний эрх эрх чөлөөг хязгаарлах зохицуулалт бүхий хуулийн төсөлд Хүний эрхийн комиссоос санал авна аа. Энэ бол зөв. Гэхдээ ганцхан Хүний эрхийн Комисс маань үнэхээр институтийн хувьд тэр хүний эрх, эрх чөлөөг хамгаалж хадгалж байгаа талыг бүх талаараа харж чадаж байгаа юу. Нэг талаараа тэр хүний эрхийн комисс маань Улсын Их Хурлаас томилогддог байгууллага учраас одоо хараат бус байдал нь өөрөө хэр зэрэг хангагдаж байгаа вэ. Өөрөөр хэлбэл хүний эрхийг хамгаалж байгаа тэр институц байгууллагуудын саналыг заавал авдаг байх гэдгийг хаана тусгаж өгсөн бэ. Эрх ашиг нь хөндөгдөх тухайлбал бизнесийн эрх ашиг хөндөгдөх юм бол тэр ажил олгогчдын холбоо гэдэг юм уу танхим гэдэг юм уу тэр хүмүүсээс нь заавал санал авдаг байх.

Ажилтны эрх ашигтай холбоотой ийм санал авах юм бол тэр үйлдвэрчний эвлэл ажилтны төлөөллийн байгууллагуудаас нь заавал санал авах гэдэг ийм хууль эрх зүйн зохицуулалтуудыг тусгаж өгвөл болохгүй юу гэдэг ийм саналыг хэлмээр байна аа.

Дээрээс нь энэ олон нийтийн хэлэлцүүлэг гээд байж байгаа. Зарим хууль бол яах вэ яг үнэндээ халтуурдаж байна аа. Хэзээ батлагдах хэн хийж байгаа гэдгээсээ хамааруулаад олон нийтийн хэлэлцүүлэг гэхээр манай зарим төрийн захиргааны байгууллагууд баахан төрийн захиргааныхаа байгууллагын албан хаагчдыг авчирч ирж байгаад тэгээд санал хэлэлцүүлэг явуулчихсан гэдэг байдлаар оруулж ирээд байна лээ.

Тэгэхээр тухайн салбарын хууль зөвхөн төрийн захиргааны албан хаагчид гэхээсээ гадна эрх ашиг нь хөндөгдөх жирийн иргэдээс авхуулаад институц байгууллагууд судлаач нар гэх мэтчилэн олон хүмүүсээс хамаарч байгаа учраас энийг бас арай илүү нөгөө либералчилж олон талын оролцоог хангах гэдэг энэ зохицуулалтуудыг нь яг яаж тусгаж өгсөн бэ гэдэг дээр тодруулж асууя.

Б.Пүрэвдорж: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн хариулна.

О.Номинчимэг: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Яах вэ бид нар энэ нөгөө нэг хувь хүний үзэл бодол юу гэдэг юм ийм субъектив юм орж ирээд байна гээд та хэлж байна. Гол нь бид нарын нөгөө зорилго бол хууль тогтоомжийг боловсруулахдаа судалгаа шинжилгээнд үндэслэсэн байх, зорилгодоо нийцсэн байх. Энийгээ л сайтар нягталж л хийж байх ёстой л гэсэн энэ шалгуурыг тавьж

байгаа. Тэгээд энийг илүү сайн чамбайруулах дээр мэдээж энэ хуулийн төсөл дээр жишээ нь бол энэ 17.1 буюу хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээг өөрөө бас хийдэг байсныг нь хөндлөнгийн судлаач мэргэжлийн байгууллагуудаар хийлгэдэг болгоё. Манай гишүүдээс гарсан санал ажлын хэсэг дээр зөвшөөрөөд явсан нь төсөвтэй зардалтай холбоотой асуудлыг энэ чиглэлээр мэргэшсэн байгууллагаар хийдэг болъё гээд хөндлөнгийн ийм судалгаагаар бид нар 2 талаас нь харахгүй зөвхөн өөрийнхөө үзэл баримтлалд өөрийнхөө зорилгод нийцүүлээд тэрэнд нь тааруулсан судалгааг нь хийдэг ийм селективтэй байдлыг нь халахын тулд ийм шалгуур орж ирж байгаа гэдгийг хэлмээр байна.

Хамаа замбараагүй хууль орж ирдэг гээд тэгж байна. Яах вэ энэ дээр бид нар хууль санаачлагч 3 субъект байгаа. Тэгээд хууль санаачлагч нийгэмд тулгамдаж байгаа энэ асуудал гажуудлын засах, зөрчилдөөнийг засах гээд хууль санаачилж болно. Энэ хууль санаачлагчийн бүрэн эрх. Гол нь энийгээ энэ хууль тогтоомжид заасан хуульд заасны дагуу үр нөлөөллийн үнэлгээг нь зардлыг нь тооцооллыг нь хийгээд олон нийтээсээ саналыг нь аваад чамбайруулаад ороод ир ээ. Үүний дараа үнэхээр дахиад асуудал байх юм бол мэдээж Улсын Их Хурал өөрөө энэ чинь хэлэлцдэг зөвшилцдөг ийм байгууллага. Мэргэжил арга зүйн туслалцаа үзээд Тамгын газар байна, хүрээлэн байна. Эндээс хууль зүйн дүгнэлт гаргуулах, дахиад хүний эрхтэй холбоотой асуудлыг ч гэсэн хүний эрхийн үнэлгээ хийлгэх аргачлалын дагуу нь байна уу үгүй юу гэдгийг Байнгын хороо, дэд хороо, гишүүдийн хүсэлтээр ч гэсэн хийгээд энийг дахиж чамбайруулж бид нарын хэлэлцэх шатдаа энийг сайжруулах боломж нь бол нээлттэй байгаа. Энэ хууль дээр ч гэсэн энэ үзэл баримтлалаар бол энэ зүйлс орж ирсэн байгаа.

Хүний эрхийн комисс бол манай юу гэдэг юм Улсын Их Хурлын хүний эрхийг хянах энэ механизмыг бэхжүүлэхэд мэргэжлийн ийм байгууллага байгаа. Хөндлөнгөөс хүний эрх Монгол Улсад хэрэгжиж байгаа юу? Энэтэй холбоотой хэрэгжилт хууль тогтоомжийн энэ уялдаа дээр ажиллаж байгаа. Тэгэхээр энэ комисс маань угаасаа бидний хувьд энэ хууль тогтоомж хүний эрхэд нийцэж байгаа юу үгүй юу гэдэг дээр өргөн утгаараа яалт ч үгүй санал өгөх эрх бүхий байгууллага.

Үүнээс гадна бид нар нэмэлт шаардлагатай гэх юм бол тухайн үедээ Улсын Их Хурлын Байнгын хороо, Дэд хороо гишүүдээсээ энэ саналыг гаргаад хийх бүрэн боломжтой байгаа гэдгийг хэлмээр байна аа.

Хүний эрхийн хязгаарлалтыг хийхдээ мэдээж хүний амин чухал эрхээс гадна бусад эрхийг тодорхой зорилгод нийцүүлж, зорилгоор бол хязгаарлаж болдог энэ олон улсын гэрээ, конвенц, зохицуулалтынх нь үндсэн зарчим. Энийг бол таны яг хэлж байгаагаар бусдын аюулгүй байдал, нийгмийн хэв журам гээд яг хуульд заасан зорилгыг нь.

Б.Пүрэвдорж: Нэмж хариулъя.

О.Номинчимэг: Хуульд заасан зорилгын дагуу л байх ёстой. Энэ бол манай Үндсэн хуулийн зарчим. Хуульд заагаагүй тохиолдолд хүний эрх эрх чөлөөг бусад байдлаар захиргааны хэмжээний актаар ч юм уу хязгаарлаж байхгүй. Тэгээд яах вэ таны хэлж байгаа бидний иргэдийн маань, өөрсдийн маань хүний эрхийн ойлголт бас их өөр өөр болчихжээ. Би одоо жишээ нь хууль санаачлаад Тамхины хяналтын хуулийг санаачлаад явж байхад надад энэ тамхи импортлогч санал ирж байгаа юм. Тэгээд энэ тамхины янжуур тамхины хайрцгийн гадаргуу дээр 50 хувь нь

анхааруулга байна. Эрүүл мэндийн анхааруулга байна гэдгийг 70 хувь болгоё гэсэн чинь надад ирсэн санал нь ингэж өсгөж байгаа чинь бидний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд халдаж байна гэдэг санал ирж байгаа юм. Тэгэхээр энэ бол бид нар өөрсдөө хүний эрх, эрх чөлөөгөө яаж ойлгох юм, ямар хязгаарлал байж болох юм гэдэг дээр нэлээн өөрсдөө анхаарч ажиллах. Иргэддээ ч гэсэн зөв мэдээллийг түгээхэд их анхаарах ёстой болжээ гэдгийн дохио л гэж би харж байгаа. Тэгээд энийг бол Улсын Их Хурлын гишүүд өөрсдөө хийх ёстой гэж харж байгаа.

Б.Пүрэвдорж: Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууна.

А.Ариунзаяа: Хууль тогтоомжийн тухай хуулийг зарчмын хувьд бол дэмжиж байгаа, дэмжиж санал өгсөн. Анхдугаар хэлэлцүүлэг дээр ажлын хэсгийн гаргасан зарим саналууд дээр тодруулах асуудал байна.

Нэгдүгээрт хүний эрхийн үнэлгээ хийх гэсэн асуудлууд байгаа дээр ажлын хэсгийн гаргасан буюу санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалтын 41.4 дэх хэсгийг хасах гэсэн байна. Энэ нь Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Судалгааны асуудал эрхэлсэн хүрээлэн, хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээг хийсэн эсэх дээр нь дүгнэлт гаргах гэсэн ийм заалт байгааг хассан байна аа. Энэ ер нь яг энэ үнэлгээнд сөргөөр нөлөөлөх үү үгүй юу гэдэг ийм асуулт байна.

Хоёр дахь нь болохоор ашгүй ажлын хэсгийн гаргасан саналыг Байнгын хороо дэмжээгүй байна. Дэмжээгүйгээр жендерийн мэдрэмжтэй байх тал дээр нь энэ 17.3.3 ялгаварлан гадуурхахгүй таслал жендерийн мэдрэмжтэй байх гэсэн заалт хэвээр үлдэх үү гэдэг ийм асуудал байна.

Дэмжээгүйд талархлаа илэрхийлье. Ер нь бол энэ жендер гэдэг үгнээс хүмүүс ер нь их айгаад байдаг. Зүгээр л нэг дарга болох гэсэн хэдэн эмэгтэйчүүдийн асуудал юм шиг маш буруугаар ойлгож цааргалаад байдаг. Тэгэхээр энэ жендерийн мэдрэмжтэй гэдэг асуудлын нэг төрийн бодлогын талаар би хэлж яагаад энэ их чухал юм бэ гэдгийг хэлье. Тэгээд энэ төслийг дэмжээгүйг дэмжиж энэ жендерийн мэдрэмжтэй байх шалгуурыг Улсын Их Хурлын гишүүд маань дэмжиж өгөөсэй гэж хүсэж байна.

Нолиос 3 насны хүүхдээ асарч байгаа эцэг эхийн тэтгэмж гэж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас олгодог.

2017 оноос хойш энэ хөтөлбөр хэрэгжиж байгаа. Тухайн үедээ бол зөвхөн эх буюу эмэгтэйчүүдийг цалинтай ээж гэсэн нэршлээр олгож эхэлсэн. Тэгэхээр нолиос 3 насны хүүхдээ асарч байгаа эмэгтэйчүүдэд л одоо энэхүү тэтгэмжийг олгож байсан бол үүн дээр Цэц дээр 2021 онд маргаан үүсгэж би яг тухайн үед сайдаар ажиллаж байсан 21 оноос хойш эцэг болон эх буюу хүйсээр ялгаварлахгүй ийм саналыг бол гаргасан. Тэгэхээр анхны энэ бодлого маань зөвхөн эмэгтэйчүүдийг л хүүхдээ харах ёстой юм шиг ийм төрийн бодлого хүртэл гарсан нь энэ жендерийн ялгаварлалыг үүсгэсэн байгаа. Яг одоогийн байдлаар бол 3 мянга орчим залуучууд, залуу аавууд яг энэ хүүхдээ гэртээ хараад асраад сууж байгаа аавууд байдаг аа.

Тэгэхээр төрийн бодлого ч гэсэн өөрөө энэ гаргаж байгаа хууль тогтоомжоороо хүйсээр ялгаварлаж болохгүй юм аа. Аливаад хууль тогтоомж цаанаа ийм нөлөөллийг үзүүлдэг юм цаанаа. далд ухамсарт зөвхөн эмэгтэйчүүд л

хүүхдээ гэртээ хараад суух ёстой юм шиг ийм ойлголтыг төрүүлж байгаа нь бол буруу юм гэдэг ийм санаа явж байгаа учраас аливаа хууль тогтоомжийг гаргахаасаа өмнө яг ийм хүйсээр ялгаварласан санаа бодол байна уу үгүй юу гэдгийг гаргаж байх юм бол ийм асуудал гарахгүй ээ.

Ийм учраас энэ заалтыг үлдээж өгөөсэй. Мөн түүнчлэн яг энэ хүний эрхтэй холбоотой энэ зүйл заалтууд нь яагаад чухал юм бэ гэхээр саяын энэ нолиос 3 насны хүүхдээ асарч байгаа эцэг эхчүүдийн хөдөлмөрлөх эрхэд бол бас ноцтойгоор халдсан гэж үзэж болохуйц заалт байгаа. Яагаад гэвэл нолиос 3 нас хүртэл нь зөвхөн хүүхдээ хараад л гэртээ асарч байгаа хүмүүс л энэ тэтгэмжид хамрагддаг. Аливаа жижиг цагийн ажил ч байдаг юм уу ямар ч төрлийн ажил эрхлээд л эхлэх л юм бол энэ тэтгэмж зогсдог нь бол эргээд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бус ийм бодлогыг төр өөрөө явуулсан байгаа юм аа. Тэгээд Сайд байхдаа би уг нь бол яг энэ нолиос 3 насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд дэмжлэг болъё, хүн амаа өсгөх бодлого мөн л юм бол хүүхэд дөнгөж төрөнгүүт нь залуу гэр бүлд нэг удаа шууд 3 сая төгрөг олгодог байх ийм зарчимтай байвал яасан юм бэ гээд ийм саналыг тухайн үедээ дэвшүүлээд явж байсан.

Ийм учраас ер нь бол аливаа бодлого дээр яг энэ хүний эрх талаас нь мөн түүнчлэн жендерийн талаас нь анхаарах нь зүйтэй юм гэж. Тэгээд миний ойлгосон зөв үү? Яг энэ дэмжээгүй саналыг дэмжих юм бол.

Б.Пүрэвдорж: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн хариу хэлнэ.

О.Номинчимэг: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Эхний энэ 41.4 дээр буюу хууль боловсруулагч санаачлагч өөрөө хууль тогтоомжоо төслөө оруулаад ирэхээр түрүүн хэлсэн тиймээ хүний эрх, эрх чөлөөг хязгаарлахдаа хязгаарлачихсан ийм зохицуулалт орж ирж байгаа. Заавал энэ аргачлалын дагуу тохирсон байна уу, зорилгодоо нийцсэн байна уу, хуулийн дагуу байна уу гээд. Энэ нөгөө нэг аргачлалаар бид нар тэр өөрсдөө шалгаж орж ирэх юм. Энийг нь 41.4 дээр Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх судалгааны байгууллага давхар ингээд хянана гэсэн хянаж 5 өдрийн дотор дүгнэлт гаргана гэсэн юм байгаад байгаа.

Тэгэхээр бид нарын хувьд бол хууль санаачлагчийн бүрэн эрх байна. Өөрийн хууль, хүний эрх, эрх чөлөөг хязгаарлахтай холбоотой хууль дээрээ Хүний эрхийн комиссоосоо бид нар санал авна. Дахиад дээр нь 41.8 дээр бүрдүүлбэрийн шатанд Тамгын газар шалгалт юу энэ дээр бүрдүүлбэр дээр нь шалгадаг. Энэ хүний эрхийн аргачлалаа хийсэн байна уу үгүй юу гэдгийг. Тэгэхээр энэ давхар давхар ийм шалгалт байх нь зохимжгүй.

Дээр нь үнэхээр бид нар Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороогоор энийг хэлэлцэх тохиолдолд үнэхээр давхар энийг нь дахиж бид нар шалгах ёстой байна гэх юм бол объектив байдлаар хөндлөнгөөс Тамгын газар хэн нэгний өмнөөс энэ дээр нь аргачлал нь зөв байна, буруу байна гэдэг дүгнэлтийг гаргана гэхээсээ илүүтэйгээр Байнгын хороо гишүүдээс гарсан саналаар мэргэжлийн байдлаар зөвлөн туслах чиг үүргийнхээ дагуу энэ дүгнэлтийг гаргах нь зүйтэй юм гэдэг байдлаар энийг хасах нь зүйтэй гэж ажлын хэсэг дээр ч гэсэн санал нэгдсэн юм. Тэгээд энийг нөгөө Сайнзориг гишүүн маань илүү өмнө нь гишүүний хувиараа гаргачихсан санал байсан болохоор ажлын хэсэг бас энийг нь дэмжээд хасах нь зүйтэй гэж үзэж байгаа юм аа.

Хоёр дахь асуудал болох жендерийн мэдрэмжийн асуудал байна. Энэ дээр бол энэ хүний эрх, эрх чөлөөг хязгаарлахдаа ямар шалгуур байх вэ гэдэг энэ асуудал байгаа. Тэгэхээр та яг нөгөө энэ анх орж ирсэн төслийг нь харах юм бол ялгаварлан гадуурхахгүй байх дээр нь жендерийн мэдрэмжтэй байх гэсэн 2 үг байгаад байгаа юм. Тэгээд дээр нь бид нар ялгаварлан гадуурхахгүй гэдэг дээр хүйсээр ялгаварлахгүй буюу жендерийн тэгш байдал гэдэг юм маань өөрөө орчихдог. Жендерийн мэдрэмж гэж юу юм бэ гэдгийг бид нар судлаад үзсэн чинь ерөөсөө ерөөсөө нөгөө энэ хүчин зүйлүүдийг хүйст өөрөөр нөлөөлж байна уу үгүй юу гэдгийг анхаарч тооцох хүсэл эрмэлзэл мэдлэг чадварыг нь тодорхойлсон ойлголт байгаа юм.

Тэгэхээр энэ нөгөө нэг ялгаварлан гадуурхах жендерийн тэгш байдал буюу ялгаварлахгүй гэдэг энэ нөгөө нэг хэм хэмжээ гэхээсээ илүү хүсэл зоригийг хараад байгаа юм. Тэгээд бид нар хэм хэмжээг юу гэдэг юм аргачлалын дагуу энийг тооцоолохдоо тэр хүсэл зориг байна уу гэдгийг хууль дээр объектив байдлаар дүгнэх боломжгүй учраас ялгаварлан гадуурхах гэдэг дээр жендерийн тэгш байдлыг хангасан уу үгүй юу гэдэг маань орж байгаа учраас жендерийн мэдрэмж гэдэг үгийг бид нар хууль хэрэглээний шатад хэн яаж хэрэглэх нь ойлгомжгүй байдал үүсэх учраас мэдрэмж буюу энийг субъектив байдлаар байгаад хандах юмыг больё. Жендерийн тэгш байдал буюу ялгаварлан гадуурхахгүй байх гэсэн энэ шалгуур нь байх нь зүйтэй гэж ажлын хэсгээс санал дүгнэлт гарсан байгаа юм.

Б.Пүрэвдорж: Аюушийн 10 Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Тэгэхээр жендерийн мэдрэмжтэй гэдэг үгийг хасъя гэдэг ажлын хэсгийн саналыг Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй буюу дэмжээгүй саналыг дэмжих юм бол жендерийн мэдрэмжтэй гэдэг нь үлдэх юм байна гэж би ойлголоо. Ийм учраас энэ дээр тухайн үед нь би гишүүддээ анхааруулж ажлын хэсгийн саналыг дэмжихгүй байхыг хүсье ээ.

Энэ жендерийн мэдрэмж үнэлгээ гэдэг юмыг би дөнгөж гаргаж ирээд байгаа ийм асуудал огт биш. Энэ бол Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор 6 аргачлал батлагдсан байдаг. Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг судлахдаа энэ жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлэх шаардлагыг тухайн үедээ бол тогтоосон байдаг. Жендерийн үндэсний хороо төрийн ажлын албанаас 2018 онд энэ жендерийн нөлөөллийн үнэлгээг хийх аргачлалыг боловсруулсан Улсын Их Хурлын Тамгын газар, ЗГХЭГ, Хүний эрхийн комисс, холбогдох яамдыг оруулсан хууль тогтоомжийн төсөлд үнэлгээ хийх арга зүйг нь боловсруулсан байдаг юм аа. Тэгэхээр энэ бол бэлэн байгаа аргачлал гэдгийг сануулж хэлье ээ. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууна.

Н.Наранбаатар: Гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд сүүлд Улсын Их Хурлаар өргөн баригдсан орж ирж байгаа 2 ч хуулийн төсөлтэй танилцаж байгаа. Хүний эрхийн зөрчилтэй гэж хэлж болохоор Үндсэн хууль зөрчсөн гэж хэлж болохоор ийм тохиолдлууд орж ирээд байгаа юм. Тухайлах юм бол Байгаль орчин нь уур амьсгалын яамнаас өргөн барьсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль гээд сая орж ирээд хэлэлцэх эсэх нь дэмжигдээд л явсан л даа.

Тэгээд үзэл баримтлалыг нь харахаар зэрэг Үндсэн хуулийн заалт дурдчихсан. Монгол Улсын иргэн эрүүл аюулгүй орчинд амьдрах ийм эрхтэй гээд. Доторх заалтыг нь харахаар зэрэг аливаа нэгэн томоохон уурхайн ч юм уу төсөл явахдаа багийн иргэдийн нийтийн хурлаас санал авдгийг болиулчихсан байх жишээтэй. Шалтгаан нь болохоор зэрэг хугацаа алддаг багийн иргэдийн нийтийн хурал мөд хуралдаж өгдөггүй, ирц нь хүрдэггүй, тэгээд төсөл гацаанд ордог гэсэн шалтгаанаар ингээд тэр заалтыг нь авчихсан байх юм. Уг нь бол одоо тэр малчдын тэр суманд амьдарч байгаа хүмүүс эрүүл аюулгүй орчинд амьдарч байгаа юу үгүй юу? Ямар сөрөг нөлөөлөл байна вэ гэдгийг тэр улсууд л мэднэ л дээ. Тэгээд багийнхаа ИНХ-аар хэлэлцээд энэ төсөл дээр санаа оноогоо яриад ингээд тогтоол гаргаад өгдөг. Тэгээд энийг нь хасчихсан гэсэн хууль орж ирж байх юм. Бас нэг кэйс байгаа. Энэ Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль. Тэгээд 1 жилээр ингээд хойшилчих. Сая 6 сарын 1-ээс эхлээд хэрэгжих ёстой байсан.

Тэр шалтгааныг нь сонсохоор Үндсэн хуультай зөрчилдөж байгаа юм аа. Газрын асуудлаар гээд тэгэх юм. Тэгэхээр яахаараа ч Үндсэн хуультай зөрчилдсөн хуулийг ингээд оруулж ирээд Улсын Их Хурлаар хэлэлцээд хойшлуулаад ингээд явж байдаг юм. Үндсэн хууль зөрчсөн гэдгийг нь ямар баримт нотолгоогоор хэлээд байгаа юм. Нөгөө талаар бас тэр хуулиа хойшлуулах болсон шалтгаанаа тайлбарлахдаа бэлтгэл ажил хангагдаагүй гээд энэ чинь хуулийн чинь бэлтгэл ажил хангагдаагүй арай амжихгүй байна наадхаа хойшлуул гээд дахиж хууль гаргаад ингээд яваад байж болж байгаа юм уу гэх мэтчилэн ийм замбараагүй үнэлгээ сайн хийгдээгүй ийм хуулийн төслүүд энэ чуулган руу Байнгын хороо руу орж ирээд ингээд хэлэлцэгдээд яваад энэ чуулган дээр бөөн маргаан болоод л ингээд явах юм аа.

Тийм учраас энэ асуудлуудыг хаана нь үнэлгээ, дүн шинжилгээ хийж байж наашаа оруулж ирж байгаа юм. Энэ хуулийн өөрчлөлт дээр үүнийг нь зассан юм байгаа юм уу. Уг нь угаасаа байгаад ингээд хуулиа зөрчөөд орж ирээд байдаг юм уу гэдэг дээр нэг товч хариулт авъя.

Дараа нь энэ хэрэгжиж байгаа хуулиудад асуудал их байна шүү. Тухайлбал энэ бүсийн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль гээд бүүр 2003 онд батлагдсан хууль өнөөдөр явж л байгаа. Тэгээд аль хэдийн цаг үеэ элээчихсэн ийм хуулиуд ингээд өнөөдрийг хүртэл явж байдаг. Тэгээд орчин үе, цаг үетэйгээ нийлэхээ больчихсон ийм хуулиуд өнөөдөр явж байх юм.

Нөгөөтээгүүр энэ Ашигт малтмалын тухай хууль 2006 оноос хойш 11 удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр 300 нэмэлт, өөрчлөлт ямар нэгэн хэмжээгээр ороод утгаа алдчихсан. Нэг хууль байж байгаад 10 хууль болоод ингээд салаад задраад явчихсан. Хуульд нь одоо дүн шинжилгээ хийгээд үзэхлээр зэрэг 267 давхардал бусад 9 хуультайгаа ингээд ашигт малтмалыг зохицуулсан харилцааг зохицуулсан хуультайгаа 267 давхардалтай, 150 хийдэлтэй, 150 зөрчилтэй ийм хуулиуд өнөөдөр ингээд явж байгаа.

Бүүр нөгөө анхныхаа тэр үзэл баримтлал зорилго чиглэл утгаа алдчихсан хуулиуд явж байгаа. Тэгээд эд нарыг хаанаас дүн шинжилгээ хийж одоо энэ хуулиа өөрчлөхгүй бол болохгүй болсон байна гэдэг юмыг хаанаас үнэлгээ хийж явж байх юм. Тэгээд өнөөдрийг хүртэл эд нар нь хэвээрээ ингээд явж байх юм уу? Харилцаагаа зохицуулж чадахаа больчихсон, цаг үеэсээ хоцорчихсон ийм юмнууд.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын даргын зөвлөх Наранчулууны Отгончимэг. Индрийн 4 дүгээр ном микрофоноос.

Н.Отгончимэг: Наранбаатар гишүүний асуултад хариулъя.

Хуулийн хэрэгжилтийн асуудлаар энэ Хууль, тогтоомжийн тухай хуулийн төсөлд 2 чухал заалт орсон байж байгаа. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар бол 5 жил болсон бол заавал хэрэгжилтийг нь үнэлж байх ёстой байж байгаа. Гэхдээ түүнээс наана бол бас үнэлэх боломжтойгоор ийм зохицуулалт байгаа. Гэвч энэ заалт өөр бүүр эзэн биегүй байж байгаа. Засгийн газар нь алийг нь үнэлэх юм. Их Хурал нь алийг нь үнэлэх юм. Их Хурлын харьяа байгууллагууд нь алийг нь үнэлэх юм гэдэг нь эзэн биегүй ингээд явж ирсэн.

Үүнийг бол тодорхой болгоод Улсын Их Хурлын зохион байгуулалт үйл ажиллагаатай холбоотой хуулийг бол Улсын Их Хурлын Тамгын газар нь хэрэгжилтийг нь үнэлнэ гэж оруулсан байж байгаа.

Харьяа байгууллагуудтай холбоотой нэлээн хэдэн хуулиуд байдаг. Түүнийг нь түүгээрээ тэр байгууллагууд нь үнэлнэ. Үүнээс бусад хуулийн хэрэгжилтийг хамгийн цаад тал нь 5 жил тутам наана нь мэдээж үнэлж болно. Засгийн газар бол үнэлэхээр ингэж эзэн биетэй болгосон байгаа. Энэ үнэллээ гэхэд дата өөрөө бол маш тархай бутархай байдалд байж байгаа өнөөдөр. Тухайлбал яамдууд датагаа үнэлсэн хэрэгжилтийг нь үнэлсэн байлаа гэхэд тэр тайланг хаанаас олох нь бол өөрөө ойлгомжгүй байдаг. Тэгэхээр энийг бол хууль хэрэгжсэнээр цаашид легал инфо гээд энэ эрх зүйн мэдээллийн нэгдсэн сайт дээр тухайн хуулийн хэрэгжилтийг үнэлсэн бол тайланг нь тухай бүр нь хуулийнх нь дэргэд байршуулж байх, энэ олон нийтэд нээлттэй байх энэ зарчмыг хангаж энэ заалтууд бол орсон байж байгаа. Энэ хуулийн хийдэл юуны хувьд ярьж байна? Энэ бол хуулийн төслийн үр нөлөөний судалгаа, хэрэгжилтийн үр дагаврын судалгаануудаар ингэж гарч ирэх боломжтой. Ер нь Их Хурлын гишүүд хууль тогтоох ажиллагааг хэрэгжүүлж байхад нэмэлт материал судалгаанууд өөрөө маш олон талын оролцоог хангасан бодитой ийм чанартай судалгаанууд орж ирж байх ёстой гэдэг үндсэн дээрээс энэ судалгаануудад энэ босгыг нь чанарыг нь ахиулах энэ заалтууд бол орсон байж байгаа.

Б.Пүрэвдорж: Нанзадын Наранбаатар гишүүн нэмж тодруулъя.

Н.Наранбаатар: Орон нутгийн Иргэдийн хурал, Засаг дарга нар шийдвэр гаргаад зарим нэг журмуудыг баталж байгаа. Тэр тухайн нутаг дэвсгэртээ мөрдүүлээд байгаа юм. Тухайлбал зарим аймаг, согтууруулах ундааг сар болгоны ч гэдэг юм уу 7 хоног болгоны ч гэдэг юм уу тэд дэх өдөр зарахгүй гээд л шийдвэр гаргаад явж байдаг. Мөн зарим аймгууд нь вип тамхийг манай аймгийн нутаг дэвсгэрт зарж борлуулахыг хориглоно гээд л ингээд л шийдвэр гаргаад л явж байдаг юм.

Тэгээд Төсвийн тухай хууль ингээд яриад явахлаар зэрэг манайх нэгдмэл улс холбооны улс биш ээ. Тэгээд 1 бодлого нэг шийдвэртэй явах ёстой, нэг төсөвтэй нэг удирдлагатай явах ёстой гэдэг. Тэгэхээр алин дээр нь энэ үйлчлээд алин дээр нь үйлчлэхгүй явж байдаг юм. Үүнийг яаж зохицуулах ёстой юм бэ?

Б.Пүрэвдорж: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуултад хариулна.

О.Номинчимэг: Орон нутгийн хэмжээнд хэм хэмжээний акт гаргах эрх бас тухайн орон нутгийнхаа онцлогт тааруулаад энэ харилцааг нийтийн харилцааг гадагшаа чиглэсэн ийм харилцааг зохицуулах эрхийг бол бас олгодгоо. Захиргааны ерөнхий хуулиар энийг бол зохицуулдаг. Гагцхүү тэр Захиргааны ерөнхий хуулийн дагуу гарч байгаа Засаг даргын байдаг юм уу энэ хэм хэмжээний акт маань өөрөө хуульд үндэслэсэн байх ёстой. Тэгээд хуулиар буюу манай хууль тогтоогчид Улсын Их Хурлаас гүйцэтгэх засаглал энэ засаглалыг хэрэгжүүлж байгаа энэ этгээдүүдэд хэм хэмжээний акт гаргах тухайлсан, нарийвчилсан, харилцааг орон нутгийнхаа шинж чанарт тааруулж зохицуулах эрх хэмжээг нь өгдөг. Энэ эрх хэмжээнийх нь дагуу л орон нутаг маань өөрсдийнхөө захирамж байдаг юм уу тогтоол шийдвэрээ гаргаад явах эрх нь гардаг энэ бол олон улсад ч байдаг жишиг, манай Монгол Улсын ч хууль.

Б.Пүрэвдорж: Жаргалсайханы Золжаргал гишүүн асуулт асууна.

Ж.Золжаргал: Энэ төслийн 3 дугаар зүйлийн 3 дугаар заалт 17.1 дээр судалгаа шинжилгээний байгууллага судлаачаар гэснийг хөндлөнгийн судлаач хуулийн этгээдээр гэж өөрчлөх гэсэн санал л орж ирж байгаа юм байна лээ. Хууль санаачлагч өөрөө иргэдийг төлөөлөөд эсвэл нэг салбар төлөөлөөд нэг үзэл баримтлалтай консепттэй юм бэлдэж оруулж ирж таарна.

Тэгэхээр тэр хүн өөрөө мэргэжилтэн, бас зөвлөхдөө юун төлөө энэ чинь 126 гишүүн байгаа билээ. Бас тал талаас нь хэлэлцэнэ. Тэгэхээр энэ дээр ингээд нөгөө хөндлөнгийн байгууллага гэж заавал тухайлж оруулахаар хууль санаачлагч өөрөө хийнэ үү, хөндлөнгийн бус хүнээр хийлгэнэ үү? Хөндлөнгийн байгууллагаар судалгаа хийлгэнэ үү гээд ажил хийж байгааг нь яаж хийхийг нь зааж өгч байгаа юм шиг агуулга уншигдаад байх юм.

Энэ дээр ажлын хэсэг нэг нэмж тайлбар өгөөч.

Хоёрдугаарт нь Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 33.1 дээр Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудлаар Ерөнхий сайд санал гаргаад Их Хурлаар яаралтай хэлэлцэх талаар зохицуулалт байдаг. Энэ Хууль тогтоомжийн тухай хууль дээр болохоор энэ хуульд заасан шаардлагыг биелүүлж байгаа эсэх талаар хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргана л гэсэн ийм юутай. Ганц л хязгаар зохицуулалттай. Тэгэхээр бараг л дурын хуулиудыг яаралтай горимоор оруулж ирэх нэг ийм нөхцөл бүрдчихээд байгаа.

Түрүүчийн парламент дээр 45 хуульд яаралтай горимоор баталсан гэсэн энэ парламентын статистикийг олж хараагүй л байна. Тэгээд маш том асуудлууд яаралтай орж ирээд баярын өмнө шөнө шахдаг. Иймэрхүү юмнуудыг Дэгийн хууль дээр л орох байх. Гэхдээ энэ Хууль тогтоомжийн хууль дээрээ энэ хуульд нийцсэн эсэхийг төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргана гэдгээс арай илүү нарийн зааж өгмөөр санагддаг юм. Энэ тал дээр ажлын хэсэг та бүхэн ярилцсан уу. Уг нь бол энэ асуудал ярьж байгаа гэж сонсогдож байсан?

Б.Пүрэвдорж: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуултад хариулна.

О.Номинчимэг: Золжаргал гишүүний хөндөж байгаа энэ яаралтай горимоор орж ирдэг хуулийн төсөлтэй холбоотой хууль санаачлагчид энэ дээр анхаараад урьд нь бол энэ хууль тогтоомжийн хуулиараа яаралтай горимоор орж ирж байгаа энэ хууль дээр хууль тогтоомжийг боловсруулаад оруулж ирэхэд бүрдүүлбэр дээр байдаг энэ тандан судалгаа, үнэлгээ, үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо, үр дагаврын үнэлгээг ерөөсөө хийхгүйгээр шууд оруулж ирдэг байсан. Тэгээд энэ нь ч өөрөө нөгөө нэг дараа нь ул суурьтай үнэхээр нэн яаралтайгаар мэдээж арга хэмжээ авах шаардлага гарахыг үгүйсгэхгүй. Мэдээж гарна. Энэ үед гэхдээ ярина энийгээ байгаа онож байна уу гэдэг дээр дараа нь үнэлэлт дүгнэлт хийхэд дутуу дулимаг байна гэдэг энэ үндэслэлээр одоо энэ Хууль тогтоомжийн хууль дээр нэн яаралтайгаар орж ирж байгаа энэ хууль дээр бол нөгөө хэрэгцээ шаардлагын урьдчилсан тандан судалгаагаа болон хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагавартаа заавал үнэлгээ хийж байж орж ирье гэдэг энэ 2 шалгуурыг нь тавьж байгаа юм. Ингэж тавьснаар бид нар нэн яаралтай боловчиг үнэхээр хэрэгцээ шаардлага нь байна уу, энэнийхээ дагуу бид нар юу хийвэл зохистой вэ гэдэг энэ чигийг гаргаж өгнө гэдэг энэ шаардлага орж ирж байгаа гэдгийг хэлье. Тэгэхээр энэнээс энэ бүрдүүлбэрээр Тамгын газар хянаад нэн яаралтай орж ирж байгаа төсөл дээр энэ тандан судалгаа болон үр дагаврын үнэлгээ хийгдсэн байна уу гэдгийг давхар шалгадаг болно гэсэн ийм зохицуулалт орж ирж байгаа.

12.3 буюу үр нөлөөний үнэлгээг болохоор заавал хөндлөнгийн яагаад судлаачаар хийлгэх гээд байгаа юм бэ гэсэн энэ асуулт байна. Яах вэ түрүүн бас хэлсэн. Улсын Их Хурлын гишүүдийн хувьд бол тэр бүрчлэн бас тийм ресорс буюу нөөц бололцоо бага. Ер нь хуулийн төслийг боловсруулахад түүний зардлыг тооцооллыг хийхэд үр нөлөөгөө үнэлэхэд мэргэжлийн баг хэрэгтэй болог оо. Тэгээд энэ нь ч бол өөрөө ингээд хөндлөнгийн байгууллагыг авах нь элбэг байдаг. Сайн үнэлгээ хийе гэвэл. Засгийн газрын хувьд бол бас энийгээ хөндлөнгөөс ингэж үнэлгээ эд нарыг нь хийлгэж байхгүй бол Сангийн яам, Хууль зүйн яам өөрсдөө хийгээд ороод ирчихсэн. Яамдууд өөрсдөө хийгээд ороод ирчихсэн байгаа юмнууд маань өөрөө зөвхөн өөрсдийнхөө хиймээр байгаа юман дээр чиглээд хөндлөнгийн нүдээр үр нөлөө нь яаж гарах юм бэ гэдэг олон талаас харахгүй байна гэдэг шүүмжлэл орж ирж байгаа юм.

Тэгэхээр энэ дээр энэ нөгөө үр нөлөөний үнэлгээг бол заавал судалгаа шинжилгээний хөндлөнгийн эсвэл мэргэжлийн энэ байгууллагуудаар хийлгэж хийлгэж орж ир ирдэг байя гэсэн энэ шалгуурыг тавьж орж ирж байгаа гэдгийг хэлье.

Б.Пүрэвдорж: Золжаргал гишүүн нэмж тодруулъя.

Ж.Золжаргал: Санал хэлье ээ. Хөндлөнгийн байгууллагаар судалгаа хийлгэвэл сайн. Хэрвээ тэр хууль санаачлагч дээр сайн баг хийгээд байгаад судалгаа хийвэл бас сайн. Үүнийг олон талаас нь хэлэлцэхийн тулд 126 гишүүн 126 гишүүний цаана зөвлөхүүд гээд ингээд багууд ажиллаж байгаа. Тэгэхээр энэ бол яг тухайн хууль санаачлагчийн ажлын арга барил өөрийнх нь сонголтын асуулт байх нь илүү зохимжтой гэж бодогдож байна. Хуулиар бол тавигдах шаардлагуудыг нь гаргаад өгчхөж байгаа. Яаж ийгээд баруун гараараа алхаа барих уу, зүүн гараараа алхаа барих уу гэдэг нь өөрийнх нь сонголтод байх нь зохимжтой гэж бодож байна гэж саналаа хэлье ээ.

Б.Пүрэвдорж: Одсүрэнгийн Оюунчимэг гишүүн нэмж хариулъя.

О.Номинчимэг: Золжаргал гишүүний түрүүний асуултад би нэн яаралтайгаар орж ирэх гэж байгаа хууль дээр бол тандан судалгаа, зардлын тооцоолол хийх аргачлалыг нь заавал хийж орж ирж байх ёстой юм байна шүү. Тэгэхээр энэ нэн яаралтай хууль гарснаар ямар зардал гарах вэ? Энэ хэрэгцээ шаардлага нь юу байна гэдэг энэ судалгааг нь Хууль тогтоомжийн хуулийн дагуу хийх шаардлага нь орж ирж байгаа юм байна. Андуурсан байгаа учраас тодруулаад хэлчихье ээ.

Б.Пүрэвдорж: Батбуян Батбаатар гишүүн алга байна. Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууна.

Б.Жаргалан: Сайн байцгаана уу? Хууль тогтоомжийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан байдаг. Тэгээд яг тухайн үед өргөн баригдаж байсан хуулийн төслийн үзэл баримтлалыг нь эргээд харахаар 2012-2016 оны Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд багтсан нэг зорилтыг эш татсан байгаад байгаа юм. Хуулийн тухай хуулийг батлуулж, хуулийн хэрэгцээ шаардлага хэрэгжилтийг үнэлдэг болох.

Тэгэхээр 1 дүгээрт 2 төрлийн үнэлгээ яригдаад байгаа юм. Хэрэгцээ шаардлага, хэрэгжилт.

Тэгээд үзэл баримтлал дээр дурдсан зүйлүүдийг харах юм бол яах вэ ер нь энэ хууль зүйн техникийн хувьд ч тэр, хууль, хоорондын уялдаа холбооны хувьд ч тэр хуулийн хийдэл гаргахгүй байх талаасаа энэ хуулийн тухай хууль зайлшгүй байх шаардлагатай юм гэдэг ийм анхны санаачилга явсан байдаг. Тэгээд түүнээс хойш хэд хэдэн нэмэлт, өөрчлөлт орсон боловчиг одоо бид дахиад оруулах гээд сууж байна.

Тэгээд би бол 2 зүйл дээр санаа зовоод байгаа юм.

Нэгдүгээрт, хууль санаачлах онцгой бүрэн эрх бол Улсын Их Хурлын 126 гишүүн, Засгийн газар Ерөнхийлөгчид байдаг ийм онцгой бүрэн эрх байгаа. Тэгэхээр энэ хууль санаачлах бүрэн эрхийг бас хязгаарлах агуулгууд байж болохгүй ээ. Хязгаарлах гэдэг дээр болохлоор хэтэрхий хүнд сурталтай гэдэг юм уу хэтэрхий их нөөц шаардсан эсвэл хэтэрхий их тийм цаг хугацаа шаардсан ингээд аягүй олон зүйлээр энэ бүрэн эрхийг хязгаарлах болохгүй гэсэн нэг ийм санаа яваад байгаа юм.

Тэгээд сүүлийн 10 жилд батлагдсан хууль тогтоомжуудыг харах юм бол нийт батлагдсан хууль тогтоомжийн бараг 70, 80 хувь нь Засгийн газраас өргөн баригдсан хуулиуд орж ирээд байгаа юм. Тэгэхээр өөрөөр хэлэх юм бол нөгөө нөөц ихтэй тэр нөгөө үнэлгээ, судалгаа, шинжилгээ, тэр хэлэлцүүлгүүдийг хийгээд байх боломжтой Засгийн газраас орж ирж байгаа хуулиуд нь яваад байдаг. Улсын Их Хурал дээр ерөөсөө ингээд хууль шинээр санаачлагдах орон зай хумигдаж байна уу гэдэг нэг болгоомжлол байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ дээр бас ажлын хэсэг дээр тодорхой судалгаанууд байна уу? Ер нь зүгээр онолын хувьд бас яг энэ асуудал дээр ямар бодолтой байна вэ гэдгийг асуух гээд байгаа юм.

Тэгэхээр хууль санаачлах процессыг хэтэрхий хүнд сурталтай болгочих юм бол энэ хууль санаачлах Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхэд бас халдах зүйл байна уу гэдэг. Тэгээд сүүлийн үед өргөн баригдаж байгаа хуулиудыг хараад байхад ингээд баахан шаардлагууд тавьчихсан байгаа. Гэхдээ тэр судалгаа хэлэлцүүлгүүд аягүй формалын шинжтэй байгаад байна аа. Яг үнэхээр тэр хууль зүйн техник сайжраад байгаа гэдэг дээр асуудлууд зөндөө байна. Тэгэхээр зүгээр тэр нэг бүрдүүлбэрийн тоог нэмлээ гээд тэр чанар сайжрахгүй гэдэг ийм болгоомжлол байгаад байна шүү гэдэг, нэг.

Хоёрдугаарт нь болохоор өнгөрсөн намрын чуулганаар бид энэ Хууль тогтоомжийн хуультай холбоотой асуудлуудыг нэлээн ярьсан. Тэгээд 1 дүгээр асуудал нь бол хуулийг дагалдуулж, хамааралтай, хамааралгүй баахан олон хуулиудыг дагалдах хэлбэрээр оруулж ирээд батлуулж байна аа.

Тэр нь бол ингээд олон нийтийн анхаарлын төвөөс нийтийн хэлэлцүүлгээс далдуур яваад байна гэсэн нэг болгоомжлол байсан. Үүнийг хэрхэн яаж бас шийдэж байгаа вэ гэдэг асуудал. Сая яаралтай горимоор орж ирж байгаа хуулийн төслүүдийн талаар ярилаа.

Тэгээд энэ яаралтай горим гэдэг чинь асуудлууд байгаад байгаа юм. Яаралтай горимоор хэр олон хуулиуд орж ирж батлуулж байна? Энэ нь одоо бас ингээд нөгөө нийтийн анхаарлын төвөөс нийтийн хэлэлцүүлгээс гадуур яваад байгаа. Үүнтэй холбоотой яг тодорхой бодитой ямар асуудал шийдсэн бэ гэдэг дээрээ нэг хариулт авъя. Тэгээд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт өнгөрсөн парламент хийсэн байгаа. Тэгээд үүнтэй холбоотойгоор бас Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор тийм холбогдох хуулиудад нэмэлтүүд оруулаагүй асуудлууд сая гарлаа шүү дээ. Жишээлэх юм бол саяын нөгөө нэг.

Б.Пүрэвдорж: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуултад хариулна.

О.Номинчимэг: Жаргалан гишүүний дагасан хуультай холбоотой асуудал дээр хариулт өгөөд бусад асуудлыг хууль санаачлагч ажлын хэсгээс хариулъя, тайлбарлая. Дагасан хуулийн хувьд бол хамгийн их асуудал дагуулдаг юм бол төсөв дагаж хууль орж ирдэг. Төсөв жил болгоны төсвийн хуулийг дагуулаад төсөвтөө ямар ч холбоогүй эсвэл юу гэдэг юм бүүр шинэчилсэн найруулга ч гэсэн орж ирж байсан ийм түүх байдаг. Тэгэхээр бид нар яг ер нь бол зүгээр хууль тогтоомжийг барихад бол тухайн хуультай холбоотой уялдаа холбоог нь хангах зорилгоор хууль нь орж ирдэг хамгийн гол асуудал төсөв дагасан хуулиуд байгаа. Тэгэхээр төсөв дагасан хууль дээр үнэндээ бас Засгийн газар Сангийн яам ч гэсэн зовлонгоо хэлдэг л юм байна лээ. Төсөв дагаад ингээд ийм юм оруулчихъя гэдэг асуудал их байдаг. Энийг цэгцэлж өгөөч гэдэг саналаа ч тавьж байсан. Тэгэхээр яг энэ дээр бол бид нар энэ саналын томъёолол дээр өнөөдөр санал хураалгах гээд орж ирж байгаа. Төсөвтэй холбоотой төсөв төсөв дагаж зөвхөн тэр төсөв санхүүгийн харилцааг зохицуулж байгаа түүнд нөлөөлөл үзүүлж байгаа л хууль тогтоомж тогтоолын төсөл орж ирнэ ээ. Өөр юм бол дагалдуулж болохгүй шүү гэдэг энэ хязгаарлалтыг бол оруулж ирж байгаа. Бусад түрүүний онолын асуудал хууль тогтоогчийн эрх үүрэг. Тэгээд энэ дээр Улсын Их Хурлын тухай хууль дээр тодорхой өөрчлөлт ороод Улсын Их Хурлын гишүүдийн хууль санаачлах эрхийг илүү нээж өгсөн байгаа. Энэ дээр манай ажлын дэд хэсгээс илүү дэлгэрэнгүй тайлбар өгчихье.

Б.Пүрэвдорж: Наранчулууны Отгончимэг. Индрийн 4 дүгээр микрофон.

Н.Отгончимэг: Жаргал гишүүний асуултад хариулъя.

Улсын Их Хурлын гишүүд парламентын гишүүд болон Засгийн газрын хууль санаачилж байгаа батлагдаж байгаа тэр статистик тоо бол ер нь дэлхийн улсуудад их тийм ойролцоо байгаа. Тухайлбал бид нар харьцуулсан судалгаа хийлгүүлсэн судлаачдаар энэ сэдвээр Герман, Солонгос, Япон гээд энэ улсуудынхыг манайтай харьцуулж байхад бол тухайлбал Солонгост бол парламентын гишүүд нь маш олон тооны хууль Засгийн газраасаа илүү тооны хувьд олон тооны хууль өргөн барьдаг боловч батлагдаж байгаа нь Засгийн газар нь илүү давуутай олон батлагдаж байх тийм тенденц байна. Германд энэ тенденц бас байна. Монгол Улсад статистикийн хувьд ийм тэндэнц бас байгаа. Гэхдээ яг хууль санаачлах эрхийн хувьд бол парламентын гишүүн болон Монгол Улсын Ерөнхийлөгч бол Улсын Их Хурлын хуулиар бол эрхээ хязгаарлуулсан хэд хэдэн салбар байдаг.

Б.Пүрэвдорж: Нэмж хариулъя.

Н.Отгончимэг: Парламентын гишүүн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн хууль санаачлах эрхийг хязгаарласан хэд хэдэн салбар байгаагийн дотор бол татварын асуудал, өмч, эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хууль тогтоомжийн асуудлаар бол хууль санаачлах эрхгүй байж байгаа. Энэ дээр бол өмчийн асуудлаар зарим хэсгийг нь нээж өгч байгаа Хууль тогтоомжийн хуулиараа. Түүнээс гадна захиргааны эрх зүйн харилцаанд холбогдох хуулийг бол санаачлах эрхийн энэ 2 субъектэд нээж өгч байгаа. Учир нь захиргааны эрх зүйн харилцаа өөрөө маш өвөрмөц. Нэг талд нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, нөгөө талд нь иргэд хувийн этгээдүүд байж байдаг. Тэгтэл хууль санаачлах эрхийг нь бол яг энэ харилцааны нэг талд байдаг этгээдэд дангаар нь олгох бол зохимжгүй учир энэ 2 парламентын гишүүн Монгол Улсын Ерөнхийлөгчийн энэ санаачлах эрхийг яг энэ засаг захиргааны хууль.

Б.Пүрэвдорж: Тодруулах уу? Батбаярын Жаргалан гишүүн тодруулна.

Б.Жаргалан: Тэгэхээр сая Ерөнхий сайдад итгэл үзүүлэх, эс үзүүлэх тухай асуудал яригдахад Үндсэн хуулийн заалт мөн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн заалт дээр жишээлбэл нэг ийм бага зэргийн зөрчлүүд энэ тэр ажиглагдаад байгаа юм. Тэгэхээр бид нарын хувьд болохоор энэ хуулийн хийдлүүдийг арилгах энэ зөрчлүүдийг арилгах дээр бас нэлээн далайцтай ажил хийх шаардлагатай байгаа гэж харж байгаа. Тэгээд түрүүний дурдсан энэ хуулийн хэрэгцээ шаардлага хэрэгжилтийг үнэлдэг болох гэсэн энэ анхны үзэл баримтлалын дагуу энэ хуулийн хэрэгжилт дээр ингээд Улсын Их Хурлын Тамгын газраас бөгөөд энэ Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс энэ цаглавар гаргаад энэ хэрэгжилтийн тэр 5 жил тутмын үнэлгээнүүдийг маш олон хууль дээр дахиж хийх шаардлагатай л нөхцөл байдал харагдаад байгаа юм. Тэгж байж дараа дараачийн нөгөө хууль тогтоомжууд илүү чанартай гарах ийм үр дагавартай байгаад байгаа.

Тэгэхээр энэ хууль их ач холбогдолтой л байгаад байгаа юм.

Б.Пүрэвдорж: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдаар 10 сар ажиллахдаа 5 жи сүлжээг орон даяар асааж өндөр хурдны технологи болон аж үйлдвэрийн салбарт шинэ дэвшил гаргах ийм боломжийг нээсэн. Мөн түүнчлэн apple рау төлбөрийн сүлжээг нэвтрүүлж ялангуяа залуучууд төгрөгийн картаараа олон улсын төлбөр тооцоо хийх тэр боломжийг нээж өгсөн. Мөн сумдад Киоск

машиныг байрлуулж иргэд хурдан шуурхай төрийн үйлчилгээг авах ийм боломжуудыг нээж өгсөн Цэндийн Баатархүү сайд асуулт асууна аа.

Ц.Баатархүү: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Парламентын засаглалтай улс оронд хууль боловсруулж батлах 2 дугаарт нь энэ хуулийн хэрэгжилтийг хангах, хуулийн чанарыг сайжруулахад бол энэ Хууль тогтоомжийн тухай хууль маш чухал амин сүнс нь болж байгаа. Энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтийг оруулж ирээд хэлэлцүүлж байгаа явдалд бол санаачилсан гишүүдэд баярлаж байгаагаа илэрхийлье. 2024 оны 6 сарын 5-нд Монголын парламент нэг өдрийн дотор 240 хуулийг баталж байсан. 2 минутад бараг нэг хууль.

Тэгэхээр парламент бол олон хууль батлах нь чухал биш, чанартай хууль батлах нь чухал юм гэдэг зарчим агуулга энэ нэмэлт, өөрчлөлт дээр байгаа гэж бодож байна. Ер нь 3 том асуудал энд харагдаад байгаа юм.

Нэгдүгээрт нь бол хууль боловсруулах үе шатад судалгаа шинжилгээ, мэргэжлийн дүгнэлт, нөгөө талд нь олон нийтийн хэлэлцүүлэг.

2 мянгаас 2024 оны парламентын үед боловсруулсан 254 хуулийн дөнгөж 40 хувьд нь олон нийтийн хэлэлцүүлэг хийгдсэн. 60 хувьд нь хийгдээгүй байна гэдэг тоон мэдээ явж байна. Тэгэхээр олон нийтийн хэлэлцүүлгийг хийх тэр дундаа орон нутгийн иргэдийг энэ хууль боловсруулах үе шатанд ямар нэг хэлбэрээр оролцуулах тэр боломжийг хэрхэн нээсэн бэ гэдэг зүйлийг би энд тодруулж асуумаар байна.

Хоёрдугаар асуудал энэ яаралтай горим, яаралтай горим. Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангах гэдэг ийм ерөнхий агуулгын дор өнгөрсөн 4 жил бол 120 хуулийг бол нийтийн хэлэлцүүлэггүй хийсэн. Үүнийх нь 45 нь бол яаралтай горимоор орсон. Яаралтай горимоор жишээлэх юм бол авто замын түгжрэлийг бууруулах гэр хорооллыг орон сууцжуулах хууль гэдгийг иргэдээс санал авалгүйгээр яаралтай горимоор баталсан. Энэ хуулийн заалт бол хүний эрхийг зөрчиж байна аа. Хувийн өмчийг булааж авах хууль болсон байна гээд Монгол Улсын ҮХЦ-д 2024 онд би хандаж байсан. Хүний эрхийн асуудлыг өнөөдөр энд ярьж байна. Маш зөв. Гэтэл энэ яаралтай горим гэдгийн цаана хүний эрхийн асуудлыг хөндсөн хуулиуд батлагдаж байна аа. Энийг хэрхэн хязгаарлах юм бэ гэдэг асуултыг асууя.

Гуравдугаарт нь энэ шаардлагатай тохиолдолд гэдэг ийм дагалдах хууль байгаа. 2022 оны Төсвийн тухай хуулийг дагаж 100 гаруй хууль дагалдах хууль болгож нэмэлт, өөрчлөлт оруулж ирсэн. Үүнд нь анхдагч хуулиуд байсан. Тэгэхээр парламент өөрөө хариуцлагатай байя гэвэл Засгийн газрын ч тэр, хууль санаачлагчийн ч тэр энэ хуулийн чанарыг сайжруулах дээр онцгой анхаарч бид нар ажиллах шаардлага байна гэж бодож байна.

Хамгийн сүүлд нь бол энэ хуулийн хэрэгжилтийн асуудал. 5 жил гэдэг бол урт хугацаа. Парламент Улсын Их Хурлын Тамгын газар өөрийн төсөв дээр хуулийн хэрэгжилтийг үнэлэх энэ төсвийн менежменттэй хамт өргөн барих хэрэгтэй.

Хэн энэ хуулийн хэрэгжилтийг үнэлэх юм бэ гэдэг нь тодорхойгүй байдаг. Яамдууд нь үнэлэх юм уу, Улсын Их Хурлын гишүүд нь үнэлэх юм уу? Ямар төсвөөр

үнэлэх юм. Хэн үнэлэх юм бэ? Зохион байгуулалтын асуудал нь тодорхойгүй байдаг. Энэ дээр ямар тодорхой байдал орж ирж байгаа юм бэ гэдгийг асууя.

Сүүлд нь цахим хөгжил, инновац, харилцаа холбооны салбар бол зөвхөн хууль боловсруулах үе шатанд иргэдийн саналыг авдаг биш, хуулийн хэрэгжилт дээр тогтмол иргэдээс хуулийн хэрэгжилт ямар түвшинд байгаа яам бэ гэдгийг цахимаар санал авдаг болгох ийм цонх.

Б.Пүрэвдорж: Отгончимэг Улсын Их Хурлын даргын зөвлөх. Индрийн 4 дүгээр микрофон.

Н.Отгончимэг: Баатархүү гишүүний асуултад хариулъя.

Олон нийтийн саналыг авах боломж гэж байгаа. Энэ хууль тогтоомжийн хууль бол 2015 онд батлагдаад 2017 оноос хэрэгжиж эхэлсэн. Энэ хууль батлагдахдаа бол олон нийтийн оролцоог хангахтай холбоотой маш чухал концепцын тийм зохицуулалтуудыг оруулсан. Энгийг бол өөрчлөөгүй. Харин яаж үүнийг гүнзгийрүүлэх вэ гэдэг талаар хэд хэдэн заалт орсон. Тухайлбал энэ хууль хэрэгжиж эхлэх юм бол хууль санаачлагч өөрийнхөө веб сайтад хуулийнхаа төслийг тавихын зэрэгцээ эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан гэж байдаг. Бид нар легал инфо гэж нэрлэж заншсан үүн дээр бол заавал нэгдсэн байдлаар тавих шаардлагатай болно. Яаралтай горимын асуудал байна.

Яаралтай горимоор бол ер нь 2016 оноос хэрэгжиж эхэлсэн юм байна лээ. Статистик үзэхэд бол сүүлийн энэ парламентаар бол яаралтай горимоор хэлэлцсэн тоо 2.4 дахин нэмэгдсэн байж байгаа. Энэ тохиолдолд бол гол нь энэ хууль тогтоох байгууллагыг тал бүрийн, иж бүрэн мэдээллээр хангах нь чухал юм байна гээд 2 шаардлага нэмж тавигдаж байгаа. Яаралтай горимоор орж ирэх хууль дээр. Юуны өмнө тухайн хууль дээр зардлын судалгаа хийж орж ирнэ.

Хоёрдугаарт бол энэ хэрэгцээ шаардлага юу байсан юм бэ гэдэг дээр бол бас мэдээлэл, энэ судалгаануудаа парламентад өгч байх хэрэг болно. Тэгэхээр Их Хурлын гишүүд харьцангуй бол мэдээлэлтэй байх ийм боломж бүрэлдэнэ.

Дагалдах хууль дээр ярьж байна. Төсвийн хууль дээр бол 2 удаа анхдагч хууль оруулж ирсэн тохиолдол түүхэнд байдаг. Төсвийн хууль дагалдуулж. Энгийг хааж бол 2003 онд бол Хууль тогтоомжийн хуульд бол өөрчлөлт орсон. Гэхдээ энэ байдал бол бас их хумигдаж өгөхгүй байна. Тийм учир нэг заалт орсон байж байгаа. Одоо цаашид бол төсвийн хууль дээр ямар хууль дагалдах вэ гэхээр зөвхөн төсөвт нөлөөлөх үзүүлэх санхүү төсвийн хувьд нөлөөлөл үзүүлэх тэр хуулийг бол дагалдуулж оруулах боломжтой болно. Ингэхдээ орлого зарлага төсвийн тэнцэлд ямар нөлөө үзүүлж байгаа юм бэ гэдэг нэмэлт тайлбар мэдээллийг бол заавал гаргаж өгч байх ёстой гэж ингээд тусгагдсан байгаа.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүү нэмж тодруулъя.

Ц.Баатархүү: Би нэг санал нэмчихье гэж бодож байна. Түрүүн дутуу хэлчихлээ. Энэ хууль боловсруулах үе шатаас гадна энэ хуулийн хэрэгжилтийг яг тэр орон нутагт, баг, хороон дээр очоод ямар түвшинд хэрэгжиж байгаа юм бэ гэдгээр тогтмол иргэдээс санал авдаг. Ийм цахим цонхыг ди парламент, легал инфо

дээр оруулъя гэдэг энэ ажлыг эхлүүлчихсэн явж байгаа. Тэгэхээр хууль эрх зүйн хувьд энэ боломжтой гэж бодож байгаа.

Тэгэхээр энэ хуулийн хэрэгжилтийг ч гэсэн иргэдээс ингээд санал авдаг байдлаар явахгүй бол жишээлэх юм бол Инновацын тухай хууль 2012 онд батлагдсан. Хэрэгжилтийн асуудал үнэхээр хангалтгүй. Тунхагийн шинжтэй, ирээдүй цаг дээр биччихсэн байдаг. Шинэ санааг дэмжинэ, инновацыг дэмжинэ, компаниудыг дэмжинэ, яаж дэмжих юм, хэн дэмжих юм, хэн хариуцах юм гэдэг нь үнэндээ тодорхойгүй байдаг.

Тийм учраас тогтмол хуулийн хэрэгжилтийн асуулт асууна.

Б.Пүрэвдорж: Одоо Пүрэвийн Батчимэг гишүүн асуулт асууна.

П.Батчимэг: Монгол Улсын Их Хурлын 2024-өөс 2028 оны стратеги төлөвлөгөөнд туссан хүн төвт хүний эрх эрх чөлөөг дээдэлсэн үзэл санааг төгөлдөржүүлэх гэсэн энэ чухал зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх хүрээнд боловсруулсан Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байна аа.

Харамсалтай нь өнөөдөр чуулганы танхимд 105 гишүүн ирцэд орсон байдаг. Гэтэл өнөөдөр зүтгүүлээд зүтгүүлээд 1нэг 20 гаруй гишүүн 2 хуулийн төслийг өнөөдөр хэлэлцээд сууж байна. Түүний нэг нь Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэ маш чухал цаг үеэ олсон, хэрэгцээ шаардлага, ач холбогдол өндөртэй хуульч голдуу гишүүд өргөн барьж байгаа ийм хуулийн төслийг хэлэлцэхэд манай гишүүд өнөөдөр байхгүй байгаа нь харамсаж байна.

Энд бас хариуцлагын тухай яригдах байх л гэж бодож байгаа юм. Засгийн газар Ерөнхий сайдтай боллоо. Засгийн газар кабинетаа байгуулах Ерөнхий сайдын эрх үүрэг. Тэгэхэд өнөөдөр энд ингээд суудал хоосон ямар нэгэн өөр дотоод ажил хөөцөлдөөд алга болчихдог юм уу гайхаж байна. Энэ Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулаад хууль санаачилж байгаа гишүүний хувьд өнөөдөр шинэ тутам манай улсад хөгжиж байгаа бичил цахилгаан тээврийн хэрэгслийн скутер суроны хуулийг би өргөн барьж байгаа. Засгийн газраас сая санал ирсэн. Харамсалтай нь замын хөдөлгөөний дүрмээр зохицуулах хэрэгтэй гэсэн ийм санал ирсэн байгаа юм.

Тэгэхээр энэн дээр үүнээс үүдээд яг хууль боловсруулах энэ хуулийн төслийг боловсруулах явцдаа нэлээн их саадтай учирч энэ Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй хэрэгтэй юм байна гэдгийг л мэдэрлээ л дээ.

Тэгэхээр ганц 2 асуултад хариу авъя. Энэ нээлттэй нийгэм форумын хийсэн судалгаагаар өнгөрсөн 4 жилийн хугацаанд 120 гаруй хуулийг олон нийтийн хэлэлцүүлэг хийхгүйгээр баталсны 45 нь яаралтай горимоор батлагдсан байдаг. Өнгөрсөн намрын чуулганаар ч гэсэн Засгийн газар яаралтай горимоор гэж олон олон асуудлуудыг оруулж батлуулснаас харахад энэ байдал цаашид хэвээр байх шиг юм байна гэж ойлгогдож байна. Гэтэл одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа энэ Хууль тогтоомжийн тухай хуульд яаралтай өргөн мэдүүлэх хуулийн төсөлд Хууль зүйн яам дүгнэлт гаргана гэснээс өөр зохицуулалт харагдахгүй байна.

Иймд яаралтай гэсэн нэрийн доор Хууль тогтоомжийн тухай хуульд заасан энэ шаардлага хангахгүй буюу судалгаа, шинжилгээгүй, олон нийтийн оролцоог хангаагүй ийм хуулийн төсөл Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс сэргийлэх зорилгоор ямар шинэлэг зохицуулалтыг энэ хуулийн төсөлд оруулж тусгасан бэ?

Өөрөөр хэлбэл хуулийг яаралтай батлах үндэслэл, шаардлага, шалгуурыг тогтоосон зүйл байгаа юу? Хууль тогтоомжийг судалгаа шинжилгээ олон нийтийн хэлэлцүүлэлгүй, энэ батлан гаргах явдал бол ер нь их түгээмэл болоод байгаа юм.

Ер нь Монгол Улс нийгэм тэр аяараа хуулиар биш дүрмээр журмаар сүүлдээ бүүр стандартаар энэ зохицуулдаг ийм хэлбэрт шилжчихсэн байгааг энд нуугаад байх хэрэггүй. Энэ дагалдах хууль, гол хуулийг дагалдуулаад бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад тавигдах шаардлага баримт.

Б.Пүрэвдорж: Пүрэвийн Батчимэг гишүүнд нэмж минут өгье.

П.Батчимэг: Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад тавигдах шаардлага баримтлах журам тодорхойгүй байгаагаас үүдэн олон тооны хуулийг нэг зэрэг батлах, тухайн гол хуулийнхаа үзэл баримтлалаас хальсан асуудлыг дагалдах хуулиудаар зохицуулах ийм асуудлууд гараад байгаа юм. Энэ одоо жишээ нь Зөвшөөрлийн тухай хуулийг 2023 оны 1 дүгээр сарын 1-нд мөрдөж эхэлсэн.

Энэнтэй холбоотойгоор салбарын 90 гаруй хуулиудад гэнэт өөрчлөлт оруулж, олон нийт, бизнес эрхлэгчдийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэлгүйгээр баталсан нь одоо ч гэсэн бизнес эрхлэгчдийн бухимдлыг дагуулаад л байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг хуулийн төсөлд хэрхэн шийдвэрлэхээр тусгасан бэ? Энэ 2 асуултад хариу авъя аа. Хариулт авъя.

Б.Пүрэвдорж: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуултад хариулна.

О.Номинчимэг: Яаралтай горимын асуудал түрүүн гишүүдийн асуултад гарсан. Ер нь яаралтай хэлэлцэх горимын асуудал өргөн барих ямар үндэслэлээр өргөн барих вэ гэдэг асуудал энэ Хууль тогтоомжийн хуулиар биш Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар зохицуулагдсан байгаа.

Тэгэхээр бид нарын хувьд энэнтэй холбоотой Хууль тогтоомжийн хууль дээр хэрвээ яаралтай горимоор хууль тогтоомж өргөн барих гэж байгаа бол ямар шаардлага байх вэ л гэдэг энэ шаардлага нь хууль тогтоомжийн хуулийн хүрээнд байгаа. Тэгээд таны хэлсэн 19¹ дээр бол Хууль зүйн яам энэ дээр дүгнэлт гаргадаг. Дээр нь нэмээд түрүүн бас гишүүдийн асуултад гарсан хариултын дагуу нэн яаралтай горимоор өргөн барьж байгаа хуульд энэ хууль боловсруулахдаа тандан судалгаа, зардлын тооцоо, үр нөлөөний үнэлгээ, хэрэгжилтийн үнэлгээ, эд нар ерөөсөө хийхгүйгээр орж ирдэг байсан бол бид нар хэрэгцээ шаардлага тандан, судалгааг нь, дээр нь зардлын тооцооллыг нэн яаралтай горимоор өргөн барьж байгаа. Энэ хууль дээр заавал хийдэг бай гэсэн энэ шаардлагыг тавьж байгаа гэдгийг дахин хэлье.

Бусад тэр асуудалд Хууль зүйн яамнаас хариулчихъя.

Б.Пүрэвдорж: Нармандахын Жамъянхүү ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга. Индрийн 4 дүгээр микрофоноос хариулна.

Н.Жамъянхүү: Батчимэг гишүүний асуултад нэмж тодруулъя. 2024 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр бол энэ Улсын Их Хурлын дэгийн тухай хууль дээр орсон өөрчлөлт байгаа. Энүүгээр бол энэ Хууль тогтоомжийн хууль дээр ХЗДХ-ийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн бол нэн яаралтай горимын хуулийн төсөл дээр Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлага хангасан эсэх талаар дүгнэлт гаргаж өгөхөөр ингээд тусгасан байгаа. Тэгэхээр яг өнөө өнөөдөр бол энэ үндэсний аюулгүй байдал ялангуяа эдийн засгийн аюулгүй байдлын гол үндэслэлээр нэн яаралтай горимын хэлэлцэх эсэх асуудлыг бол дүгнэлт гаргахаар гол нь агуулгын хувьд байх ёстой.

Гэтэл одоогийн яг хууль дээрээ бол зөвхөн Хууль тогтоомжийн хуульд заасан тэр шаардлагыг хангаж байна уу гэдэг асуудлаар бол дүгнэлт гаргаж өгөхөөр бол хууль дээр байгаа. Төсөл дээр байгаа. Ингэхдээ бол одоо.

Б.Пүрэвдорж: Нэмж тодруулна.

Н.Жамъянхүү: Өмнө нь Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд орсон өөрчлөлт дээр бол тодорхой эшлэлүүдийг буруу авснаас болоод ийм асуудлууд нэлээн үргэлжилж явсан байдаг юм. Тэгэхээр өнөөдрийн нэмэлт оруулж байгаа хуулийн төсөл дээр ялангуяа энэ дэгийн тухай хуультай бол мөн Хууль тогтоомжийн хууль дээр энэ эшлэлүүдийг зөв засаж оруулсан ийм байгаад байгаа юм.

Б.Пүрэвдорж: Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууна аа. Үгүй уучлаарай Пүрэвийн Батчимэг гишүүн нэмж тодруулна.

П.Батчимэг: Яг л би уг нь тодорхой асуугаад байгаа юм л даа. Хууль зүйн яам тодорхой хариулаад өгөх үү.

Энэ яаралтай өргөн мэдүүлэх хуулийн төсөлд Хууль зүйн яам дүгнэлт гаргана гээд тиймээ. Тэрнээс өөр ямар нэгэн зохицуулалт байхгүй гэдэг талаар хүлээн зөвшөөрч байгаа юу?

Хоёрдугаарт хуулийг яаралтай батлах үндэслэл шаардлага энэ шалгуурыг яг тогтоож өгсөн юм уу л гэж асуугаад байгаа юм.

Б.Пүрэвдорж: Нармандахын Жамъянхүү. Индрийн 4 дүгээр микрофоноос.

Н.Жамъянхүү: Өнгөрсөн 2024 онд Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд өөрчлөлт орсноор бол ХЗДХЯ нэн яаралтай горимын хуулийн төсөл дээр дүгнэлт гаргадаг болсон байгаа. Ингэхдээ бол би одоо түрүүн бас хэлсэн. Зөвхөн хууль тогтоомжийн хуульд нөгөө яаралтай горимоор хэлэлцүүлэх гэж байгаа хуулийн төсөл маань Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг хангаж байна уу үгүй юу гэдэг дээр л дүгнэлт гаргаж өгдөг болсон.

Тэрнээс биш яг одоо нэн яаралтай горимоор хэлэлцүүлэх гол үндэслэл болсон үндэсний аюулгүй байдал тэр дундаа эдийн засгийн аюулгүй байдал дээр бол энэ дээр дүгнэлт гаргадаггүй байгаа.

Б.Пүрэвдорж: Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууна.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая аа. Парламентын засаглалтай хууль тогтоох эрх мэдэл нь гагцхүү Улсын Их Хуралдаа хадгалагддаг энэ тохиолдолд Хууль тогтоомжийн хууль яах аргагүй бид нарын барих ёстой хамгийн том хууль. Энэ хуулийн төсөл боловсруулах хуулийн хэрэгжилт үр дүнд үнэлгээ хийх аргачлал стандартыг тогтоож өгч байгаа ийм хууль аа.

Тийм учраас энэ хуулийг бид их олон талаас нь сайн харж хийдэлгүй гаргах тухай асуудал хамгийн чухал зүйл байгаа юм гэдгийг зориуд би нэг хэлчихмээр байна. Би одоо ерөнхий юм яримгүй байна. Ажлын хэсгийн боловсруулсан Байнгын хороо дэмжихсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол дээр 2, 3 санал хэлье.

Нэгдүгээр томъёолол буюу тэр 18.3 дээр Улсын Их Хурлын гишүүн хууль санаачилбал зардлын тооцоог нь хууль зүй төсвийн судалгааны чиглэлээр дагнан ажилладаг хүн хуулийн этгээд хийхээр бид хэд томъёолчихжээ. Тэгэхээр энэ бол хуулийн төслийн бүрдүүлэлтийн шалгуур үзүүлэлт болчхож байгаа учраас заавал хийлгэх болно. Энэ нь эргээд мэргэжлийн байгууллагуудаар заавал хийлгэхээр өртөгжилтийг бий болгож байна аа. Их Хурал өөртөө бүтэцтэй. Энэ бүтцийн байгууллага чинь яагаад энэ дүгнэлт юуг хийж болохгүй байна вэ? Уг нь зардлын тооцооны тухай ярьсан.

Гэтэл энэ томъёолол дотор хууль зүйн чиглэлээр дагнасан мэргэжлийн байгууллага гэж ороод байгаагийн утга учир нь юунд байгаа юм гэдэг нэг ийм асуудал байна.

Хоёр дахь зүйл тэр 3 дахь саналын томъёолол дээр буюу 29.5 дээр байгаа юм аа. Төсөв төсвийн тодотгол өргөн барихтай холбоотой асуудал байгаа юм.

Тэгэхээр энэнийг дагуулаад хуулийн төслүүд өргөн барьж болохоор бид хэд саналын томъёоллоо өргөтгөхөж. Уг нь бол нэг мөр хэрэгжиж байгаа хуулиуддаа нийцүүлж төсөв төсвийн тодотголоо боловсруулах ёстой. Нэг талаасаа харвал. Нөгөө талдаа хэрвээ бид нар тодорхой хуулиудад өөрчлөлт оруулж тэрүүнийг баримталж төсвөө боловсруулсан юм бол төсвийн орлого, зарлага тэнцэлд ямар нөлөө үзүүлж байгаа үнэлгээ бол тийм гол зүйл биш. Угаасаа тэрнийг чинь аваад энэ тооцооллыг хийчихсэн зүйл ээ.

Тэгэхээр энэний утга учир юунд байгаа юм гэдэг асуудал. Зүгээр би бол харахдаа төсөв, төсвийн тодотголыг дагуулж зөвхөн хууль хоорондын нийцэл хангах зорилгоор хуулийн өөрчлөлтийн төсөл л өргөн баригдах ёстой. Тэрнээс анхдагч гэдэг юм уу, шинэчилсэн найруулгын төслүүд өргөн баригдах боломжгүй ээ. Энийг бид хязгаарлаж өгөх ёстой. Өмнөх он жилүүдэд төсвийг дагуулж анхдагч хууль өргөн барьж байсан асуудал байдаг юм. Энүүнийг бид хязгаарлаж өгөх ёстой гэж ийм саналтай байна аа.

Гурав дахь санал. Та хэд тэр дагасан тогтоол дээр шинэ заалт оруулаад ирчихсэн байлаа. Хуулиар тусгайлан эрх олгогдоогүй бөгөөд нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр баталсан дүрэм журам, заавар, аргачлалыг хүчингүй болгох гэж. Үндсэн хуулийн 62-т хуулиар тусгайлан зохицуулаагүй дээд шатны байгууллагын эрх хэмжээнд хуулиар хамааруулчхаагүй асуудлыг нутгийн өөрөө удирдах

байгууллага өөрөө бие даан шийдвэрлэх боломжийг нь Үндсэн хуулиар заагаад өгчихсөн юм аа.

Нэмж нэг минут тодруулъя.

Ж.Батжаргал: Одоо энэ орон нутгийн эрх мэдэл рүү энэ заалтаар тогтоолын заалтаар дамжиж халдах нь ээ. Ядаж хаалт дотор нутгийн өөрөө удирдах байгууллагын хуульд зааснаас бусад энэ тэр гэж оруулахгүй энэ болохгүй нь. Одоо бэлэн жишээ бий. Нутгийн өөрөө удирдах байгууллага хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд газар нутгаа тусгай хэрэгцээнд гэдэг юм уу, тусгай хамгаалалтад авдаг. Гэтэл АМГТХЭГ кадастрын алба тэд хоногийн дотор ирүүлээгүй учраас танай тогтоолыг бүртгэхгүй гээд өнөө эрх бүхий байгууллагын гаргачихсан шийдвэрийг бүртгэдэггүй ийм бүдүүлэг алдаа гараад болж өгөхгүй байгаа байхгүй юу. Тэнд бол тэд нар үндэслэл юм хянах үндэс байхгүй. Гагцхүү бүртгэж авч зураглалдаа тэмдэглэл хийх тухай л асуудал бий.

Б.Пүрэвдорж: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуултад хариулъя.

О.Номинчимэг: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Эхний асуулт энэ хуулийн 18.3-тай холбоотой байгаа юм. Тэгэхээр яг таны хэлж байгаа яг энэ өгүүлбэр нь яах вэ саналын томьёолол нь ингээд орчихсон байгаа биз. Өгүүлбэрээр нь харах юм бол энд зардлын тооцоолол хийхдээ Улсын Их Хурлын гишүүн 1 дүгээрт Улсын Их Хурлын тамгын газраар хийлгэж болно. Эс үгүй бол өөрсдөд нь судалгаа сонголт өгөөд судалгааны эрдэм шинжилгээний байгууллага эсвэл энэ нөгөө дагнан ажилладаг ийм хүн хуулийн этгээдээр хийлгэж болно гэж байгаа юм.

Тэгэхээр таны хэлж байгаа гишүүдийн хувьд бол зардлын тооцооллоо Тамгын газраар хийх боломж нь бол энд байгаа шүү гэдгийг хэлмээр байна.

Хоёрдугаар асуудал төсөвтэй холбоотой асуудал байна.

Төсөвтэй холбоотой яг энэ таны зарчим буюу яг энэ төсөв дагуулж төсөвтэй холбоогүй шинэчилсэн найруулга оруулж ирэх асуудлыг хязгаарласан шинэчилсэн найруулга өөрийн тусдаа үзэл баримтлал танилцуулга, тооцоололтой хийгдэж орох ёстой. Бүтэц бүрэлдэхүүн Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний асуудал ч гэсэн Улсын Их Хурлын тухай хуулиараа энийг бол заавал тусдаа танилцуулгатай байхыг 2024 онд шинэ хууль гараад өөрчилчихсөн юм байна лээ. Тэгээд бид нарын энэ зарчим ер нь бид нар төсөв батлах гэж байгаа бол төсөвтөө нөлөөлж байгаа энэ л хуулиудаа дагуулж орж ир гэдэг л энэ зарчмыг бол оруулж энд хуулийн төсөлд бол оруулсан байгаа.

Гурав дахь асуулт болохоор орон нутгийн эрх хэмжээ гэж та хэлж байх шиг байна. Яах вэ энэ тогтоолын төслийг харах юм бол энэ ерөөсөө л энэ нөгөө Хууль тогтоомжийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа нэг амин сүнс нь энэ захиргааны хэм хэмжээний актыг бид нар хууль тогтоомжоор гүйцэтгэх засаглал руу өгөх гэж байгаа бол энэ шаардлагыг нь хүрээ хязгаарыг нь жоохон тодорхой болгож өгье өө гэдэг ийм асуудал байгаа. Тэгээд энэ энэ эмх замбараагүй гарч байгаа захиргааны хэм хэмжээний актыг жоохон цэгцэлье гэдэг л энэ зорилгын хүрээнд энэ хууль гарснаар захиргааны хэм хэмжээний акт буюу энэ Засгийн газарт үүрэг өгч байгаа захиргааны хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэх, Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр юм байгаа юм. Тэгээд таны хэлж

байгаа орон нутгийн энэ эрх ч гэсэн тусгай хэрэгцээнд авах эрх бол угаасаа тусгай Тусгай хамгаалалтын хууль, Тусгай хэрэгцээний хуулиар угаасаа орон нутагт ингээд өгчихсөн байдаг. Энэнийхээ дагуу авдаг хэм хэмжээний акт гаргадаг ийм бол эрх бүрэн эрх бол орон нутагт байгаа. Тэгээд энийгээ гол нь яг энэ нөгөө хэм хэмжээний дагуу байна уу? Зарим тохиолдлын судалгаагаар харахаар хууль тогтоомжоор бид нар захиргааны байгууллагад хэм хэмжээний акт гарга гээд ингээд үүрэг өгчихсөн байтал тэрийгээ ч гаргахгүй байгаа асуудлууд байгаа.

Тэгэхээр энэ л бүх юмаа цэгцлээч гэсэн чиглэл өгч байгаа Засгийн газар чиглэл өгч байгаа тогтоолын төсөл байгаа юм аа.

Б.Пүрэвдорж: Жигжидийн Батжаргал гишүүн нэмж тодруулъя.

Ж.Батжаргал: Тийм, хязгаарлалт өгч байгаа юм гээд 29.5 дээр яриад байгаа юм. Тухайн жилийн төсөвт нөлөө үзүүлэх хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлэх гэж та хэдийн томьёолол орж ирчхээд байгаа байхгүй юу. Тэгэхээр тэр дотор хууль тогтоолын төслийн гэдэг дотор бол ямар хууль байх вэ гэдэг асуудал заагдаагүй ээ.

Тийм учраас энд хязгаарлалт хийж өгөхөөс өөр арга байхгүй. Хууль хоорондын нийцэл хангах, хуулийн өөрчлөлтийн төсөл л өргөн баригдах ёстой. Энийг нэлээн онцгой анхаарч үзмээр байна. Ер нь уг үндсээр нь авч үзэх юм бол тодорхой хуульд захирагдаж юмаа боловсруулах байтал төсвөө боловсруулчихаад удирдлага болгох ёстой хуулиудаа дагуулж өргөн бариад байгаа явдал нь буруу байгаад байгаа байхгүй юу. Энийгээ бид энэ Хууль тогтоомжийн тухай хуулиараа засах ёстой юм гэж ингэж харагдаад байгаа юм.

Тэр тогтоол дээр бол эргэж харахаас өөр арга байхгүй. Энэ заалтаа тэр нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээ.

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асуух байсан. Цэцийн хуралд оролцож байгаад ирсэн учраас асуулт асууя.

П.Сайнзориг: Баярлалаа дарга аа. Яах вэ өргөн баригдсан хуулийн төсөл маш олон зүйлийн гацаа тээг болох байсан. Ажлын хэсэг ажиллаад тодорхой саналууд орж ирж байгаа. Тэгэхдээ л анхаарах хэдэн юмнууд байгаа. Би тэгээд протоколын хувьд үлдэг гээд 2, 3 зүйлийг асууя гэж бодож байна.

Нэгдүгээрт энэ ажлын хэсгээс буюу яг энэ мэргэжлийн яам нь нэг хариулаадхаач.

Өнөөдөр эрх олгосон заалтын дагуу нийт захиргааны хэмжээний актуудын тоо яг хэд байна вэ? Өнөөдөр ингээд олон нийтэд буруу мэдээлэл өгөөд байгаа байхгүй юу. Журмын тоо хэт ихэссэн гээд. Гэтэл журам гаргах энэ нөхцөл байдлыг Улсын Их Хурал өөрөө хийж өгөөд байгаа юм. Бид хэд Хог хаягдлын тухай хууль, Малын хөлийн албан татварын тухай хууль, Эрчим хүчний хуулиар жишээ нь зохицуулах хороо маш олон журмуудыг байгууллага байгууллагаар нь журам гаргах ёстой байдаг. Малын хөлийн татвар гэхэд 330 сум нэмэх нь 9 дүүрэг чинь тус тусдаа журам гаргах ёстой. Хог хаягдлын хууль мөн ялгаагүй. Энэ хэдийг ингээд хасчихаар чинь ерөнхийдөө цаана нь яг хэдэн журам үлдээд байна аа. Эрх олгосон заалтын хэчнээн нь Засгийн газар Ерөнхийлөгч буюу ХЗДХЯ-ны бүртгэдэггүй тийм журмууд

байна аа. Энэ зөрүүг аваачаад олон нийтэд мэдээлээд баахан журам бүртгэлгүй байгаа мэтээр ингээд олон нийтэд мэдээлэл өгөөд ийм яваад байгаа юм буруу байгаа.

Мэдээж энэ журмуудыг сайжруулах хуульд нийцүүлэх зарим журмаар зохицуулж байсан зүйлийг хуульд биежүүлэн тусгаж зохицуулах асуудлууд байх ёстой энийг ерөөсөө үгүйсгээгүй.

Энэ хууль дээр заавал ингэж шахсан шахаагүйг нь Улсын Их Хурлын гишүүд бид нарын өөрсдийнх нь хийх ажил байхгүй юу?

Нэгдүгээрт энэ зүйл дээр хариулаадхаач.

Хоёрдугаарт энэ 2 дугаар санал дээр ажлын хэсгийн дарга хариулах юм уу яах юм. Дараах асуудлаар захиргааны хэмжээний акт батлах эрх олгохгүй гэж байгаа юм. Энэ дээр нь юу байгаа вэ гэхээр Монгол Улсын Үндсэн хуульд гагцхүү хуулиар тогтоохоор заасан харилцаа гэж байгаа юм. Тэгээд Үндсэн хууль дээр чинь гагцхүүгээс гадна зөвхөн хуулиар тогтоох гэж үг байгаа, хуулиар зохицуулах гэж үг байгаа. Энэ 3 ялгаатай юу? Гагцхүү хуулиар зохицуулна гэххээд энийг дагаад журам гарахгүй юм байна гэж ойлголоо. Харьяатын хууль дээр байгаа Дүрвэгсдийн журмаас эхлээд маш ноцтой юмнууд энд яригдах нь дээ. Энийг тооцсон юм уу үгүй юу?

Хоёрдугаарт яг энэ гагцхүү хуулиар гэдгээсээ агуулгын хувьд зөвхөн хуулиар, хуулиар зохицуулна гэдэг энэ өөр үү? Магадгүй сонгуулийн харилцааг хуулиар зохицуулна гэххээд яг энэ агуулгын хүрээнд бас Сонгуулийн хууль тогтоомжийг дагасан энэ захиргааны хэмжээний актууд буюу энэ дүрэм журамд гарч чадахаа байгаад сонгуулиа хийж чадахаа байх юм биш биз дээ? Энэ дээр зүгээр протоколын хувьд хариулаадхаач. Хууль ёсны ашиг сонирхлын гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацааг журам гаргах юм уу. Хөөн хэлэлцэх хугацааг тусгачихсан байгаа журам хэд байгаа юм бэ, хариулаадхаач, тоог нь хэлээдхээч, тэр сайдын баталсан тийм журам байгаа юм гээд. Гомдол гаргах урьдчилан шийдвэрлэх ажиллагааны зарчим, хугацаа, оролцогчийн эрх үүргийг тогтоосон журам хэд байгаа юм хэлээдхээч.

Монгол Улсын дүрэм журмын дагуу хариуцлага оногдуулаад тийм торгох ялтай ийм эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа эсвэл ийм иргэний хариуцлага хүлээлгэж байгаа гээд дүрэм журам хэн сайд баталчхаад байгаа юм бэ? Ямар ч дүрэм журмаар зохицуулах боломжгүй буюу хуулиар угаасаа зохицуулдаг харилцаануудыг энд ингэж дурдаж дүрэм журам гаргахгүй гээд ингээд хэлбэрдэх хэрэг юу байгаа юм бэ? Энийг надад нэг хариулаад өгөөч.

Хоёрдугаарт би гишүүддээ нэг зүйлийг хэлэх гэж байгаа юм. Өргөн барьсны дараа маш олон судалгаануудыг Тамгын газрын ажилтнууд экспертүүдээр хийлгэж болно. Хүний эрхэд яаж нөлөөлж байна?

Эдийн засагт яаж нөлөөлөхөөр байна. Эерэг сөрөг үр дагавруудыг энэ төсөл дээр хийгээдхээч гээд. Одоо ч гэсэн тодорхой хэмжээнд хийж байгаа. Гэтэл энэ хуулийн төслөөр өргөн баригдах гэж байгаа төсөл дээр баахан шаардлагуудыг тавиад хэлэлцэх эсэхээ ч шийдээгүй байж байхад яг ингээд өргөн баригдахаасаа эхлээд гишүүдийн бүрэн эрхэд халдах гэж байгаа ийм асуудал байгаа.

Тэгэхээр гишүүд маань энийгээ хуулийн төслөө маш сайн уншиж яахгүй бол хууль санаачлах бүрэн эрх рүүгээ халдуулж болохгүй. Харин өргөн баригдах эсэхээ шийдээд ажлын хэсэг гараад Байнгын хороо, Улсын Их Хурал дээр чиглэл өгчихвөл маш олон судалгаануудыг нэмж хийлгэж болно. Маш олон дүгнэлтүүдийг нэмж хийлгэж болно.

Тэр асуудлыг Одсүрэнгийн Номинчимэг гишүүн хариулна.

О.Номинчимэг: Сайнзориг гишүүний асуултад хариулъя.

Би энэ ХЗДХЯ-аас захиалж хийсэн судалгааны тоо баримтыг дурдъя. 2023 оны ар 10 сарын байдлаар манай Монгол Улсад Хууль зүйн яаман дээр бүртгэлтэй Захиргааны хэм хэмжээний акт 2357 байгаа юм байна аа. Нийтдээ 413 хууль тогтоомжоор эрх олгосны хүрээнд ийм журам хэм хэмжээний акт гарсан юм байна. Энэ тоонд бол Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын баталсан шийдвэрийн тоо бол ороогүй байгаа. Тэгээд яах вэ эмзэглээд л байх шиг байна л даа. Зүгээр тооны харьцаагаа л бид нар харахаар 318 хуулиас бид нар эх авсан ийм 2493 захиргааны хэмжээний актаар нийгмийн харилцаагаа зохицуулж байгаа чинь энэ тэнцвэр нь алдагдсан байна гэдгээ бид нар харах ёстой байна аа. Бид нар заримдаа хэтэрхий хууль тогтоомжоороо хууль тогтоогчид ч гэсэн бланк буюу цагаан байдлаар захиргааны гүйцэтгэх засаглал руу хэм хэмжээ тогтоох энэ эрхээ шилжүүлээд байгаа. Эндээ хязгаар хийхгүй бол хэмжээний актаар санаатай санаагүй хүний эрх зөрчил гардаг, удааширдаг, авлига албан тушаалын асуудал гардаг ийм юм руу түлхээд байна л гэдэг судалгаа гарсан байгаа юм.

Дээрээс нь хуулиар тусгайлан эрх олгосон боловч 194 захиргааны байгууллагад шилжүүлсэн 850 шийдвэр захиргааны хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэл байхгүй байна гээд байгаа юм. Тэгээд энэ бүртгэл 805-ийг уг нь гаргах ёстой юм байна лээ. Тэгэхдээ хийгдээгүй байна. Энэ дээр судалгаа хийгээд энэ ялангуяа хөрөнгийн зах зээлтэй холбоотой ч юм уу юман дээр хууль журмаар зохицуулна гээд орхичихдог. Тэгээд нөгөө холбогдох байгууллагууд нь журмаа гаргадаггүй.

Ингээд харилцаа, эдийн засаг, бизнесийн харилцаа явах гэхээр журам гараагүй юм чинь бид нар ийм юм хийхгүй, бүртгэл хийхгүй гэдэг ийм асуудлууд гараад хүндрэл учирдаг гэсэн ийм судалгаанууд байгаа.

Хоёрдугаарт энэ захиргааны хэмжээний акт батлах эрх олгохгүй тухай та асуудлыг хөндөж байна. Үндсэн хуулиа бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Бид нар Үндсэн хуулиараа хүний эрх чөлөөг хязгаарлахдаа заавал энэ хуулиар байх ёстой. Хуулийн хүрээнд эндээс энэ шаардлагуудыг хангаж байж хийх ёстой гэдэг юм байгаа.

Үндсэн хуульд гагцхүү хуулиар тогтоохоор заасан хэдхэн юм байгаа. 18.2-ыг харах юм бол онцгой нөхцөл байдал буюу хүмүүсийн эд хөрөнгийг дайчилж байгаа дайны.

Б.Пүрэвдорж: Хэн билээ цолмон.

Шагдарсүрэнгийн Цолмон ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын хяналт бүртгэлийн хэлтсийн дарга 4 дүгээр микрофоноос хариулна.

Ш.Цолмон: Тийм тэгэхээр Сайнзориг гишүүний асуултад хариулъя.

Хоёр судалгааны тоон мэдээлэл өгсөн гэж ойлголоо. Нэгдүгээрх нь өнөөдрийн байдлаар захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй захиргааны хэм хэмжээний актын тоо хэд байгаа юм бэ гээд. Тэгэхээр өнөөдөр 2025 оны 6 сарын 10-ны байдлаар бид нар нэгдсэн санд бүртгэлтэй байгаа тоог гаргаж үзсэн. Иймд 2838 шийдвэр бүртгэлтэй байна гэж байгаа юм. Гэхдээ үүний 904 шийдвэр нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын шийдвэр. Өөрөөр хэлэх юм бол нөгөө Хог хаягдлын тухай хууль, Малын тоо толгой, албан татварын хууль, Газрын тухай хууль гэсэн ийм 3 хуулийн эрх олгосон заалтаар 904 шийдвэр бүртгэлтэй байна гэсэн үг. Түүнчлэн эрчим хүчний тухай хууль дээр нөгөө эрчим хүчний зохицуулах хороо, аймаг, нийслэлийн салбар зөвлөл бас тариф батлах ийм эрх олгосон нэг заалтын тоогоор 305 шийдвэр, тэгээд Хот суурины ус хангах татуургын ашиглалтын тухай хуулийн бас нэг заалтаар 131 гээд ингээд 2838 шийдвэрийн мянга.

Б.Пүрэвдорж: Нэмж хариулъя. Чухал мэдээлэл байна. Шийдвэрийн 1450 буюу бараг 50 орчим хувь нь 5 хуулийн заалтаар бүртгэлтэй байгаа шийдвэр гэсэн үг ээ.

Дараагийн тоо нь болохоороо нөгөө хуулиар тусгайлан эрх олгосон заалтын судалгааны тоог өссөн гэж ойлгосон. Энийг 2023 оны 11 сарын 15-ны байдлаар Хууль зүйн яамнаас тусгайлан эрх олгосон заалтын судалгаа гаргаж өгсөн байгаа.

Энэ дээр яг эрх олгосон хууль бол 315. Үүний хуулиар эрх шилжүүлэх заалт олгосон 2403 хууль байна гэж тухайн үеийн судалгаагаар гарсан байгаа. Гэхдээ үүн дотор нөгөө тухайлах юм бол Засгийн газар холбогдох Их Хурлын Байнгын хороо Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан иймэрхүү олгосон заалтууд тоологдсон байгаа. Тухайлах юм бол үүний 642 эрх олгосон заалт Засгийн газарт байна гэсэн ийм тоо байгаа.

Б.Пүрэвдорж: Үгэн дээрээ тодруулчих. Соронзонболд гишүүн асуулт асууя.

Л.Соронзонболд: Энэ 27-гийн штрих 2.1 дээр Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх эрх чөлөөг хуулиар тогтоосноос гадуур хязгаарлах гээд хариуцлага оногдуулах гээд тэгсэн байна. Энэ Үндсэн хуульд гадуур хязгаарлана гэдэг нь ямар ойлголтын асуудал яригдаад байна вэ гэдэг ийм асуулт байна.

Б.Пүрэвдорж: Гишүүд өглөө хуралдааны цагийг товлосон хугацаа хэтэрсэн байна. Нэг цагаар хуралдааныг уртасгах саналтай байна.

Ингээд асуултад Одсүрэнгийн Номинчимэг гишүүн хариулна.

О.Номинчимэг: Монгол Улсын Үндсэн хуульд хүний эрх чөлөөг бол хуулиар л хязгаарлахаар заасан байгаа. Тэгээд энэ нь бол тодорхой. үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, нийгмийн хэв журмыг хамгаалах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд хуулиар тодорхой хязгаарлалтыг хийж болно л гэсэн юм байгаа. Тэгээд энэ маань өөрөө энэ хүний эрх чөлөөний хязгаарлалт бол арга хэмжээнд тохирсон байх ёстой. Зорилгодоо нийцсэн байх ёстой. Тэгээд боломжит бага хамгийн бага түвшинд байх ёстой гэдэг энэ олон улсын гэрээ конвенцын хэм

хэмжээнүүд үйлчилдэг юм. Тэгэхээр бид нар яах вэ хууль тогтоомжоор бол мэдээж хүний эрх чөлөөг, хэрвээ хүний эрх чөлөөг хязгаарлах гэж байгаа бол заавал хууль тогтоомжоор байх ёстой. Энийгээ ихийг нь хийх ёстой. Энэнээс гадуур энд өгсөн, хэм хэмжээ, хязгаарын хүрээнээс гадуураар захиргааны хэм хэмжээний актаар тэр тухайн хүний эрх эрх чөлөөг бол хязгаарлаж болохгүй л гэсэн санаа байгаа юм аа.

Яах вэ жишээ бас хэлж болж байна. Энэ судалгаануудыг хараад байхаар их сонирхолтой юм байна лээ. Төрийн албан хаагчийн тэтгэвэртээ гарахаар 36 сарын цалин авдаг нэг ийм юу байгаа журам байгаа. Тэгээд энийг ингээд уг нь бол төрийн албанд тогтвортой ажиллуулах мэргэжлийн боловсон хүчнээ бэлдэх гээд олон ач холбогдолтой ийм журам. Тэгтэл энийгээ Засгийн газраас энэ журмаа батлахдаа сүүлийн тэдэн жил тогтвортой ажилласан сүүлийн тэдэн жил НДШ төлсөн гэдэг нэмэлт ийм шаардлага тавьчихаж байгаа юм. Тэгэхээр ямар нэгэн байдлаар төрийн албан хаагч жинхэнэ албан хаагч юу гэдэг юм улс төрийн нөлөөгөөр ч юм уу ингээд чөлөөлөгддөг халагддаг, буцаад орж ирдэг, энд нь нийгмийн даатгал төлөөгүй гээд зай гарах юм бол нөгөө 36 сарынхаа тэтгэмжийг авч болохгүй ийм нөхцөл байдал үүсгэдэг. Тэгээд энэ маань өөрөө энэ Засгийн газраас гаргаж байгаа энэ журам маань энэ төрийн албан хаагчдын энэ эрхээ эдлэх хязгаарлалт болж байна. Ийм зүйлүүдийг анхаараач гэдэг ийм нарийн нарийн ийм зохицуулалтууд журам дээр гар гардаг аа.

Энэ бол ер нь манай Үндсэн хуулийн зарчим. Энийгээ л бид нар тодорхойлж энэ хууль тогтоомжийн хууль дээр оруулж өгч байгаа гэдгийг хэлмээр байна.

Б.Пүрэвдорж: Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд үг хэлнэ.

Пүрэвжавын Сайнзориг гишүүн. Индрийн 1 дүгээр микрофон дээр урьж байна. Уучлаарай анхны хэлэлцүүлэг учраас суудлаасаа хэлэх юм байна шүү?

П.Сайнзориг: Баярлалаа. Яах вэ тэгээд би уг нь энэ Хууль тогтоомжийн хууль бол rule off law буюу хуульд ёсыг бэхжүүлэх эрх зүйн тогтолцоо системтэйгээ эрх зүйн тогтолцоогоо зөв авч явах энийг тогтвортой байлгах энэ нөхцөл байдлыг уг нь бүрдүүлэхэд хамгийн чухал суурь хууль байгаад байгаа юм. Тэгээд энэ зарчим яах вэ зүгээр ийм ойчин цойчин байдлаар алдагдах гээд байгаад жоохон харамсаж байгаа юм. Ер нь бол яах вэ зүгээр Цогтбаатар нарын гишүүдийн өргөн барьсан хуулийн гол агуулгын үзэл санаа бол бас зайлшгүй яригдах байгууллага болоод байгаа юм.

Хөрөнгө оруулалтын тухай хууль гэж байсан юм. Гадаадын хөрөнгө оруулалтыг. Тэрийг 66 хувиар батлах ёстой. Нэмэлт, өөрчлөлт оруулах ёстой гээд. Энэ уг нь эрх зүйн хамгаалалтыг батлах квотоор нь ингээд хамгаалдаг оролдлогыг манай хууль тогтоох байгууллагаас хийж байсан боловч Цэц дээр унасан юм. Тэгэхээр энэ бүх зүйлүүдийн ард юу яригдах гээд байна гэхээр хуулийн төрөл ангиллын болоод түүнийг батлах квотыг хуулиар зохицуулна гээд Үндсэн хуульд уг нь суурь зарчмаа тусгаж өгөөд хууль тогтоомжийн хуулиараа явбал маш олон зүйлүүдийг ангиллаасаа гадна жишээ нь кодекс гэдэг бусад орны хууль дээр криминал код ч юм уу, сивил код гэх юм бол энийг дагаж дүрэм журам гардаггүй хуулийг хэлдэг байхгүй юу. Кодекс гэхээр угаасаа нэршлийн хувьд энийг дүрэм журам эрх олгосон заалт тусгаж болохгүй хууль юм байна гэж ойлгодог. Тэгээд

магадгүй органик хууль гэдэг тэр тодотголтой байх юм бол тэр хуулийг парламентад сонгогдсон гишүүдийн 66 хувиар бүр хамгаалдаг.

Одоо жишээ нь Төрийн албаны хууль байж болно, Шүүхийн тухай хууль байж болно, Сонгуулийн хууль байж болно. Хэн нэг улс төрийн хүчин дангаараа өөрчлөх бололцоогүй консенсус хийдэг. Тэгэхээр энэ бүх зүйлүүдийг хийх асуудлыг цаашдаа судалж хийхгүй бол ингэж хууль санаачлах эрхийг хязгаарлаад ерөөсөө юм явахгүй. Улсын Их Хурал асуудлыг ч тал талаас нь хэлэлцээд шийдэх гэж л байгаа. Заавал өргөн барина гэдэг чинь батална гэсэн үг биш байхгүй юу. Буцааж болно батлахгүй байж болно. Тэгэхдээ энийгээ мэдээж үндэслэлтэй боловсруулж ирэх нь зүй ёсны шаардлага.

Тэгэхээр энийг бид нар ингээд ултай суурьтай авч үзэхгүй бол бүх зүйлүүд ингээд системийн хувьд эвдрэх гэж байна гэдэг зүйлийг хэлмээр байгаа юм.

Тэгэхээр энийг цаашдаа зүгээр би протоколын хувьд үлдээе. Тэгээд энэ хураах гэж байгаа санал болгон дээр гишүүдийг дэмжсэн дэмжээгүйгээ хэлэхдээ анхаараасай. Жишээ нь одоо би Энхтүвшин гишүүн гишүүний энэ эхний саналыг бол зүгээр ингээд ойлгоод байгаа юм л даа. Гэтэл дахиад ийм хүнд процесс руу оруулах гэж байна. Анх хууль санаачлагч буюу Цогтбаатар нарын гишүүний өргөн барьсан хууль дээр судалгаа, шинжилгээний байгууллагыг судлаач ч юм уу судалгааны байгууллагаар хий гэсэн чинь санал гаргасан гишүүн маань юу хийх гэж байна гэхээр хууль зүй болон төсвийн судалгааны чиглэлд дагнан ажилладаг хүн хуулийн этгээд иржээ. Дагнан ажилладаг гэдгийг хэн тодорхойлох юм? Дагнан ажиллаагүй хүнээр хийлгэсэн байна гээд энийг чинь авахгүй юм уу өргүүлэхгүй юм уу? Дагнан ажилладаг гэдгийг хэн тодорхойлоод ямар байгууллагыг дагнан ажилладаг гэж хэлэх гээд байгаа юм?

Тэгэхээр энэ ингээд ерөөсөө энэ хуулийг зүгээр яах вэ нэг л болж өгөхгүй байгаа юм аа. Тэгээд намайг ингээд шүүмжлэхээр хувийн сэдлээр яагаад микрофон хааж байгаад чи шинэ сонгогдсон энэ тэр гэдэг байдлаар ингээд дарамталж байна. Урд хойдын удирдлагууд руу утасдаж хэлүүлж байна. Иймэрхүү байдалтай хууль санаачлагч хүмүүс байх юм бол бас болохгүй ээ. Тэгэхээр би зүгээр ингээд хэлэх гээд байгаа нь энэ хураах гэж байгаа санал болгон дээр болгоомжтой байхгүй жишээ нь одоо нөгөө төсвийн зардлыг чинь уг нь мэргэжлийн байгууллагаар хийе гээд ингээд хууль санаачлагчид маань ороод ирсэн чинь бүр сүүлдээ дагнадаг гээд. Дагнадгийг нь хэн тодорхойлох нь ч ойлгомжгүй байдлаар одоо ингээд бид нар хураах гэж байгаа байхгүй юу. Тэгээд энэ бүх зүйлүүд чинь ийм ойлгомжгүй юм руу явах гэж байна аа.

Тэгээд энэ дээрээ гишүүд маань анхаараач л гэдэг зүйлийг хэлж байгаа. Би энэ дээр та бүгдийн Үндсэн хуульд заасан хууль санаачлах эрхийг чинь хэрэгжүүлэхтэй холбоотой хууль шүү. Энэ зүйл дээр чинь зүй бус гэдэг юм уу сүүлдээ хүмүүсийн хооронд үл ойлголцох тийм шаардлагууд тавигдаад явчих вий дээ л гэж л болгоомжлолын үүднээс л яриад хэлээд байгаа юм. Тэгэхээр энийг анхаараач гэдэг зүйлийг л гишүүддээ хэлмээр байна аа.

Б.Пүрэвдорж: Дэгээрээ болохгүй. Тэгэхээр Цогтбаатар дарга хууль санаачлагчийнхаа хувьд үг хэлье.

Д.Цогтбаатар: Үгүй үгүй. Тэгэхдээ энэ чинь би нэг юм хэлмээр байна. Би ерөөсөө аливаа нэгэн удирдлага юм руу хэзээ ч яриагүй. Шинэ гишүүн гэж хэнийг ч хэзээ ч би ялгаварлан гадуурхаж байгаагүй. Яривал би логиктой мэтгэлцээн л явуулж байснаас сөрж өөрийнхөө байр суурийг хэлэх эрх аль ч гишүүнд байгаа. Түүнээс энэ одоо энэ чинь ноцтой юм ярьж байна шүү дээ. Гишүүн рүү халдаад эс үгүй бол ард нь урд хойно нь ажиллаж байсан дарга нар нь тэр нэрсээ хэл. Хэн тэгж хэлүүлсэн байна. Тэгвэл тэрийгээ ярихгүй бол болохгүй шүү.

Б.Пүрэвдорж: Чуулганы дэгийн тухай хуулийн 10.12 дугаар заалтын дагуу зарчмын зөрүүтэй санал болон санал хураалтыг дараагийн чуулган хүртэл хойшлууллаа.

Өнөөдөр Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл хуралдаж тэтгэврийн зээлийн асуудлаар шийдвэр гаргасан байгаа. Яг цаас нь одоогоор албажиж гараагүй байна. Тэгэхээр тэтгэврээс ер нь бол 50, 50-ийн харьцаатайгаар зээл гаргахаар болсон байна. Тэр нь нэг ойролцоогоор 3 зуугаад мянган төгрөг ахмадууд дээр очих юм байна.

Тэгээд зээлээ төлөөд шинээр зээл авахаар нөгөө зээл төлдөг мөнгө хүүлэгч нарын аманд очно гэсэн үг.

Дахиад шимтгэл төлөх ийм шаардлага гарч ирнэ. Тэгээд хугацааг банкнууд шийдэхээр өчигдөр нэлээн өндөр настай ахмадуудад бүүр зээл өгөхгүй байх ийм нөхцөл байдал руу очиж байна. Тэгээд 8 саяын зээлтэй хүн зээлээ төлөөд тэгээд буцаагаад 30 сараар 50, 50-ийн харьцаагаар авлаа гэхэд 1 сая төгрөг л гар дээр нь үлдэх нь. Тэгээд 1 сая төгрөгөөсөө нөгөө нэг зээлийнхээ хүүг төлөөд явахаар юу ч үгүй үлдэх ийм нөхцөл байдал руу очиж байна.

Тийм учраас энэ одоо Монголбанк улирал болгон хуралддаг. Тэгэхдээ шаардлагатай тохиолдолд л Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл хуралдаж болох ийм заалттай. Тийм учраас манай ахмадууд тэр банкан дээр очоод яг энэ гаргасан шийдвэрийн дагуу ямар ямар хүндрэл гарч байна гэдгийг мэдэх хэрэгтэй. Би тэр цаад шийдвэрийг нь аваад харъя. Тэгээд Монголбанк арилжааны банкууд хэтэрхий их мөнгө хөөж болохгүй. Амьд бурхад болсон ахмадууддаа ингэж хатуу хандаж болохгүй гэдгийг хэлье.

Өнөөдрийн чуулганы хуралдаан хаасныг мэдэгдье.

13.22 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА